




МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2011

1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	7
1.1 Дотоод эрэлт	7
1.2 Үйлдвэрлэл	20
1.3 Гадаад сектор	26
1.4 Хөрөнгийн зах зээлийн хөгжил	49
2. МӨНГӨНИЙ БОДЛОГО	51
2.1 Мөнгөний бодлогын зорилт, хэрэгжилт	51
3. ВАЛЮТЫН ХАНШИЙН БОДЛОГО	55
3.1 Валютын ханшийн бодлого	55
3.2 Улсын валютын нөөцийн удирдлага	58
4. БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ	61
4.1 Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд	61
4.2 Банкны салбарын хөрөнгө болон эх үүсвэрийн бүтэц	63
4.3 Банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд	65
4.4 Банкны хяналт шалгалт	67
5. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ	71
6. ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ	73
6.1 Төлбөр тооцооны систем	73
6.2 Банк хоорондын төлбөр тооцоо	73
6.3 Төлбөрийн карт	74
7. ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА	77
8. МОНГОЛБАНКНААС 2011 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ	83
9. АУДИТОРЫН ТАЙЛАН	85
10. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД	153

МОНГОЛБАНКНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ



Эрхэмсэг хатагтай, ноёд оо!

Монголбанк 2011 онд инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх, эдийн засгийн хямралыг сөрөх чадавхийг бий болгох замаар дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах үндсэн зорилт тавьж ажиллав.

Монгол Улсын эдийн засаг 2011 онд 17.3 хувиар өсч өмнө байгаагүй өндөр үзүүлэлттэй гарлаа. Ийм өсөлтийн суурь нь нийт эрэлтийн эрчимтэй өсөлт болж байна. Уул уурхайн томоохон ордуудыг ашиглаж эхэлснээр Монгол Улсыг чиглэсэн санхүүгийн хөрөнгийн урсгал нэмэгдлээ.

Оны эхнээс тасралтгүй өсч буй эрэлтээс үүдсэн инфляцийг хязгаарлахын тулд Монголбанк мөнгөний бодлогоо чангаруулан бодлогын хүүг 3 удаа, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 удаа тус тус өсгөв. Мөнгөний бодлогын эдгээр арга хэмжээг авснаар 2011 оны эцэст жилийн инфляци Улаанбаатар хотод 11.1 хувьтай, улсын хэмжээнд 10.2 хувьтай гарав.

Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн секторт банкны салбарын гүйцэтгэх үүрэг жин дарсан хэвээр байна. Тухайлбал эдийн засаг дахь нийт хадгаламж, харилцахын 99.4 хувь, олгосон зээлийн 99.2 хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байна. 2011 онд ДНБ ийнхүү хурдацтай өсөхөд банкны сектор үлэмж хувь нэмэр оруулсаар ирлээ. Банкны зээлийн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 2010 онд 38.8 хувь байсан бол, 2011 онд 52.1 хувь болон өсчээ. Зээл 2010 онд 23 хувиар өссөн бол 2011 онд даруй 72.8 хувиар өссөн байна. Үүний дотор жижиг дунд үйлдвэрлэлийн зээл 2011 онд 66.8 хувиар, ипотекийн зээл 95.8 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Монголбанк мөнгөний бодлогын мөчлөг сөрсөн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх үүднээс банкны салбарын эрсдэл, эдийн засгийн мөчлөгийг тогтмол тооцоолж, тухайн нөхцөл байдалд тулгуурлан макро зохистой харьцааны арга хэрэгслүүдийг оновчтой тодорхойлж ажиллахад гол анхаарлаа чиглүүлж байна.

Монголбанк төлбөрийн системийг хөгжүүлэх, бэлэн бус төлбөр тооцоог дэмжихэд анхаарч, банк хоорондын их дүнтэй төлбөрийн систем, “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-г шинээр нэвтрүүлж, холбогдох эрх зүйн баримт бичиг, журам, зааврыг шинэчлэн мөрдүүлээд байна.

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан эрдэс, түүхий эдийн үнэ буурах, гадаад валютын дотогшлох урсгал саарах эсвэл эргэж гадагшлах эрсдэл хадгалагдсаар байна. Хөрөнгийн дотогшлох урсгал өндөртэй, эдийн засаг нь хурдацтайгаар тэлж

буй манай улсын хувьд макро зохистой бодлогыг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна. Энэхүү бодлогын гол цөм нь эдийн засгийн мөчлөг сөрсөн, харилцан уялдсан макро бодлогын хослол, цогц юм. Цаашид төсвийн зохистой бодлогод шилжиж мөнгөний бодлогыг сулруулан инфляцийн дарамтгүй эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хувийн хэвшлийг бүх талаар дэмжих нь Монгол улсын Засгийн газар, Монголбанкны өмнө тулгамдсан зорилт болохоор байна.




Л.Пүрэвдорж
Монголбанкны Ерөнхийлөгч

1.1 Дотоод эрэлт

Нийт эрэлт

Эдийн засгийн хямралаас үүдэн Монгол улсын эдийн засаг 2009 онд 1.3 хувиар хумигдсан бол 2010 онд 6.5 хувь, 2011 онд 17.3 хувиар тэлсэн үзүүлэлттэй байлаа. Хувийн хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал харгалзан 13.3 хувь, 69.9 хувиар өссөн нь 2011 оны эдийн засгийн тэлэлтийн үндэс болж байна. Эдийн засгийн өсөлтөд эцсийн хэрэглээ голлох хувь эзэлж байсан бол 2010 оноос хуримтлалын хувь өндөр жин эзлэх болсон. Энэ нь гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн, тэр нь үндсэн хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлсэнтэй холбоотой юм.



Зураг 1


Эдийн засгийн өсөлт,
өсөлтийн задаргаа /
эрэлтийн талаас/

Эх үүсвэр: УСХ *урьдчилсан байдлаар

Хувийн хэрэглээ

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр эцсийн хэрэглээ 2011 онд 13.3 хувиар өссөн бөгөөд эцсийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувь 79.8 байна. Харин сүүлийн таван жилийн дундаж дүнгээр нийт хэрэглээний 78.9 хувь буюу ихэнх хувийг хувийн хэрэглээ эзэлсэн хэвээр байна. Хувийн хэрэглээ сүүлийн таван жилд дунджаар 12.2 хувиар өссөн ба 2011 онд 13.3 хувь болж өмнөх оноос 2.3 нэгж хувиар нэмэгджээ. Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 42.1 хувиар өссөн, бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 1.6 дахин өссөн зэрэг нь 2011 онд хувийн хэрэглээний өсөлтийг бататгах үзүүлэлтүүд болж байна.

Зураг 2

Хувийн хэрэглээ,
ДНБ-ий өсөлт

Эх үүсвэр: УСХ *урьдчилсан байдлаар

Цэвэр экспорт

Уул уурхайн салбарын тэлэлттэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд нийт экспортын хэмжээ нэмэгдэж дотоод эдийн засаг идэвхижсэн боловч үүнтэй зэрэгцэн уул уурхай, барилга, худалдаа үйлчилгээний салбарын эрчимтэй өсөлт тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний барааны импортыг нэмэгдүүллээ. Жишээ нь авто машины импорт 2009 онд 11658 ширхэг, 2010 онд 26378 ширхэг байсан бол 2011 онд 56210 ширхэг болсон буюу тоон дүнгээр 2010 оныхоос 2.1 дахин, үнийн дүнгээр 2.7 дахин өсчээ. Түүнчлэн өргөгч, ачигч, буулгагч зэрэг тоног төхөөрөмжийн импортын тоо хэмжээ 10.1, бульдозерь зэрэг зам барих ажлын тоног төхөөрөмж 2.5, ачааны машины импорт 2 дахин ихэсчээ.

Зураг 3:

Худалдааны тэнцэл



Эх үүсвэр: УСХ *урьдчилсан байдлаар

Засгийн газрын санхүү

Монгол улсын нийт тэнцвэржүүлсэн төсвийн орлого, тусламжийн дүн 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4159.6 тэрбум төгрөг (ДНБ-ий 38.2 хувь), нийт зарлага, цэвэр зээлийн дүн 4792.0 тэрбум төгрөг (ДНБ-ий 44.0 хувь) болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 632.4 тэрбум төгрөгийн алдагдалтай, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 906.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн орлого

Нийт орлого, тусламжийн дүн 4159.6 тэрбум төгрөг хүрч төлөвлөсөн хэмжээнээс 2.9 хувь буюу 118.3 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 33.2 хувь буюу 1037.1 төгрөгөөр их байна. Төсвийн нийт орлого, тусламжийн 99.6 хувийг бүрдүүлдэг урсгал орлого өмнөх оны мөн үеэс 34.5 хувь буюу 1063.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нийт орлого, тусламжийн дүн өсөхөд голлон нөлөөлөв. Урсгал орлогын 87.8 хувийг бүрдүүлсэн татварын орлого өмнөх оны мөн үеэс 35.3 хувь буюу 948.6 тэрбум төгрөгөөр өссөн нь аж ахуйн нэгжийн албан татвар 154.5 тэрбум төгрөг, хүн амын орлогын албан татвар 69.7 тэрбум төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Харин зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар 7.6 дахин буюу 367.3 тэрбум төгрөгөөр буурсан. Татварын бус орлого (урсгал орлогын 12.2%) өмнөх оны мөн үеэс 29.3 хувь буюу 114.3 тэрбум төгрөгөөр өссөн нь төсөвт газрын өөрийн орлого (татварын бус орлогын 36.7%) 13.5 хувь буюу 22.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1: 2011 оны улсын нэгдсэн төсвийн орлого /тэрбум төгрөгөөр/

Төсвийн орлого	Өмнөх оны мөн үеийн	2011 оны урьдчилсан гүйцэтгэл		Жилийн өөрчлөлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	3,122.5	4,041.3	4,159.6	33.2
Урсгал орлого	3,078.3	4,018.3	4,141.3	34.5
Татварын орлого	2,688.2	3,556.6	3,636.9	35.3
Орлогын албан татвар	975.0	808.8	831.8	(14.7)
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	331.3	383.8	450.4	35.9
Өмчийн татвар	13.8	14.4	16.9	22.5
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	865.3	15,540.2	1,428.6	65.1
Гадаад худалдааны орлого	193.3	351.2	337.4	74.5
Бусад татвар	309.5	548.2	571.7	84.7
Татварын бус орлого	390.1	461.7	504.4	29.3
Хөрөнгийн орлого	5.7	14.4	16.8	194.7
Тусламжийн орлого	38.5	8.6	1.5	(96.1)

Эх үүсвэр: УСХ *урьдчилсан байдлаар

Төсвийн зарлага

Нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээлийн дүн төлөвлөсөн хэмжээнээс 5.2 хувь буюу 264.8 тэрбум төгрөгөөр бага, өмнөх оны мөн үеэс 55.6 хувь буюу 1711.3 тэрбум төгрөгөөр өсч 4792.0 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт төсвийн зарлага ба цэвэр зээлийн 67.5 хувийг бүрдүүлсэн урсгал зардал 43.3 хувь буюу 977.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал (нийт төсвийн зарлагын 22.3%) 80.7 хувь буюу 476.5 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээл (төсвийн зарлагын 10.2%) 2.1 дахин буюу 257.1 тэрбум төгрөгөөр өссөн нь төсвийн зарлага, цэвэр зээлийн дүнг нэмэгдүүллээ. Халамжийн сангаас халамжийн тэтгэвэр, тэтгэмж, алдар цолтой ахмад дайчдад олгох хөнгөлөлт, жирэмсэн эхчүүдэд алдарт эхийн одонгийн олгох санхүүжилтэнд 130.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 2: 2011 оны улсын нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөгөөр/


Төсвийн зарлага	2010	2011		Хувийн жин	2011/2010 (гүйц), %
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Нийт зарлага ба цэвэр зээл	3,080.7	5,056.8	4,792.0	100	55.6
Урсгал зардал	2,256.7	3,337.0	3,234.4	67.5	43.3
Бараа ба үйлчилгээний зардал	1,166.7	1,557.8	1,528.1	47.2	31.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	42.3	38.2	37.3	1.2	(11.8)
Татаас ба урсгал шилжүүлэг	1,047.6	1,741.1	1,669.0	51.6	59.3
Хөрөнгийн зардал	590.7	1,254.2	1,067.2	22.3	80.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	233.4	465.6	490.5	10.2	110.2
Тэнцэржүүлсэн урсгал тэнцэл	821.6	681.3	906.9		10.4
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	41.8	-1,015.5	-632.4		

Эх үүсвэр: УСХ *урьдчилсан байдлаар

Үнэ

Хэрэглээний үнийн индекс 2011 онд 9.4 хувиар өслөө. Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлтийг бүлгээр нь авч үзвэл тээврийн бүлгийн бараа, үйлчилгээний үнэ 12.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 18.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 14.4 хувь, хүнсний барааных 7.6 хувь, боловсролын үйлчилгээнийх 7.5 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр өсөлттэй байлаа. Хэрэглээний үнийн индекс өнгөрсөн оны мөн үеэс 9.4 хувиар өсөхөд 24.4 хувийг хүнсний барааны, 23.8 хувийг хувцас, бөс бараа, гутлын, 17.0 хувийг тээврийн бүлгийн бараа, үйлчилгээний, 21.5 хувийг орон сууц, ус цахилгаан, түлшний үнийн өсөлт тус тус бүрдүүлжээ.

Махны үнэ буурснаас шалтгаалан хэрэглээний үнийн индекс 3, 4 дүгээр саруудад буурч, харин бусад саруудад өсчээ. 5, 6 дугаар саруудад инфляци хамгийн өндөр байсан бөгөөд тухайн үед ОХУ-аас нийлүүлж буй түлшний хэмжээ буурсны улмаас дизель, бензиний үнэ 11.1-17.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.



Хувьсгал	2010 он	2011 он
Хүнсний бараа, ундаа, ус	62	24
Хувцас, бөс бараа, гутал	10	24
Орон сууц, ус, цах илгаан, түлш	10	22
Тээвэр	1	18
Боловсролын үйлчилгээ	8	5
Бусад	9	8

Зураг 5

УБ хотын жилийн
инфляцийн задаргаа

Эх үүсвэр: YCX

МОНГОЛБАНК ЖИЛИЙН ТАЙЛАН 2011 11


Шигтгээ 1: Монгол улсын нийгэм, эдийн засаг, банк санхүүгийн салбарын талаарх түүвэр судалгаа

Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал:

Монголбанк “Монгол улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, банк санхүүгийн үйл ажиллагаа”-ны талаар 2011 оны 9 дүгээр сард олон нийтийн дунд долоо дахь жилдээ санал асуулга явууллаа. Түүвэр судалгааны үр дүнгээр эдийн засгийн байдал сайжирч байна гэж үзэх иргэдийн хандлага нэмэгдэж, хямралын өмнөх үеийн түвшинд хүрлээ. Хэдийгээр эдийн засгийн байдал сайжирч байна гэж иргэд үзэж байгаа ч өнөөдрийн эдийн засгийн өндөр өсөлт иргэдийн 40 орчим хувьд сөргөөр, 20 гаруй хувьд ямар нэгэн нөлөө үзүүлдэггүй гэсэн дүн гарлаа. Иргэдийн дийлэнх хувь нь өргөн хэрэглээний барааны үнэ өсч, эдийн засагт бүрэлдэж буй баялаг тэгш хуваарилагдахгүй байна гэсэн хариултыг өгсөн нь эдийн засгийн өндөр өсөлт иргэдэд төдийлөн хүрэхгүй байгаагийн зэрэгцээ ядуу болон дунджаас доогуур орлоготой иргэдийн амьжиргаанд хүндээр тусч байгаа нь манай судалгааны дүнгээр харагдсан юм.

Зураг 6


Монгол улсын эдийн засгийн байдал (санал асуулгад оролцогчдын хариулсан хувь)



Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн

Зураг 7

Эдийн засгийн баялгын хуваарилалт (санал асуулгад оролцогчдын хариулсан хувь)



Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн


Иргэдийн талаас илүү нь **ойрын ирээдүйд** манай улсын эдийн засгийг уул уурхайн салбар авч явна гэж үзэж байгаагаас гадна боловсруулах үйлдвэрлэл, ХАА-н салбарт ихээхэн найдлага тавьж байна. Харин **урт хугацаанд** уул уурхайд түшиглэн хөгжинө гэсэн иргэдийн хандлага багагүй хэмжээгээр буурч, дээр дурьдсан салбаруудаас гадна банк санхүү, боловсрол зэрэг бусад салбар уруу чиглэсэн.



Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн

Зураг 8

Хөгжлийг тодорхойлогч голлох салбар (санал асуулгад оролцогчдын хариулсан хувь)



Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн

Зураг 9

Ядуурлын түвшин (санал асуулгад оролцогчдын хариулсан хувь)

Түүвэр судалгааны үр дүнгээр иргэдийн 26 хувь нь ядуурал хэвэндээ гэж хариулсан нь сүүлийн жилүүдэд ядуурлын түвшин дорвитой буурахгүй дунджаар 32 хувьтай байгаагаар холбоотой байх талтай. Эндээс харахад иргэдийн ихэнх хувь нь ядуурлын түвшин өндөр хэвээр байна гэж үзжээ. Харин ажилгүйдлийн түвшин бага зэрэг буурсан гэж иргэд үзсэн нь судалгаагаар харагдсан юм.

Иргэдийн дийлэнх нь Засгийн газраас уул уурхайн салбарт томоохон төслүүд хэрэгжүүлж эхлүүлснийг дэмжиж байгаа хэдий ч улс орны эрх ашиг, аюулгүй байдалд нийцсэн, манай улсын эдийн засагт үр өгөөжтэй байх шаардлагыг тавьж байна. Иргэдийн бодлоор уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлж эхлүүлснээр байгаль орчинд сөрөг нөлөөг үзүүлнэ, уул уурхайн салбарын орлогын дийлэнх хэсгийг гадны хөрөнгө оруулагчид хүртэнэ, орлогын тэгш бус хуваарилалт нэмэгдэнэ гэсэн болгоомжлолтой байгаа нь судалгаагаар харагдлаа.

Зураг 10


Уул уурхайн салбар
эдийн засагт
үзүүлэх сөрөг нөлөө
(санал асуулгад
оролцогчдын
хариулсан хувь)



Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн

Зураг 11

Хүний хөгжил
сангийн эх үүсвэр
(санал асуулгад
оролцогчдын
хариулсан хувь)




Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн

Санал асуулгад оролцогчдын 20 орчим хувь нь **өнөөдрийн** бэлэн мөнгө олгож байгааг цаашид хэвээр нь үлдээхийг дэмжсэн бол олонх буюу **80 хувь** нь **цаашид** Хүний хөгжил сангийн мөнгөний эх үүсвэрийг ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг дэмжих болон үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулах нь зүйтэй гэж үзжээ.

Банк, санхүүгийн байгууллага


Манай улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог иргэдийн дийлэнх нь боломжийн гэж үзэж байгаагийн зэрэгцээ тэдний банкинд итгэх итгэл эргээд сэргэсэн нь банкуудын үйл ажиллагааг найдвартай гэсэн хариултын хувь хямралын жилээс мэдэгдэхүйц нэмэгдсэнээр харагдаж байна.



Зураг 12

Банкинд итгэх итгэл (санал асуулгад оролцогчдын хариулсан хувь)

Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн



Зураг 13

Банкны үйлчилгээ (санал асуулгад оролцогчдын хариулсан хувь)

Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн


Харин иргэдийн дунд банк, санхүүгийн байгууллагууд үйлчилгээгээ сайжруулах хэрэгтэй гэсэн хандлага нэмэгдсэн нь Хүний хөгжил сангаас олгож буй 21 мянган төгрөгийн үйл ажиллагаа зохион байгуулалтгүй, чирэгдэлтэй явагдаж байгаагаар холбоотой байх талтай юм. Иргэдийн санхүүгийн үйлчилгээ авдаг гол байгууллага нь банкны салбар хэвээр байгаа бөгөөд бэлэн бус тооцооны хэрэгсэл болох картыг өргөн хэрэглэдэг болсон нь төлбөр тооцоог хөнгөн шуурхай гүйцэтгэх үйл ажиллагааг хялбар болгож өгсөн.

Хуримтлалтай иргэдийн талаас илүү хувь нь хуримтлалаа банк санхүүгийн байгууллагад байршуулж байгаа нь өмнөх судалгааны үр дүнгээс өссөн үзүүлэлт боллоо. Иргэдийн хуримтлалаа бэлэн мөнгөөр хадгалах хандлага буурч байгаа нь нэг талаас бэлэн бус тооцооны хэрэгслийг ашигладаг болсон, нөгөө талаас хөрөнгөө үл хөдлөх хөрөнгө

болон үнэт цаас, хувьцаа зэрэг бусад хэлбэрээр байршуулдаг болсонтой холбоотой юм. Иргэдийн тал хувь нь хадгаламжийн хүүг боломжийн байна гэж үзсэн нь өмнөх жилүүдээс нэлээд өссөн үзүүлэлт байлаа.

Зураг 14

Хуримтлал,
хадгаламжтай
эсэх (санал асуулгад
оролцогчдын
хариулсан хувь)



Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн

Зураг 15

Зээлийн зарцуулалт
/2011 он/
(санал асуулгад
оролцогчдын
хариулсан хувь)



Эх үүсвэр: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгааны үр дүн

Зээлийн эрэлт, хэрэгцээ өмнөх жилүүдтэй харьцуулахад бага зэрэг буурч, зээл хүртээмжтэй гэж үзэх иргэдийн хандлага нэмэгдэн, хямралын өмнөх үеийн түвшинд хүрчээ. Энэ нь эдийн засаг хямралын дараа хэвийн үйл ажиллагаанд эргэн орж байгааг харуулж байна. Иргэд цаашид ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй байгаа бол түүний дараагаар ЖДҮ-ийн түүн дотроо худалдаа эрхлэх зээлийн эх үүсвэр авахыг хүсч байна. Мөн иргэдийн дунд ахуйн хэрэглээний зээлд хамрагдах хүсэл өндөр хэвээр байгаа юм. Эндээс харахад иргэд нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн зээл авах эрмэлзэл харьцангуй бага байгаа нь ажиглагдлаа. Иргэдийн дунд зээлийн хүү буурсан гэж үзэх хандлага 2009 оны судалгааны дүнгээс 4 хувиар нэмэгдлээ.

Шигтгээ 2: ЖДҮ эрхлэгчдийн дунд явуулсан судалгааны дүн

Жижиг дунд үйлдвэрлэл нь иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинээр ажлын байр бий болгож ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, шинэ технологи, бүтээгдэхүүн бий болгох, бичил болон том бизнесүүдийг холбож өгөх зэргээр эдийн засгийн өсөлтийг олон талаар дэмждэг. Банкны салбар ЖДҮ-ийн хөгжилд санхүүгийн зуучлалынхаа хувьд гол үүрэг гүйцэтгэдэг байна.

Монголбанкнаас 2011 оны 1 дүгээр улиралд орон даяар ЖДҮ эрхлэгчдийн дунд “Монгол улс дахь ЖДҮ-ийн хөгжлийн өнөөгийн байдал, түүний санхүүжилт”-ийн талаар түүвэр судалгаа явуулж, уг судалгаанд нийт 2,227 ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгж (ХК, ХХК, нөхөрлөл, хоршоо) оролцлоо.

Санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн зүгээс тэднийг хамгийн ихээр дэмжиж буй байгууллагуудаар:

- Арилжааны банкууд,
- Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа тодорсон байна.

Эдгээр байгууллагуудаас голчлон санхүүжилт олгох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сургалт, зөвлөгөө явуулах, татварыг хөнгөвчлөх (татвар, НӨАТ-аас чөлөөлсөн) замаар дэмжлэг үзүүлдэг байна. Эдийн засгийн салбаруудаар ангилж харвал ХАА, үйлдвэрлэлийн салбарт бусад салбаруудаас илүү ихээр дэмжлэг авдаг байна. Цаашид нэн түрүүнд дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна гэж үзжээ:

- Төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй болгох,
- Санхүүжилтийн хөнгөлөлттэй, хангалттай эх үүсвэрийг бүрдүүлэх,
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих,
- Татварын таатай орчинг бий болгох,
- Авилгалыг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзжээ.

ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эдийн засгийн таатай орчин хангалттай бүрдээгүй гэж үзсэн нь манай улсад бизнес эрхлэх орчин, боломж муу байгааг харуулж байна. Түүнчлэн санал асуулгад оролцогчид инфляцийн түвшин доогуур тогтвортой, төгрөгийн ханш хэлбэлзэл багатай байх нь тэдгээрийн бизнест эерэг нөлөө үзүүлнэ гэжээ.

Нийгмийн зүгээс ЖДҮ-ийн хөгжилд ядуурал болон ажилгүйдэл хамгийн гол бэрхшээл болж байна. Ядуурал, ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь нэг талаас хэрэглэгчдийн худалдан авах чадвар сул байгааг харуулах бөгөөд нөгөө талаас ядуурал, ажилгүйдэл нийгэмд өндөр байгаагаас ЖДҮ эрхлэгчдийн тодорхой хэсэг нь санхүүжилт авах барьцаа хөрөнгө, баталгаа байхгүй байгааг нотолж байна. Хээл хахууль, гэмт хэрэг болон улс төрийн тогтворгүй байдал нь ЖДҮ-ийн хөгжилд багагүй саад болж байгаа нь санал асуулгын дүнгээс харагдлаа.

ЖДҮ-ийн бизнесийн орчин (-1=муу, 1=сайн)



Мөн ЖДҮ эрхлэхэд хамгийн их саад бэршээл учруулж байгаа хүчин зүйл нь хөгжиж буй улсуудын нэгэн адил санхүүжилтийн орчин буюу:

- Хөнгөлөлттэй зээлийн олдоц хомс,
- Зээлийн үндсэн нөхцөл хатуу (хүү өндөр, хэмжээ бага, хугацаа богино),
- Хөрөнгийн зах зээлийн хөгжил сул,
- Барьцаа хөрөнгө, баталгаа байхгүй зэрэг болж байна.

Олон улсын байгууллагууд, Засгийн газраас дамжуулан олгож буй хөнгөлөлттэй зээлийн хэмжээ нь ЖДҮ-ийг бүрэн санхүүжүүлэх хэмжээнд хүрч чадахгүй (бүрэн санхүүжүүлэх боломж ч байхгүй биз дээ) байгаагийн зэрэгцээ бага хүүтэй, дунд болон урт хугацаатай, хангалттай хэмжээтэй санхүүжилтийн эх үүсвэрийг өнөөгийн байдлаар манай банк, санхүүгийн байгууллагууд олгох боломжоор тааруухан байна. Хөрөнгийн зах зээлийн хөгжил сул (ялангуяа орон нутагт огт хөгжөөгүй) байгаагаас шалтгаалж бизнес эрхлэгчид өөрсдийн хөрөнгө, техник, технологи дээр тулгуурлан мөнгө босгох боломжоор хязгаарлагдмал байгаагийн зэрэгцээ ажилгүйдэл, ядуурал их байгаа учир санхүүжилт авах барьцаа хөрөнгө, баталгааны асуудал хүндрэлтэй хэвээр байна.

Санал асуулгын дүнгээр хууль эрх зүйн ерөнхий орчныг “муу” гэж дүгнэсэн бөгөөд эдгээрээс:

- Төрийн байгууллагын үйлчилгээ,
- Хууль, эрх зүйн орчин,
- Татварын тогтолцоо,
- Гадаад худалдаа хийх нөхцөл зэрэг үзүүлэлтүүд хамгийн “муу” дүнг авчээ.

Зах зээлийн зүгээс хамгийн хүндрэлтэй асуудал нь шударга бус өрсөлдөөн болж байна. Эндээс зах зээлд шударга бусаар оролцож, өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулдаг ААН, иргэд нийгэмд байсаар байгаа бөгөөд нөгөө талаар өрсөлдөөнийг хянан зохицуулах үүрэг бүхий байгууллагын ажлын үр дүнг харуулж байгаа юм. Үүнээс гадна зах зээлийн багтаамж бага, мөн даатгалын тогтолцоо сул байгааг судалгаанд оролцогчид онцолж байна.

Судалгааны дүнгээр дэд бүтцийн байдлыг бага зэрэг муу гэсэн ч бусад бизнесийн орчны хүчин зүйлстэй харьцуулахад хамгийн боломжийн гэж үзжээ. Дэд бүтцийн орчин дотроо тээврийн хөгжлийг хамгийн муу байна гэж үзсэн бөгөөд дулаан, усан

хангамжийн асуудал үүний дараа орж байна.

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ямар зардал, хэрхэн хүндрэл учруулж буйг олж тогтоох нь цаашдын бодлого боловсруулалтанд ихээхэн ач холбогдолтой билээ. ЖДҮ эрхлэгч нарт хамгийн их хүндрэлтэй зардлуудаас:

- Зээлийн хүү,
- Шимтгэл хураамжийн төлбөр,
- Тоног төхөөрөмжинд зарцуулах зардал,
- Түрээсийн зардал зэрэг үзүүлэлтүүд хамгийн их хүндрэл учруулдаг нь харагдлаа.

Ихэнхи нь санхүүжилтийн анхны эх үүсвэрээ гэр бүлийн хөрөнгөөр босгодог бөгөөд 4-ний нэг нь банкаас зээл авч анхны санхүүжилтээ авсан байна. Талаас илүү нь урьд нь зээл болон бусад хэлбэрээр санхүүжилт авсан бол үлдэж буй бизнес эрхлэгчдийн ихэнх нь зээлийн хэрэгцээ байгаагүй бөгөөд зарим нь зээлийн нөхцөл хангаагүй, хангасан боловч банкны зээлийн нөхцөлийг хэт хатуу байна гэж үзсэний улмаас санхүүжилт аваагүй байна. Урьд нь санхүүжилтэнд хамрагдсан бизнес эрхлэгчдийн дийлэнх нь банкны зээлээр санхүүжсэн байхад үлдсэн нь хөнгөлөлттэй зээл, гэр бүлийн хөрөнгөөр санхүүжсэн байна. Судалгаанд оролцогчид авсан санхүүжилтээ эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, машин тоног төхөөрөмж худалдан авах зэрэгт ихэвчлэн зарцуулдаг байна. Харин зээлээ эргэн төлөхөд хүү хэт өндөр, хугацаа богино, хэмжээ бага гэсэн хүндрэлүүд тулгарч байна. Мөн судалгаанд оролцогчдын ихэнх нь цаашид санхүүжилтийн хэрэгцээ байгаа бөгөөд 10-50 сая төгрөгийн хэмжээтэй, дунджаар жилийн 5.8 хувийн хүүтэй, нэгээс дээш жилийн хугацаатай зээл тохиромжтой гэж үзжээ.

Судалгааны бүрэн эхийг дараах цахим хаягаар орж үзнэ үү:

http://www.mongolbank.mn/documents/moneypolicy/SME_negtgel.pdf

1.2 Үйлдвэрлэл

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээгээр бодит дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт 2011 онд урьдчилсан байдлаар жилийн 17.3 хувьд хүрэв. Энэхүү өсөлтийн 7.1 нэгжийг бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ, 4.0 нэгжийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар, 1.6 нэгжийг тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, мөн 1.5 нэгжийг уул уурхай, олборлох салбар, 1.0 нэгжийг боловсруулах үйлдвэрлэл тус тус бүрдүүлсэн бол үлдсэн 2.1 нэгжийг бусад салбар бүрдүүлжээ.

Иймээс ДНБ-ий өсөлтийн 40 гаруй хувийг худалдаа үйлчилгээний салбарт ногдож байгаад дүгнэлт хийн, үйлдвэрлэлийн салбарыг түлхүү анхаарах шаардлагатай байна.

Өмнөх оныхтой харьцуулахад бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 52.2 хувиар, бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар 42.5 хувиар, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 19.6 хувиар, боловсруулах үйлдвэрлэл 16.0 хувиар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлтүүд байсан бол манай улсын гол салбаруудын нэг болох хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт (ХАА)-ын салбар 0.3 хувиар өссөн нь маш бага үзүүлэлт юм. Харин усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент 2.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 3: ДНБ, салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр (сая төг)

	2010	2011*	Өсөлт	Хувийн жсн	Өсөлтөнд оруулж буй хувь
ДНБ	4,162,784.9	4,881,362.0	17.3	100.0	17.3
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт	664,150.1	666,359.3	0.3	13.7	0.1
Уул уурхай, олборлолт	736,944.1	801,031.6	8.7	16.4	1.5
Боловсруулах үйлдвэрлэл	248,573.0	288,293.8	16.0	5.9	1.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	96,144.1	100,927.0	5.0	2.1	0.1
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	16,640.1	16,263.0	-2.3	0.3	0.0
Барилга	60,225.6	68,825.6	14.3	1.4	0.2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	387,486.2	552,128.3	42.5	11.3	4.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	491,459.4	559,116.0	13.8	11.5	1.6
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	23,307.0	26,712.0	14.6	0.5	0.1
Мэдээлэл холбоо	180,325.1	190,759.4	5.8	3.9	0.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	143,563.3	159,915.8	11.4	3.3	0.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	195,850.6	206,934.3	5.7	4.2	0.3


Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	41,916.8	45,481.0	8.5	0.9	0.1
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	52,767.7	63,127.9	19.6	1.3	0.2
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	76,079.9	76,992.9	1.2	1.6	0.0
Боловсрол	99,089.4	106,851.7	7.8	2.2	0.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	50,138.4	53,304.0	6.3	1.1	0.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	11,475.0	12,294.1	7.1	0.3	0.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	16,719.6	18,685.6	11.8	0.4	0.0
Бүтээгдэхүүний цэвэр татвар	569,929.4	867,358.9	52.2	17.8	7.1

Эх үүсвэр: УСХ *урьдчилсан байдлаар

Эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй байдал буюу иргэдийн өсөлтөд оруулах хувь нэмэр болон өсөлтөөс хүртэх байдлыг авч үзэхэд гол тодорхойлогч хүчин зүйлсийн үзүүлэлтүүд төдийлөн сайжраагүй байна. Тодруулбал, эдийн засгийн өсөлттэй харьцуулахад ядуурал, ажил эрхлэлтийн байдал хангалттай бус, эдийн засаг уул уурхайн салбараас хамааралтай болж байгаа зэргээс харагдаж байна. Гэсэн хэдий ч Дэлхийн банк, АХБ-наас эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй байдалд анхаарч ажиллаж байгаа нь зохих үр дүнгээ өгсөөр байна.

Хөдөө аж ахуй

2010 онд зудны улмаас 16.6 хувиар буураад байсан ХАА-н салбар тайлант хугацаанд эргэн өсч 0.3 хувьд хүрсэн байна.



Зураг 16

ХАА-н салбарын өсөлт, бууралт (%)

Эх үүсвэр: УСХ

Малын тоо өмнөх оноос 3.6 сая буюу 11.0 хувиар өсч 36.3 сая толгойд хүрсэн байна. Үүний дотор ямаа 14.8 хувиар өсч 15.9 сая толгойд, хонь 8.2 хувиар өсч 15.7 сая толгойд, үхэр 7.5 хувиар өсч 2.3 сая толгойд, адуу 10.0 хувиар өсч 2.1 сая толгойд, тэмээ 3.9 хувиар өсч 280 мянган толгойд тус тус хүрчээ. Нийт мал сүрэгт ямаа 43.9 хувь, хонь 43.1 хувь, үхэр 6.4 хувь, адуу 5.8 хувь, тэмээ 0.8 хувийг эзэлж өмнөх оноос ямааны эзлэх хувь 1.4 нэгжээр өсч, харин адуу, тэмээ, үхэр, хониных 0.1-1.1 нэгжээр буурсан байна.

Зураг 17


Малын тоо, төрлөөр
(мян.тол)



Эх үүсвэр: УСХ

Зураг 18

Нийт мал сүрэгт
таван төрлийн малын
эзлэх хувь



Эх үүсвэр: УСХ

Хөвсгөл (3315.5 мянга), Архангай (2984.3 мянга), Төв (2962.0 мянга), Өвөрхангай (2425.6 мянга), Хэнтий (2379.1 мянга) зэрэг аймгууд малын тоогоороо тэргүүлж байна. Малтай нэг өрхөд дунджаар 170 толгой мал, үүнд 1 тэмээ, 10 адуу, 11 үхэр, 73 хонь, 75 ямаа ногдож байна. Тайлант онд 13.1 сая эх мал буюу эх малын 84.6 хувь төллөжээ. Төллөлтийн хувь өмнөх оноос 3.1 нэгжээр өссөн байна. Нийт 12.5 сая төл бойжсон бөгөөд бойжилтын хувь 26.9 нэгжээр өсч, 94.9 хувь болжээ.

Тариалсан нийт талбай 345.9 мянган га болж, өмнөх оноос 9.7 хувиар ихэссэн байна. Тайлант онд 446.1 мянган тонн үр тариа, 201.6 мянган тонн төмс, 100.0 мянган тонн хүнсний ногоо хурааж, 1195.2 мянган тонн өвс хадлан болон 46.7 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь 2010 оныхоос үр тариа 25.6 хувиар, төмс 20.1 хувиар, хүнсний ногоо 20.3 хувиар, өвс хадлан 5.1 хувиар, гар тэжээл 42.8 хувиар тус тус өсчээ.

Аж үйлдвэр

ҮСХ-ны мэдээгээр аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл (2005 оны үнээр) 9.7 хувиар өсч 2056.8 тэрбум төгрөг болжээ. Уг өсөлтөд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбараас нүүрс олборлолт 22.6 хувь, газрын тос шатдаг хий олборлолт 16.8 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбараас хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл 10.5 хувиар, үүний дотор ундаа, согтууруулах ундаа 23.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин бусад ашигт малтмалын олборлолт өмнөх жилээс 14.0 хувь, төмрийн үйлдвэрлэл 9.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 4: Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний жилийн өөрчлөлт, %, гол бүтээгдэхүүнээр

	2009	2010	2011
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	2.2	10.1	9.5
Нүүрс олборлолт	34.2	91.8	22.6
Газрын тос олборлолт	59.3	16.7	16.8
Металлын хүдэр олборлолт	-6.2	-6.4	4.1
Бусад ашигт малтмал олборлолт	-10.8	19.5	-14
Боловсруулах аж үйлдвэр	-14.2	11.4	11.6
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	22.1	24	10.5
Ундаа, согтууруулах ундаа үйлдвэрлэл	15	33.9	23.4
Нэхмэлийн үйлдвэрлэл	-5.3	-21.8	1.7
Төмрийн үйлдвэрлэл	-64.1	29.6	-9.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	1.8	5.8	5.8
Цахилгаан, дулаан үйлдвэрлэл	2.2	6.4	6.2

Эх үүсвэр: ҮСХ

2011 онд оны үнээр 5626.7 тэрбум төгрөгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулснаас 62.4 хувийг гадаадын зах зээлд нийлүүлжээ. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалт нийт борлуулалтын дүнд 64.9 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 27.8 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн борлуулалт 7.3 хувийг тус тус эзэлж байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалтын 83.8 хувь, боловсруулах аж үйлдвэрийн 29.6 хувь нь гадаадын зах зээлд ногдож байна.


Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 56.3 хувийг Улаанбаатар хотод, 22.2 хувийг Орхон аймагт борлуулсан байна.

Уул уурхай, олборлолт

ҮСХ-ны мэдээгээр уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэл 2011 онд 8.7 хувиар өсч, өмнөх онтой харьцуулахад 5.1 нэгжээр нэмэгдсэн байна. Уул уурхайн салбар 2002 онд ДНБ-ий 8.6 хувийг бүрдүүлж байсан бол 2011 онд хамгийн их буюу 16.4 хувийг бүрдүүлэх болсон байна. Уг хандлага цаашид нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд уул уурхайн салбар Монгол улсын эдийн засгийн голлох салбар болоод байна.

Зураг 19

Уул, уурхай олборлох
салбарын өсөлт,
бууралт (%)



Эх үүсвэр: УЦХ


Уул уурхай, олборлолтын салбар өсөхөд гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдээс газрын тос олборлолт болон төмрийн хүдрийн олборлолт 16.8-77.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн бол бусад гол бүтээгдэхүүнүүд бүгд буурсан байна.

Хүснэгт 5: Уул уурхай, олборлох салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл (жилийн өөрчлөлт, %)

	2009	2010	2011
Нүүрс	34.2	91.8	22.6
Газрын тос	59.3	16.7	16.8
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	1.5	-2.1	-1.6
Зэсийн баяжмал, 35%-ийн агуулгад шилжүүлсэнээр	2.4	-3.7	-2.7
Молибдений баяжмал, металл агуулгаараа	38.7	-17.4	-8.5
Зэсийн баяжмал, 47%-ийн агуулгад шилжүүлсэнээр	26.8	-8.7	-11
Алт	-35.4	-38.4	-5.5
Төмрийн хүдэр	-0.6	132.3	77.3
Хайлуур жоншны баяжмал	-19.3	22	-17.3
Цайрын баяжмал	-1.5	-20.4	-7
Буталмал чулуу	19.5	-18.1	-6.9

Эх үүсвэр: УЦХ

2011 оны байдлаар уул уурхайн салбар аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 64.9 хувь, нийт экспортын 47 хувийг тус тус бүрдүүлж байна. Оюутолгой, Тавантолгой болон бусад томоохон орд газруудыг ашиглаж, эдийн засгийн эргэлтэнд оруулж эхэлснээр уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Засгийн газраас нүүрсний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлснээр 2006 онд 2.3 сая тонн нүүрс экспортолсон бол 2011 онд 21.1 сая тоннд хүрчээ.




Эх үүсвэр: УСХ


Тээвэр, холбоо

УСХ-ны мэдээгээр 2011 онд тээврийн бүх төрлийн хэрэгслээр 44.0 сая тонн ачаа, давхардсан тоогоор 296.2 сая зорчигч тээвэрлэсэн бөгөөд 2010 оноос ачаа тээвэрлэлт 49.5 хувь, зорчигч тээвэрлэлт 18.2 хувиар тус тус өссөн байна. Тээврийн салбарын нийт орлого 756.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 27.4 хувиар нэмэгджээ.

Авто техникийн улсын үзлэг, тооллогын дүнгээр 2011 онд 312.5 мянган тээврийн хэрэгсэл байгаа нь өмнөх оноос 58.1 мянга буюу 22.8 хувиар нэмэгжээ. 66.7 хувь нь суудлын машин байна.



Эх үүсвэр: УСХ



Эх үүсвэр: УСХ

Зураг 20

Нүүрсний экспортын
хэмжээ (сая тонн)

Зураг 21

Автомашинь төрөл

Зураг 22

Автомашинь
ашигласан жил


Шуудан холбооны нийт орлого 459.0 тэрбум төгрөгт хүрч жилийн хугацаанд 57.1 тэрбум төгрөг буюу 14.3 хувиар өсөв. Үүнээс хүн амаас орсон орлого 343.9 тэрбум төгрөгт хүрч, нийт орлогын 74.9 хувийг бүрдүүлжээ.

Барилга

Урьдчилсан гүйцэтгэлээр барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2011 онд 450.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 28.5 хувиар өссөн байна. Нийт барилга угсралт, их засварын ажлын 94.9 хувийг дотоодын барилгын байгууллага хийж гүйцэтгэв.

Нийт барилга угсралт, их засварын ажлын 33.3 хувийг инженерийн барилга байгууламж, 29.8 хувийг орон сууцны барилга, 27.4 хувийг орон сууцны бус барилга (үйлдвэрийн, худалдаа үйлчилгээний, эмнэлэг, сургууль, соёлын г.м.), 9.5 хувийг их засварын ажил тус бүр эзэлж байна. Мөн дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн нийт барилга угсралт, их засварын ажлын 55.8 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Зураг 23
Барилга угсралт,
их засварын ажил



Эх үүсвэр: УСХ

1.3 Гадаад сектор

Төлбөрийн тэнцэл

Монгол улсын эдийн засгийн бодит өсөлт 2011 онд 17.3 хувьд хүрч 2010 оноос 11.2 нэгж хувиар өссөн, барааны гадаад худалдааны нийт эргэлт 11.3 тэрбум ам.долларт¹ хүрч 83.1 хувиар нэмэгдсэн, эдийн засаг дахь валютын урсгалын нийт эргэлтийн хэмжээ 2010 оноос 55.5 хувиар өссөн зэрэг нь эдийн засаг ихээхэн тэлсний илэрхийлэл юм.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2011 онд 2757 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 2864 сая ам.долларын ашигтай, алдаа ба орхигдуулга 78 сая ам.долларт хүрч нийт төлбөрийн тэнцэл 28 сая ам.долларын ашигтай гарлаа.

¹ C.I.F. нөхцөлөөр тооцсон дүн.



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 24

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл (сая ам.доллараар)

Урсгал тэнцэл

Тайлант онд урсгал тэнцлийн алдагдал 2757 сая ам.долларт хүрсэн нь 2010 оноос 3.1 дахин өссөн үзүүлэлт бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 32 хувьтай тэнцэх хэмжээнд хүрчээ. Урсгал тэнцлийн алдагдал ийнхүү огцом өсөхөд барааны гадаад худалдааны алдагдал өмнөх оноос 5.5 дахин өсч 993 сая ам.долларт, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 3.9 дахин өсч 1161 сая ам.долларт, цэвэр орлогын дансны алдагдал 41 хувиар өсч 843 сая ам.долларт тус тус хүрч нэмэгдсэн нь нөлөөлөв.

Урсгал тэнцлийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2011 онд өмнөх оноос 18 нэгж хувиар огцом өссөн нь эдийн засгийн тэлэлт, уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, дотоодын хэрэглээний өсөлттэй уялдан бараа бүтээгдэхүүний импорт хурдацтай өссөн, үүнийг дагаад үйлчилгээний төлбөрүүд нэмэгдсэнтэй холбоотой байна. Урсгал тэнцлийн алдагдлыг бүтцээр нь авч үзвэл бараа ба үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 78 хувийг эзэлж байгаа нь 2010 оноос 25 нэгж хувиар өссөн байна.




Эх үүсвэр: Монголбанк

Зураг 25

Урсгал тэнцлийн алдагдлын ДНБ-д харьцуулсан харьцаа

Зураг 26

Урсгал тэнцлийн
алдагдлын бүтэц /
цэвэр дүнгээр/, сая
ам.доллар



Эх үүсвэр: Монголбанк

Барааны гадаад худалдаа

Барааны гадаад худалдааны нийт эргэлт² 10628 сая ам.долларт хүрч 2010 оноос 1.8 дахин нэмэгдэхэд экспорт 66 хувиар, импорт 88 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Гадаад худалдаа ийнхүү тэлсэн нь экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ болон дэлхийн зах зээл дэх үнийн өсөлт, хүнд машин механизм, тоног төхөөрөмж, түлш шатахуун болон хэрэглээний бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнийн өсөлтүүдээр тус тус тайлбарлагдаж байна.

Тайлант онд нийт экспортын орлого³ 4780 сая ам.долларт хүрч 65 хувиар өссөн ба үүний 76 хувийг зөвхөн нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр гэсэн гурван бүтээгдэхүүн бүрдүүлжээ. Үнийн дүнгээр чулуун нүүрсний экспорт 156 хувиар өсөхөд дэлхийн зах зээл дэх үнэ 85 хувиар өссөн, зэсийн баяжмалын экспорт 25 хувиар өсөхөд дэлхийн зах зээл дэх А зэрэглэлийн цэвэр зэсийн дундаж үнэ 20 хувиар өссөн, төмрийн хүдрийн экспорт 74 хувиар өсөхөд биет хэмжээ нь 62 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.


Нийт импорт⁴ 99 хувиар өсч 6527 сая ам.долларт хүрэхэд хүнд машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт 2.1 дахин өсч 1167 сая ам.долларт, түлш шатахууны импорт 1.7 дахин өсч 1135 сая ам.долларт, тээврийн хэрэгслийн импорт 2.5 дахин өсч 1075 сая ам.долларт тус тус хүрсэн нь голлон нөлөөлжээ. Эдгээр гурван ангиллын бүтээгдэхүүн нь нийт импортын 52 хувийг бүрдүүлж байгаа юм. 2011 онд түлш шатахууны болон тоног төхөөрөмжийн импорт ийнхүү мэдэгдэхүйц хэмжээгээр өссөний зэрэгцээ өргөн хэрэглээний бүх төрлийн бараа, бүтээгдэхүүний импорт огцом өсөлттэй байв.

Барааны гадаад худалдаа С.I.F. нөхцөлөөр 2011 онд өмнөх оноос 4.6 дахин өсч 1747 сая ам.долларын, F.O.B. нөхцөлөөр 5.5 дахин өсч 993 сая ам.долларын алдагдалтай байна.

2 F.O.B. нөхцөлөөр илэрхийлсэн дүн.

3 Төлбөрийн тэнцлийн олон улсын аргачлалын дагуу нэмэлт тооцоолол хийгээгүй дүн

4 С.I.F. нөхцөлөөр



Зураг 27

Барааны гадаад
худалдааны тэнцэл⁵
(сая ам.доллараар)

Эх үүсвэр: Монголбанк

Хүснэгт 6: Экспортын бүтэц, C.I.F. нөхцөлөөр (сая ам.доллар)

		2010		2011		Мөнгөн дүнгийн өөрчлөлт
Голлох бүтээгдэхүүний нэр төрөл		Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	
1	Чулуун нүүрс	16,559,008.9	874.6	20,956,064.9	2,239.3	156.0% ↑
2	Зэсийн баяжмал	568,664.1	770.6	572,791.2	963.6	25.0% ↑
3	Төмрийн хүдэр ба баяжмал	3,539,320.4	250.9	5,753,124.3	437.3	74.3% ↑
4	Боловсруулаагүй нефть	2,078,682.3	154.9	2,540,474.6	252.2	62.8% ↑
5	Цайрын хүдэр ба баяжмал	119,788.7	134.1	120,724.1	142.7	6.4% ↑
6	Ямааны угаасан ноолуур	3,015.5	104.6	2,829.5	131.9	26.1% ↑
7	Мөнгөжөөгүй алт	5,060.3	178.3	2,655.4	113.0	-36.6% ↓
8	Жонш, лейцит, нефелинт ба нефелинт сиенит	376,049.5	63.2	404,000.7	94.9	50.2% ↑
9	Ямааны самнасан ноолуур	976.5	68.8	537.8	57.6	-16.2% ↓
10	Молибдений хүдэр ба баяжмал	4,768.7	52.0	4,191.0	46.4	-10.8% ↓
	Бусад		247.1		301.3	22.0% ↑
Нийт экспорт		2,899.2		4,780.4		64.9% ↑

Эх үүсвэр: Монголбанк

Хүснэгт 7: Импортын бүтэц, C.I.F. нөхцөлөөр (сая ам.доллар)

Голлох ангиллаар		2010	2011	Өөрчлөлт
1	Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	546.2	1,167.3	113.7% ↑
2	Нефтийн бүтээгдэхүүн	678.0	1,134.9	67.4% ↑
3	Тээврийн хэрэгсэл	422.2	1,074.5	154.5% ↑
4	Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	114.2	212.3	85.8% ↑
6	Хүнсний бүтээгдэхүүн	168.9	189.2	12.0% ↑
7	Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	63.5	90.5	42.5% ↑
5	Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	22.8	58.0	154.5% ↑
8	Төрөл бүрийн даавуу	1.7	1.8	9.3% ↑
9	Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	124.2	211.3	70.2% ↑
	Бусад	1,136.2	2,387.1	110.1% ↑
Нийт импорт		3,277.9	6,526.9	99.1% ↑

Эх үүсвэр: Монголбанк


5 Энэ нь төлбөрийн тэнцэлд тусгадаг F.O.B нөхцөлөөр илэрхийлсэн, ерөнхий барааны тэнцэл болно

Үйлчилгээний гадаад худалдаа

Монгол Улсаас эдийн засгийн харъяат буст үзүүлсэн үйлчилгээний орлого 2011 онд 28 хувиар өсч 622 сая ам.долларт хүрсэн боловч харъяат бусаас авсан үйлчилгээний зардал 128 хувиар өсч 1782 сая ам.долларт хүрснээр үйлчилгээний гадаад худалдаа 1160 сая ам.долларын алдагдалтай болж, алдагдлын хэмжээ нь 2010 оноос 3.9 дахин өсчээ. Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал ийнхүү огцом өсөхөд тээврийн үйлчилгээний алдагдал 7.4 дахин өсч 822 сая ам.долларт, аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал 6 дахин өсч 126 сая ам.долларт хүрсэн нь голлон нөлөөллөө. Барааны гадаад худалдаа эрчимжиж, импортын хэмжээ хурдацтай өссөнөөс тээврийн үйлчилгээний эрэлт нэмэгдсэн, С.I.F. нөхцөлөөр тооцсон импортыг F.O.B. нөхцөлд хөрвүүлэх тооцооллын коэффициентийг Монголбанк шинэчилсэнтэй уялдан тээврийн үйлчилгээний алдагдал ийнхүү өсчээ. Харин Монгол Улсаас гадаадад зорчих иргэдийн тоо нь манай улсад жуулчлах гадаадын жуулчдын тооноос олон байсан нь тайлант онд аялал жуулчлалын үйлчилгээний орлого 11 хувиар буурч 218 сая ам.долларт, зардал 30 хувиар өсч 344 сая ам.долларт хүрэхэд, улмаар аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал өсөхөд нөлөөлсөн байна.

Зураг 28

Үйлчилгээний гадаад худалдааны тэнцэл
(сая ам.доллараар)




Эх үүсвэр: Монголбанк

Цэвэр орлогын данс

Тайлант онд ажиллагсдын цалин хөлсний орлого өмнөх оноос 1.6 дахин өсч 30 сая ам.долларт хүрсэн хэдий ч Монгол Улсад ажиллаж буй гадаадын ажиллагсдад олгосон цалин хөлсний хэмжээ түүнээс илүү хурдацтай буюу 2.9 дахин өсч 146 сая ам.долларт хүрснээр ажиллагсдын цалин хөлсний орлогын данс цэвэр дүнгээр 116 сая ам.долларын алдагдалтай болж, алдагдлын хэмжээ нь 2010 онтой харьцуулахад 3.6 дахин өсөв.

Хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал 728 сая ам.долларт хүрч өмнөх оноос 1.3 дахин өссөн байна. Үүнд шууд хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал 35 хувиар, багцын хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал 16 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.



Зураг 29

Орлогын дансны
тэнцэл, цэвэр
дүнгээр (сая
ам.доллар)

Эх үүсвэр: Монголбанк

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагууд нь эдийн засгийн харьяат бус хувьцаа эзэмшигчиддээ 257.3 сая ам.долларын ногдол ашгийг хуваарилж, улмаар гадны хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэрт 13.0 сая ам.долларын хүү төлсөн бол эдийн засгийн харьяатууд гадаадаас авсан зээлийн эх үүсвэрт нийтдээ 97.6 сая ам.долларын төлбөр төлжээ.

Тайлант онд цэвэр орлогын дансны алдагдал 843 сая ам.долларт хүрсэн нь 2010 оноос 41 хувиар өссөн үзүүлэлт болов.

Урсгал шилжүүлэг

Урсгал шилжүүлэг цэвэр дүнгээр 238 сая ам.долларын ашигтай гарсан нь 2010 оноос 27 хувиар өсчээ. Хэдийгээр Засгийн газрын шилжүүлэг цэвэр дүнгээр 46 хувиар буурч 18 сая ам.доллар болсон ч бусад урсгал шилжүүлэг 43 хувиар өсч 220 сая ам.долларт хүрсэн нь үүнд нөлөөлсөн байна. Монгол иргэдийн эх оронруугаа гуйвуулсан валютын хэмжээ 249 сая ам.долларт хүрсэн нь ердөө 0.3 хувийн өсөлттэй байлаа. Гэтэл Монголд ажиллаж байгаа гадаадын иргэдээс гадагш шилжүүлсэн валютын хэмжээ 191 сая ам.долларт хүрч 61 хувиар өссөн байна. Монголоос гадагш гуйвуулж буй валютын хэмжээ ийнхүү эрс нэмэгдэх хандлагатай болж байгаа нь урсгал шилжүүлгийн дансны ашгийг бууруулж болзошгүй юм.

Хүснэгт 8: Ажиллагсдын гуйвуулга (сая ам.доллар)


	2009	2010	2011	Жилийн өөрчлөлт	
				Мөнгөн дүн	Хувь
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	120.1	129.4	60.5	-68.9	-53%
Гаднаас орж ирсэн	191.5	247.9	248.7	0.8	0%
Гадагш шилжүүлсэн	71.4	118.5	188.2	69.7	59%

Эх үүсвэр: Монголбанк

Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл

Зураг 30


Хөрөнгө ба
санхүүгийн тэнцэл
(сая ам.доллар)



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 31

Санхүүгийн данс
(сая ам.доллар)



Эх үүсвэр: Монголбанк


Тайлант онд хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 2864 сая ам.долларын ашигтай гарсан нь 2010 онтой харьцуулахад 1.6 дахин өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд 2010 онд 894 сая ам.долларын ашигтай байсан багцын хөрөнгө оруулалт 77 сая ам.долларт хүрч ашиг буурсан, бусад хөрөнгө оруулалтын дансны алдагдал 1947 сая ам.долларт хүрч 2010 оноос 2.1 дахин нэмэгдсэн ч гадаадын шууд хөрөнгө оруулалт 4620 сая ам.долларт хүрч 2010 оноос 2.8 дахин өссөн нь нөлөөлжээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Эдийн засгийн тэлэлт, бизнесийн өсөх мөчлөг, ашигт малтмалын салбар дахь томоохон төслүүдийн хэрэгжилт, барилга угсралтын салбарын өсөлттэй уялдан Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт⁶ 2011 онд мэдэгдэхүйц хэмжээгээр

⁶ Төлбөрийн тэнцлийг боловсруулах аргачлалын дагуу эдийн засгийн харьяат аж ахуйн нэгж, байгууллагын толгой компаниасаа авсан гадаад зээлийг гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүнд оруулж бүртгэдэг болно.


өссөн бөгөөд хөрөнгө оруулалт хийсэн улсаар нь авч үзвэл нийт хөрөнгө оруулалтын 86 хувийг Гонгконг, Канад, БНХАУ, АНУ, ОХУ гэсэн таван улс бүрдүүлж байгаа юм. Нийт хөрөнгө оруулалтын 85 хувь нь уул уурхай, ашигт малтмалын салбарт, 4 хувь нь барилгын салбарт, 3 хувь нь банк санхүүгийн салбарт тус тус ногдож байна.



Эх үүсвэр: Монголбанк, ГЕГ

Зураг 32

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт (улсаар)



Эх үүсвэр: Монголбанк, ГЕГ

Зураг 33

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт (салбараар)

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант онд 77 сая ам.долларын ашигтай гарахад дараах гүйлгээнүүд голлон нөлөөлжээ. Үүнд:

- **Гадаад актив:** Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд нь эдийн засгийн харьяат бусаас худалдаж авсан үнэт цаасны эргэн төлөлтөд 21 сая ам.долларыг хүлээн авсан байна.
- **Хөрөнгийн хувьцаа:** Монголын хөрөнгийн бирж болон санхүүгийн зуучлагч компаниудаар дамжуулан гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын худалдаж авсан хөрөнгийн хувьцааны цэвэр дүн 9 сая ам.долларын орох урсгалтай байна.
- **Засгийн газрын үнэт цаас:** Монгол Улсын Засгийн газраас тайлант онд арилжаалсан бондын 21 сая ам.доллар буюу 5.7%-ийг эдийн засгийн харьяат бус этгээдүүд худалдаж авсан бөгөөд Хөгжлийн банкнаас дотоодын төсөл

хөтөлбөрийн санхүүжилтэнд зориулж 20 сая ам.долларын үнэт цаасыг арилжаалсан.

Бусад хөрөнгө оруулалт

Энэхүү бүлэг дансанд арилжааны банкуудын харилцах, хадгаламж, бүх төрлийн зээл, худалдааны санхүүжилт, санхүүгийн лизингийн эх үүсвэр болон бусад актив, пассивын өөрчлөлтийг харуулдаг ба ингэхдээ Монголбанк, Засгийн газар, банкууд, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эдийн засгийн харъяат бус этгээдтэй хийсэн гадаад зээлийн ашиглалт, эргэн төлөлтийг зээлийн хугацаа, ангиллаар нь тус тус тооцон бүртгэдэг.

Монгол улсын Засгийн газар нь олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас тайлант онд нийт 197.2 сая ам.долларын урт хугацаатай, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авч, 61.1 сая ам.долларын зээлийг эргүүлэн төлснөөр Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 1,927.2 сая ам.долларт хүрч, 2010 оноос 8 хувиар өссөн байна.

Банкууд эдийн засгийн харъяат бусаас 162.3 ам.долларын зээлийг шинээр авч, 84.4 сая ам.долларын үндсэн зээлийг эргэн төлснөөр банкны секторын гадаад зээлийн үлдэгдэл 333.9 сая ам.долларт хүрчээ. Тайлант онд банкууд эдийн засгийн харъяат бус этгээдэд шинээр зээл олгоогүй бөгөөд урьд олгосон зээлээс 10.5 сая ам.долларын авлагыг буцаан төлүүлсэн байна. Харин аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь мөн онд 263.5 сая ам.долларын урт хугацаат, 630.2 сая ам.долларын богино хугацаат зээл авч, үндсэн зээлийн 606.3 ам.долларын өрийг барагдуулсан. Мөн гадаад худалдаатай холбоотойгоор 185.1 сая ам.долларын экспортын орлого, 221.0 сая ам.долларын импортын урьдчилгаа төлбөрийн авлагууд тус тус үүссэн байна.

Гадаад өр


Эдийн засаг тэлж, томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжих болсонтой уялдан гадаадын зээл, эх үүсвэр нэмэгдэж эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлөхүйц түвшинд хүрсэн тул Монголбанк хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гадаад зээлийг бүртгэх ажлыг 2008 оноос эрчимжүүлсэн билээ. Монголбанк 2011 оны 1 дүгээр улирлаас эхлэн “Монгол Улсын гадаад өрийн статистик, тойм”-ыг нэгтгэж олон нийтэд мэдээлэхдээ “Валютын зохицуулалтын тухай” хуулийн дагуу Засгийн газрын шугамаар авсан гадаад зээл болон хувийн хэвшлийн гадаад зээлийн мэдээллийг тус тус үндэслэл болгож байна.

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2011 оны эцсийн байдлаар 9.6 тэрбум ам.долларт хүрсэн нь 2010 оноос 2.4 дахин өссөн үзүүлэлт болов. Үүнд нөлөөлсөн голлох хүчин зүйлсийг дурдвал хувийн хэвшил (банк, бусад сектор, хөрөнгө оруулагчаас авсан зээл)-ийн гадаад өрийн үлдэгдэл 7.4 тэрбум ам.долларт хүрч 2010 оноос 3.8 дахин, Засгийн газрын баталгаатай (Засгийн газар, Монголбанк) гадаад өрийн үлдэгдэл 2.2 тэрбум ам.долларт хүрч 2010 оноос 8 хувиар тус тус өссөн байна.

Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 9.1 хувиар өсч 1927 сая ам.долларт, ОУВС-гийн урт хугацаат зээлийн өрийн үлдэгдэл 1.2 хувиар өсч 268 сая ам.долларт, банкны секторын гадаад өрийн үлдэгдэл 41.6 хувиар өсч 685 сая ам.долларт, банкнаас бусад сектор (банк бус аж ахуйн нэгж, иргэн)-ын гадаад өрийн үлдэгдэл 68.9 хувиар өсч 994

сая ам.долларт, шууд хөрөнгө оруулагчдын өглөг буюу компани хоорондын зээлийн өрийн үлдэгдэл 6.4 дахин өсч 5748 сая ам.долларт тус тус хүрчээ.


Банкны салбарын гадаад пассивын 86 хувь нь урт хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй бөгөөд үүний 34 хувь нь бонд, өрийн бичиг, 40 хувь нь арилжааны зээлийн хэлцэл, 22 хувь нь харилцах ба хадгаламж, үлдсэн 4 хувь нь бусад өглөгийн эх үүсвэрүүд байна. Гадаад эх үүсвэрийн ашиглалтыг 2011 оны эхнээс нэгтгэн тооцвол 77.7 сая ам.долларын урт, 84.7 сая ам.долларын богино хугацаат зээлийг шинээр авч, эргэн төлөлтийн хуваарийн дагуу 30.8 сая ам.долларын урт, 53.6 сая ам.долларын богино хугацаат үндсэн өр, 15.7 сая ам.долларын хүүгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.



Зураг 34

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдлийн бүтэц (сая ам.доллар)

Эх үүсвэр: Монголбанк



Зураг 35

Банкнаас бусад салбарын гадаад пассивын үлдэгдлийн бүтэц (сая ам.доллар)

Эх үүсвэр: Монголбанк

Банкнаас бусад салбарын гадаад пассив тайлант онд 6742 сая ам.долларт хүрч 2010 оноос 4.5 дахин нэмэгдсэн байна. Гадаад пассивын энэхүү огцом өсөлтийн гол шалтгааныг тайлант оны төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлээр тайлбарлавал:

- Тайлант онд шууд хөрөнгө оруулалтын дансны бусад хөрөнгө оруулалт дэд данс цэвэр дүнгээр 2847.9 сая ам.долларын эерэг урсгалтай байсан. Өөрөөр хэлбэл, Монгол улсын эдийн засгийн харьяат аж ахуйн нэгж, байгууллагууд нь гадаадын

хөрөнгө оруулагчид (толгой компани)-аас 3824.9 сая ам.долларын зээлийн эх үүсвэрийг⁷ шинээр авч, 943.4 сая ам.долларын үндсэн өрийг буцаан төлж барагдуулжээ. Энэхүү зээлийн эх үүсвэр нь ихэвчлэн уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж буй цөөн тооны аж ахуйн нэгжид хамаарч байна.

- Бусад хөрөнгө оруулалтын дансны худалдааны зээл дэд данс цэвэр дүнгээр 406 сая ам.долларын сөрөг урсгалтай гарсан нь манай аж ахуйн нэгж, байгууллагуудын экспортын нийлүүлэлт болон импортын төлбөр барагдуулалтыг илэрхийлж байна.
- Зээл гэсэн дэд данс цэвэр дүнгээр 468.7 сая ам.долларын эерэг урсгалтай байгаа нь аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн харъяат бусаас авсан зээлийн ашиглалт ба урьд авсан зээлийн эргэн төлөлт тэнцвэртэй байгааг илтгэнэ.

Хүснэгт 9: Монгол Улсын гадаад өр, хугацааны эцсийн үлдэгдэл (мянган ам.доллар)

Үзүүлэлт	2008	2009	2010	2010	2011			
			III улирал		I улирал	II улирал	III улирал	IV улирал
Засгийн газар	1,602,179	1,818,076	1,772,756	1,766,993	1,798,322	1,851,688	1,832,380	1,927,195
<i>Богино хугацаат</i>	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний захын хэрэгслүүд	0	0	0	0	0	0	0	0
Зээл	0	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл	0	0	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0	0	0
Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	0	0	0	0	0
Бусад	0	0	0	0	0	0	0	0
<i>Урт хугацаат</i>	1,602,179	1,818,076	1,772,756	1,766,993	1,798,322	1,851,688	1,832,380	1,927,195
Бонд, өрийн бичиг	0	66,248	18,015	18,995	19,979	24,835	24,458	22,434
Зээл	1,602,179	1,751,828	1,754,742	1,747,998	1,778,343	1,826,852	1,807,923	1,904,761
Худалдааны зээл	0	0	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0	0	0
Төвбанк*	752	245,608	265,435	264,494	271,353	272,988	275,385	267,689
<i>Богино хугацаат</i>	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний захын хэрэгслүүд	0	0	0	0	0	0	0	0
Зээл	0	0	0	0	0	0	0	0
Харилцах, хадгаламж	0	0	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0	0	0
Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	0	0	0	0	0
Бусад	0	0	0	0	0	0	0	0
<i>Урт хугацаат</i>	752	245,608	265,435	264,494	271,353	272,988	275,385	267,689
Бонд, өрийн бичиг	0	0	0	0	0	0	0	0
Зээл	752	245,608	265,435	264,494	271,353	272,988	275,385	267,689
Харилцах, хадгаламж	0	0	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0	0	0
Банк	365,849	341,077	275,616	483,612	490,232	567,302	609,283	684,851
<i>Богино хугацаат</i>	66,948	112,705	76,878	76,853	68,462	85,639	96,725	98,516
Мөнгөний захын хэрэгслүүд	0	0	0	0	0	0	0	0
Зээл	66,948	112,705	76,878	76,853	68,462	85,639	96,725	98,516
Харилцах, хадгаламж	0	0	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0	0	0
Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	0	0	0	0	0

7 Энэ нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид компанийн дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдаг.

	Бусад	0	0	0	0	0	0	0	0
	Урт хугацаат	298,902	228,372	198,738	406,760	421,770	481,662	512,559	586,335
	Бонд, өрийн бичиг	87,000	59,000	17,000	198,000	198,000	200,500	200,500	200,500
	Зээл	116,105	115,293	95,377	117,156	127,760	161,131	227,558	235,356
	Харилцах хадгаламж	75,796	22,079	29,361	34,603	39,009	63,032	63,441	129,633
	Бусад өглөг	20,000	32,000	57,000	57,000	57,000	57,000	21,060	20,845
	Бусад сектор	124,475	361,726	296,332	588,437	680,838	880,692	868,665	994,046
	Богино хугацаат	2,675	135,479	1,290	235,966	291,717	476,337	468,493	548,775
	Мөнгөний захын хэрэгслүүд	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
	Зээл	2,675	12,175	1,290	87,404	142,364	263,606	315,303	378,825
	Харилцах хадгаламж	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
	Худалдааны зээл	n/a	123,304	n/a	148,562	149,352	212,731	153,190	169,951
	Бусад өглөг	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
	Хугацаа хэтэрсэн төлбөр	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
	Бусад	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
	Урт хугацаат	121,800	226,247	295,042	352,471	389,121	404,355	400,172	445,271
	Бонд, өрийн бичиг	0	0	0	0	0	0	0	0
	Зээл	121,800	194,732	295,042	328,421	361,939	375,840	397,735	430,452
	Харилцах хадгаламж	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
	Худалдааны зээл	n/a	31,515	n/a	24,050	27,182	28,515	2,437	14,819
	Бусад өглөг	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
	Шууд хөрөнгө оруулалт:	90,259	219,280	601,340	893,399	896,450	4,544,499	5,433,831	5,747,806
	Компани хоорондын зээллэг	90,259	219,280	601,340	893,399	896,450	4,544,499	5,433,831	5,747,806
	Хамааралтай ААНБ-ын өглөг	0	0	0	0	0	0	0	0
	Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	0	0	0	0	0
	Бусад	0	0	0	0	0	0	0	0
	Шууд хөрөнгө оруулагчийн өглөг	90,259	219,280	601,340	893,399	896,450	4,544,499	5,433,831	5,747,806
	Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	0	0	0	0	1
	Бусад	90,259	219,280	601,340	893,399	896,450	4,544,499	5,433,831	5,747,805
	МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ОР	2,183,515	2,985,766	3,211,480	3,996,935	4,137,194	8,117,169	9,019,543	9,621,587

* ОУВС-гийн "Стэнд-бай" хөтөлбөрийн хүрээнд авсан 122.6 сая ЗТЭ-ийн хөрөнгийн эх үүсвэр орсон болно.

Эх үүсвэр: Монголбанк

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2011 оны эцэст⁸ -8,152.2 сая ам.доллар байв. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 8 тэрбум ам.доллараар их байна. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа улсын өрийн үлдэгдлээс голлон хамаарч байна.

Хүснэгт 10: Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц – 2011 оны жилийн эцсийн байдлаар⁹

А. ГАДААД АКТИВ	6,271.8	Б. ГАДААД ПАССИВ	14,423.9
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	1,875.3	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	9,434.5
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин оруулалт	1,873.2	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин оруулалт	3,686.7
1.2 Бусад хөрөнгө	2.1	6.2 Бусад хөрөнгө	5,747.8
2. Багцын хөрөнгө оруулалт	22.8	7. Багцын хөрөнгө оруулалт	956.3
2.1 Хөрөнгийн хувьцаа	22.7	7.1 Хөрөнгийн хувьцаа	714.1
2.2 Өрийн бичиг	0.2	7.2 Өрийн бичиг	242.2
3. Санхүүгийн дериватив	1.5	8. Санхүүгийн дериватив	1.5
4. Бусад хөрөнгө оруулалт	1,524.7	9. Бусад хөрөнгө оруулалт	4,031.6
4.1 Худалдааны зээл	420.2	9.1 Худалдааны зээл	184.8
4.2 Зээл	7.9	9.2 Зээл	3,315.6
4.2.1 Төв банк	0.0	9.2.1 Төв банк	267.7
4.2.2 Засгийн газар	0.0	9.2.2 Засгийн газар	1,904.8
4.2.3 Банк санхүүгийн байгууллага	7.9	9.2.3 Банк санхүүгийн байгууллага	333.9
4.2.4 Аж ахуйн нэгж	0.0	9.2.4 Аж ахуйн нэгж	809.3
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	1,096.6	9.3 Бэлэн мөнгө ба харилцах	510.4
4.4 Бусад актив	0.0	9.4 Бусад пассив	20.8
5. Нөөц актив	2,847.4	В. ПОЗИЦ	(8,152.2)
5.1 Мөнгөжсөн алт	175.9	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	(7,559.2)
5.2 Зээлжих тусгай эрх	69.6	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	(933.5)
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)	0.2	12. Санхүүгийн дериватив (цэвэр)	(0.0)
5.4 Бэлэн валют ба харилцах	1,965.9	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	(2,506.9)
5.5 Үнэт цаас	635.9	14. Нөөц актив	2,847.4
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0		
5.7 Бусад нөөц актив	0.0		

Эх үүсвэр: Монголбанк

Монгол Улсаас эдийн засгийн харъяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 6271.8 сая ам.доллар байна. Үүний 45 хувийг гадаад валютын албан нөөц, 30 хувийг шууд хөрөнгө оруулалт, 24 хувийг бусад хөрөнгө оруулалтын актив тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харъяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 14423.2 сая ам.долларт хүрчээ. Үүний 65 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 28 хувийг бусад хөрөнгө оруулалтын пассив, үлдсэн 7 хувийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 39 хувийг буюу 3686.7 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 61 хувь

⁸ Урьдчилсан гүйцэтгэлээр

⁹ Тайлант хугацааны эцсийн байдлаарх үлдэгдэл дүн

буюу 5747.8 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын өр авлагаасаа давж өмнөх жилээс 4.5 дахин буюу 6.3 тэрбум ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 4.2 хувиар буюу 272.5 сая ам.доллараар буурч, гадаад пассив 1.7 дахин буюу 6.1 тэрбум ам.доллараар нэмэгдсэн,
- Данс тус бүрээр нь авч үзвэл, гадаад валютын албан нөөц 24 хувиар буюу 560.0 сая ам.доллараар нэмэгдсэн хэдий ч гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 395 хувиар буюу 6032.8 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 64 хувиар буюу 973.9 сая ам.доллараар тус тус өссөн,
- Гүйлгээ тус бүрээр нь авч үзвэл, гадаад хөрөнгө оруулалтын богино позиц төлбөрийн тэнцлийн орлого, зарлагын гүйлгээгээр 4847.7 тэрбум ам.доллараар, үнийн өөрчлөлтөөр 764.7 сая ам.доллараар, бусад өөрчлөлтөөр 842.9 сая ам.доллараар тус тус нэмэгдэж, ханшийн зөрүүгээр 111.5 сая ам.доллараар буурсан байна.

Хүснэгт 11: Гадаад хөрөнгө оруулалтын позиц /данс тус бүрээр/

	12/31/2010	03/31/2011	06/30/2011	09/30/2011	12/31/2011
Нийт позиц	-1808.4	-2937.7	-5265.6	-6929.1	-8152.2
Гад. шууд хөр.оруулалтын позиц	-1526.4	-2096.5	-4410.9	-6510.8	-7559.2
Багцын хөр.оруулалтын позиц	-1037.0	-1321.9	-1254.1	-978.0	-933.5
Сан.үүсмэл.хэр-ийн позиц	0.0	0.7	0.0	0.0	0.0
Бусад хөр.оруулалтын позиц	-1533.0	-1863.5	-2142.3	-2046.3	-2506.9
ГВАН-ийн үлдэгдэл	2288.0	2343.5	2541.6	2606.0	2847.4


Эх үүсвэр: Монголбанк

Шигтгээ 3: Дэлхийн эдийн засгийн тойм

Дэлхийн эдийн засаг 2011 онд хурдацтай сэргэнэ гэсэн өөдрөг хүлээлттэй байсан хэдий ч Австралид болсон үер, Украин, ОХУ, Хятад, Пакистан зэрэг орнууд дахь байгаль цаг уурын таагүй нөхцөлөөс шалтгаалсан ургацын бууралт болон ойрхи дорнодын улс төрийн хурцадмал байдлаас улбаатай хүнсний болон газрын тосны үнийн өсөлтөөр өдөөгдсөн инфляцийн дарамттайгаар угтсан билээ. Хэдийгээр Европт өрийн хямралын асуудал ужгираад байсан ч, Грек болон Германы засгийн газрын бондын өгөөжийн зөрүү нь 2010 оны эцэст 2011 оны сүүл үетэй харьцуулахад 12 дахин бага байсан юм. Европын эрх баригчид 2010 оны 5 дугаар сард Грект үүссэн өрийн хямралт нөхцөл байдалд зориулан 110 тэрбум еврогийн тусламжийг илгээсэн ч удалгүй Ирландын асуудал сөхөгдөж улмаар 2010 оны 11 дүгээр сард 85 тэрбум еврогийн тусламжийг баталсан нь байдлыг түр намжаасан боловч өрийн дарамт өндөртэй дараагийн орнууд болох Испани, Португаль руу хөрөнгө оруулагчдын анхаарал хандаж, сөрөг хүлээлтүүд эдгээр улсын бондын хүүг хөөрөгдөж эхэлсэн билээ.

Зураг 36:

Дэлхийн эдийн
засгийн өсөлт



Эх үүсвэр: OYBC

Тайлант оны эхээр Испани улс төсвөө танах санал санаачлага гаргаж, Европын холбооны бонд зах зээлд амжилттай гаран, уг бондын 25 хувийг Япон улс худалдан авахаар болсон зэрэг эерэг алхмууд гарсан хэдий ч 3 дугаар сарын 23-ны өдөр Португалийн ерөнхий сайд төсвөө танах төлөвлөгөөг парламентаараа хэлэлцүүлсэн нь амжилтгүй болж огцроход хүрсэн нь нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлсэн юм. Удалгүй 4 дүгээр сарын 6-ны өдөр Португаль улс Европын холбооноос санхүүгийн тусламж хүссэн гурав дахь улс болсноор евро бүсийн өрийн хямралыг хурцатгалаа.

Хүснэгт 12: Дэлхийн эдийн засгийн өсөлт


	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Дэлхий	4.4	5.0	5.2	3.0	-0.8	5.2	3.8
Хөгжингүй орнууд	2.5	3.0	2.7	0.5	-3.2	3.2	1.6
АНУ	3.1	2.9	2.0	0.4	-2.5	3.0	1.8
Евро бүс	1.5	2.8	2.6	0.6	-3.9	1.9	1.6
Герман	0.8	3.9	3.4	1.2	-4.8	3.6	3.0
Франц	1.9	2.7	2.2	0.3	-2.3	1.4	1.6
Итали	0.7	2.0	1.5	-1.0	-4.8	1.5	0.4
Испани	3.6	4.0	3.7	0.9	-3.6	-0.1	0.7
Япон	1.9	2.4	2.4	-1.2	-5.3	4.4	-0.9
Их Британи	2.2	2.8	3.0	0.5	-4.8	2.1	0.9
Канад	3.0	2.8	2.7	0.4	-2.6	3.2	2.3
Бүрэлдэж буй олон хөгжиж буй орнууд	7.0	7.7	8.3	6.1	2.1	7.3	6.2
Африк /Саб-Сахар/	6.2	6.4	7.1	5.6	2.8	5.4	5.2
Төв болон зүүн европын орнууд	5.6	6.4	5.4	3.1	-4.3	4.5	5.1
ОХУ	6.4	8.2	8.1	5.6	-9.0	4.0	4.1
Хөгжиж буй ази	9.0	9.6	10.6	7.9	6.5	9.5	7.9
Хятад	10.4	11.1	13.0	9.6	8.7	10.4	9.2
Энэтхэг	9.0	9.5	10.0	6.2	6.8	10.1	7.8
АСЕАН-5	5.5	5.7	6.3	4.8	1.7	6.9	5.3
Ойрхи дорнод ба Хойд африк	5.4	6.0	6.7	4.6	2.6	4.4	4.0
Бразил	3.2	4.0	6.1	5.2	-0.6	7.5	3.8
Мексик	3.2	5.2	3.2	1.2	-6.2	5.4	3.8

Эх үүсвэр: ОУВС

Хөгжингүй орнуудад эдийн засгийн өөдрөг дүр зураг ажиглагдах болсон энэ үед хөрөнгө оруулагч нарын үйл хөдлөлтэй уялдан Ази болоод Латин Америкийн орнуудаас хөрөнгийн гадагшлах урсгал ажиглагдаж эхэлсэн байна. Өсөн нэмэгдэж буй инфляцийн дарамт нь мөнгөний бодлогыг хатууруулах хүлээлтийг зах зээлд үүсгэсэн бөгөөд Энэтхэг, Бразил, Хятад гэх мэт улсууд мөнгөний бодлогоо шат дараатайгаар хатууруулсаар байлаа. Бүрэлдэж буй эдийн засагтай¹⁰ голлох орнуудад дотоодын хүүгийн түвшний өсөлттэй уялдан валютын ханшийн чангарах дарамт нэмэгдэж байсан ч ихэнх нь валютын нэрлэсэн ханшийн чангаралтаас сэргийлэх зорилгоор валютын нөөцөө өсгөх бодлогоо үргэлжлүүлжээ.

10 Emerging economies


Зураг 37

Хөгжингүй орнуудын
инфляци

Эх үүсвэр: ОУВС

Анхны үнэлгээгээрээ 1995 оны Кобегийн газар хөдлөлтөөс хоёр дахин их уршигтай, 240 тэрбум ам.долларын хохирол дагуулсан газар хөдлөлт- цунамид Япон улс 2011 оны 3 дугаар сард нэрвэгдэв. Санхүүгийн зах зээл уг гамшигт үзэгдэлд маш хүчтэй хариу үйлдэл үзүүлж гамшгийн дараах хоёр өдрийн байдлаар Токиогийн хөрөнгийн биржийн индекс бараг 20 хувиар унаж, засгийн газрын үнэт цаасны хүү өсч эхлээд байлаа. Түүнчлэн, Японы даатгалын компаниуд АНУ-ын сангуудад байршуулсан гадаад валютын активаа эргэн дуудаж, дотоодын иений зардлаа санхүүжүүлнэ гэсэн хүлээлттэй уялдаж бий болсон валютын ханшийн дайралт эрчимжсэнээр Японы иенийн ханш ам.долларын эсрэг огцом чангарч эхэлсэн юм.


Зураг 38

Бүрэлдэж буй болон
хөгжиж буй эдийн
засагтай орнуудын
инфляци


Эх үүсвэр: ОУВС

Үүссэн нөхцөл байдалтай уялдан Японы төв банкнаас гамшгийн дараах эхний долоо хоногт мөнгөний захын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахын тулд нийт 82.4 их наяд иенийн санхүүжилтыг санал болгосноос 57.8 их наяд иен нь зах зээлд нийлүүлэгдсэн байна. Мөн иенийн ханшийн огцом чангаралтын эсрэг интервенц хийх, гамшигт өртсөн аж ахуйн нэгжүүдэд зориулан 1 их наяд иенийн хөнгөлөлттэй зээлийн суваг бий болгох, мөнгөний зах дээрх зөвшөөрөгдсөн барьцаа активын нэр төрлийг өргөтгөх, гамшгийн дараах бүтээн байгуулалтанд зориулж 4 их наяд иенийн нэмэлт төсөв батлах зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд, зах зээлд


үүссэн нөхцөл байдал тогтворжих хандлагатай болж, 3 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар ам.долларын эсрэг 76.3 хүрч чангараад байсан иенийн ханш 4 дүгээр сард 82-83 түвшинд хүртэл суларсан юм.



Эх үүсвэр: Блүмберг



Эх үүсвэр: Блүмберг, OYBC



Эх үүсвэр: Блүмберг

Зураг 39

Валютын ханш

Зураг 40

Бүтээгдэхүүн,
түүхий эдийн үнэ

Зураг 41

Хөрөнгийн зах
зээлийн индекс

Зураг 42

Санхүүгийн зах
зээлийн хэлбэлзэл



Эх үүсвэр: Блүмберг

Япон улсад тохиолдсон гамшгаас шалтгаалан хагас дамжуулагч, электроникийн эд ангиуд, автомашин гэх мэт өндөр технологийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг үндэстэн дамнасан зарим корпорациудын бүтээгдэхүүний үйлдвэрлэл саатах, зогсох үзэгдэл гарсан нь дэлхийн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Зураг 43

Евро бүсийн
ЗГ-ын бондын спрэд



Эх үүсвэр: Блүмберг, ОУВС

Зураг 44


Төсвийн тэнцлийн
ДНБ-д эзлэх хувь



Эх үүсвэр: ОУВС



Эх үүсвэр: ОУВС



Эх үүсвэр: Блүмберг, ОУВС

Евро бүсийн асуудал, Японд тохиолдсон байгалийн гамшиг, ойрхи дорнодын улс төрийн тогтворгүй байдалтай уялдан зах зээлд сөрөг хүлээлтүүд үүссэн үед АНУ-ын эдийн засгийн өсөлт удааших шинж тэмдгүүд илэрч, улмаар 2011 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Стандарт-Энд-Пүүрс АНУ-ын ААА зээлжих зэрэглэлийг сөрөг хандлагатай хэмээн үнэлсэн. Зэрэглэлийг нь ийнхүү сөрөг хандлагатай гэж үнэлэх болсон өөр нэгэн хүчин зүйл нь холбооны нөөцийн сангаас санхүүгийн актив худалдан авах хоёр дахь хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон явдал байлаа. Эцсийн дүнд АНУ-ын эдийн засгийн өсөлтийн 2011 оны таамаглалууд дунджаар 0.25 хувиар буурсан юм.

Тайлант оны гуравдугаар улиралд дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал муудаж байгааг илтгэсэн тайлан, статистик тоо баримт, судалгаа ар араасаа гарсаар байлаа.

Евро бүсийн орнуудын төсвийн зардлаа хумих бодлого, банк, санхүүгийн байгууллагуудын эрсдэлтэй актив, хүлээж буй санхүүгийн хариуцлага, өр төлбөрөө бууруулахаар хийж буй хүчин чармайлт нь зээл олголтыг бууруулах, санхүүжилтийн зардлыг өсгөх, банк хоорондын захын үр ашгийг муутгах зэргээр эдийн засагт сөргөөр нөлөөлж, өрийн хямралыг улам даамжруулах эрсдэлтэй байсан байна. Түүнчлэн евро

Зураг 45

Засгийн газрын өрийн
ДНБ-д эзлэх хувь

Зураг 46

Бодлогын хүү

бүсийн банкуудын бүрэлдэж буй болон хөгжиж буй орнууд дахь салбаруудын аж ахуйн нэгж, иргэдэд олгож буй зээл хумигдаж байгаа нь тэдгээр орнуудын өсөлтөд сөргөөр нөлөөлж буйг шинжээчид сануулж байв.

Зураг 47

Бараа, түүхий
эдийн үнийн мөчлөг




Эх үүсвэр: Блүмберг, ОУВС

2011 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Испани болон Италийн засгийн газрын бондын өгөөж 6.2 хувьд хүрч огцом өслөө. Цаашлаад Бельги, Франц, тэр ч байтугай Скандинавын орнуудын эзэмшилд байдаг банк, санхүүгийн байгууллагуудын хувьцаа болон бондыг зарах үзэгдэл эрчимжиж, өрийн хямрал европ тивийг бүхэлд нь хамарсан шинжтэй болж ирсэн. Энэ үеэр евро бүсийн болон евро бүстэй холбоотой санхүүгийн позиц барьж буй банк, санхүүгийн байгууллагуудын зээлжих зэрэглэл дараалан буурсаар байв. Иймд 8 дугаар сарын 12-ны өдөр евро бүсийн нөхцөл байдал нь хүндэрсэн 4 орны зарим санхүүгийн хэрэгсэлд богино позицийг хориглох шийдвэр гарсан байна.


Зураг 48

Валютын нөөц



Эх үүсвэр: Блүмберг, ОУВС


2011 оны 8 дугаар сарын 2-ны өдөр АНУ-ын ерөнхийлөгч засгийн газрын өрийн дээд хэмжээг өсгөхийн зэрэгцээ төсвийн алдагдал бууруулах төлөвлөгөөнд гарын үсэг зурсан. Үүнтэй уялдан ердөө 4 өдрийн дараа Стандарт-Энд-Пүүрс АНУ-ын AAA зээлжих зэрэглэлийг AA+ болгож түүхэндээ анх удаа бууруулжээ.



Эх үүсвэр: ОУВС

Эрсдэл багатай хөрөнгө оруулалт руу хошуурах болсон үед зарим улсуудын валютын ханшид огцом чангарах дарамт нэмэгдэж байв. Энэ үеэр Япон улс интервенцийн хэмжээг 10 их наяд иенээр нэмэгдүүлсэн бол Швейцарийн төв банк франкийн евротой харьцах ханшийг 1.2 түвшнээс чангаруулахгүй гэсэн зорилтот түвшинд интервенц хийж эхэлжээ.

Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч буйтай уялдан ихэнх орнуудад инфляци өсөх хүлээлт тогтворжиж, мөнгөний бодлогын төлвийг өөрчлөхгүй байх, улмаар сулруулах шийдвэрүүд зонхилж байлаа.



Зураг 49



Урсгал тэнцэл,
газар зүйн
ангиллаар

Зураг 50

Дэлхий нийтийн
үйлдвэрлэл ба
хэрэглээний
тэнцвэргүй байдал

Зураг 50

Дэлхий нийтийн
үйлдвэрлэл ба
хэрэглээний
тэнцвэргүй байдал



Эх үүсвэр: ОУВС

2011 оны 8 дугаар сарын 9-ний өдөр Холбооны нөөцийн сангаас бодлогын хүүг дор хаяж 2013 оны дунд үе хүртэл одоогийн бага түвшинд барихаар зорьж буй талаар мэдэгдэл хийсэн. Эдийн засгийн өсөлтийн удаашрах төлөвтэй зэрэгцэн дэлхийн зах зээл дэх бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ буурсаар байлаа. 2011 оны 4 дүгээр улирал, оны төгсгөл гэхэд хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлтийн удаашралт дээр нэмэгдээд бүрэлдэж буй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын өсөлт удаашрах хандлага бий болсон бөгөөд санхүүгийн зах зээлийг евро бүсийг тойрсон асуудал бүхэлд нь удирдаж байлаа. Бүрэлдэж буй болон хөгжиж буй эдийн засгуудын өсөлт удаашрах энэхүү сөрөг хүлээлтэд Хятадын экспортын бууралт, Тайландад болсон үерийн гамшиг голлох нөлөөг үзүүлсэн байна.

Олон орны засгийн газар эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын алхмуудыг хийж эхэлсэн ба ихэнх хөгжингүй орнуудын хувьд бодлогын хүүг бараг тэглэсэн учир эдийн засгаа дэмжихийн тулд уламжлалт бус /unconventional/ мөнгөний бодлогын арга хэрэгсэл ашиглах талаар мэдэгдэл хийж эхэлсэн юм. Жишээлбэл: 9 дүгээр сарын 21-ний өдөр Холбооны нөөцийн сан 400 тэрбум ам.долларын засгийн газрын үнэт цаасыг худалдаж авсан, 10 дугаар сарын 6-ны өдөр Английн төв банк актив худалдан авах хөтөлбөрөө 75 тэрбум фунтээр өсгөсөн, Японы төв банк 10 дугаар сарын 27-ны өдөр актив худалдан авах хөтөлбөрөө 5 тэрбум иенээр нэмэгдүүлсэн байна. Харин Австрали, Европын холбоо, Бразил, Индонез, Израйль гэх мэт хэд хэдэн орны төв банкууд бодлогын хүүгээ бууруулах замаар мөнгөний бодлогыг зөөлрүүлжээ.

2011 оны 10 дугаар сарын 26-ны өдөр евро бүсийн дээд хэмжээний уулзалт болж Грекийн өрийн дарамтыг бууруулах, Евро бүсийн санхүүгийн тогтворжилтын санг өргөжүүлэх, банкны секторт итгэх итгэлийг бэхжүүлэн хадгалах гэсэн гурван үндсэн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг баталсан. Энэхүү шийдвэр нь зах зээлд зарим эерэг хүлээлтийг бий болгосноор санхүүгийн зах зээлд нааштай үзүүлэлтүүд харагдаж эхэлсэн ч энэ нь удаан үргэлжлээгүй юм. 11 дүгээр сарын 1-ний өдөр Грект бүх нийтийн санал асуулга явуулахаар болсон тухай мэдээ, цаашлаад тус улсын болон Италийн засгийн газрууд огцорч, гүйцэтгэх засаглалыг шинээр эмхлэн байгуулсан зэрэг улс төрийн тогтворгүй байдал үүссэн нь санхүүгийн зах зээл дэх сөрөг хүлээлт, тодорхой бус байдлыг улам бүр гүнзгийрүүлсэн.

2011 оны 11 дүгээр сард евро, ам.долларын свопын зардал 2008 оны 12 дугаар сараас хойшхи хугацааны хамгийн оргил түвшиндээ хүрсэн нь евро бүсийн банкуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж эхэлсэн байна. Олон улсын хэмжээнд валютын захын хөрвөх чадварыг хангахын тулд Холбооны нөөцийн сан, Канад, Япон, Швейцарь, Англи зэрэг улсууд хамтран тухайн валютын овернайт свопын хүүн дээр 0.5 хувийн нэмэгдэлтэйгээр своп хэлцлийн шугамуудыг нээсэн нь зах зээлд эерэгээр нөлөөлж, тэр өдөртөө голлох хөрөнгийн захын индексүүд 3-4 хувиар өссөн билээ. Уг шугамыг нээснээр евро, ам.долларын своп премиум л гэхэд 1.51 хувиас 1.19 хувь болж буурсан байна.

2011 оны сүүл гэхэд европын хөрөнгө оруулагч нар бүрэлдэж буй эдийн засагтай орнуудаас хөрөнгө оруулалтаа эргэн дуудах үзэгдэл ажиглагдсан. Холбогдох төлбөрийн тэнцлийн тоо баримтаар бол тэдгээрийн зонхилох хэсэг нь Франц руу шилжсэн байна. Үүнээс шалтгаалан тэдгээр улсуудын валютын ханш огцом сулрах дарамт бий болсон бөгөөд Бразил, Унгар, Индонез, Өмнөд Солонгос, ОХУ, Турк зэрэг хэд хэдэн орнууд ханшийн огцом сулралтыг сааруулах зорилгоор интервенц хийжээ.

ОУВС-гийн эдийн засгийн зөвлөх, судалгааны газрын захирал Оливер Бланчард 2011 оны евро бүсийн өрийн хямралын үйл явцыг нийтэд тайлбарлахдаа нөхцөл байдлын талаар буруу дүгнэлт хийх нь сөрөг үр дагавар гарах үндсэн шалтгаан болж байна, нэгэнт бий болсон ойлголт ба үзэл санаа нь өөрийн эрчмээрээ бодит байдалд биеллээ олж байна, бодлогын бүрэн гүйцэд бус, хэсэгчилсэн арга хэмжээ нь нөхцөл байдлыг улам бүр муутгаж байна, төсвийн огцом хумих бодлого нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх бөгөөд улсын өрийн асуудлыг богино хугацаанд шийдэх бус, харин урт хугацааны тууштай бодлогын үр дүнд шийдвэрлэх ёстой гэж дүгнэжээ.

Эцэст нь хэлэхэд бид бүхэн 2011 оны эхэнтэй харьцуулахад дэлхийн эдийн засгийн илүү тааламжгүй, тодорхой бус, эрсдэлтэй нөхцөл байдалтайгаар 2012 оныг угтаж байна.

1.4 Хөрөнгийн зах зээлийн хөгжил

Монголын Хөрөнгийн Бирж 2011 онд үнэт цаасны 252 удаагийн арилжаа явуулж 148 компанийн 122.8 сая ширхэг хувьцааг 109.1 тэрбум төгрөгөөр, 2.4 сая ширхэг Засгийн газрын бондыг 236.7 тэрбум төгрөгөөр, 439.5 мянган ширхэг компаний бондыг 4.4 тэрбум төгрөгөөр арилжиж, нийт 350.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийжээ. Засгийн газрын бондын арилжааны хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 206.7 тэрбум төгрөг буюу 7.9 дахин, хувьцааны арилжаа 46.2 тэрбум төгрөг буюу 73.4 хувиар нэмэгджээ. Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оноос 794.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 2168.6 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 20 хувь байна. Таван толгой, АПУ, Багануур, Шивээ овоо, Шарын гол зэрэг нь зах зээлийн үнэлгээ өндөр компаниудад орж байна.


Хүснэгт 13: Арилжааны гүйлгээ /тэрбум төгрөг/

	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт	
	2010	2011	Үнийн дүнгээр	Хувиар
ЗГ-ын бонд	30	236.7	206.7	7.9 дахин
Хувьцаа	62.9	109.1	46.2	73.4
Компаний бонд		4.4		

Эх үүсвэр: Монголын Хөрөнгийн Бирж

ТОП-20 үнийн индексийн үзүүлэлт оны эцэст 21687.57 болж, өмнөх оноос 46.9 дахин нэмэгдсэн байна. ТОП-20 индекс Баянтээг, Сүү, Талх чихэр, Могойн гол, Ремикон, АПУ, Таван толгой, Монгол шилтгээн, Баянгол зочид буудал, Би Ди Сек, УИД, Багануур, Шивээ овоо зэрэг ХК-иудын үнэт цаасны үнэ өссөн тул нэмэгдлээ. ТОП-20 үнийн индексийн 2011 оны дундаж 21420.81 байв.

Зураг 51
ТОП 20 индекс,
2011 онд



Эх үүсвэр: Монголын Хөрөнгийн Бирж

Засгийн газрын бондын 14 удаагийн арилжаагаар “4000 төрийн албан хаагчдыг орон сууцны урт хугацаат зээлд хамруулах” хөтөлбөрийн санхүүжилтэд 65.0 тэрбум төгрөгийн бонд, ноос ноолуурын болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтэд 171.7 тэрбум төгрөгийн бонд арилжиж, нийт 236.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.4 сая ширхэг бондыг арилжжээ. Жаст агро, Монгол мах компаниудын 439.5 мянган ширхэг бондыг 2011 онд 4.4 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

Тайлант хугацаанд 148 компанийн үнэт цаас арилжигдсанаас 129 компанийн үнэт цаасны ханш өсч, 13 компанийн үнэт цаасны ханш буурч, 6 компанийн үнэт цаасны ханш тогтмол байв. Хувьцааны арилжааны өдрийн дундаж нь хувьцааны тоо ширхгээр 487.2 мянга, үнийн дүнгээр 432.9 сая төгрөг байв.

Хүснэгт 14: Идэвхтэй арилжигдсан үнэт цаас (тоо ширхэгээр)

Д/д	Үнэт цаасны компани	Тоо ширхэг /сая ширхэг/
1	Ремикон	33.3
2	Гермес центр	26
3	Силикат	17.8
4	Бэрх уул	10.2
5	Женко тур бюро	5.6

Эх үүсвэр: Монголын Хөрөнгийн Бирж

Хүснэгт 15: Идэвхтэй арилжигдсан үнэт цаас (үнийн дүнгээр)

Д/д	Үнэт цаасны компани	Үнийн дүн /тэрбум төгрөг/
1	Шарын гол	51.7
2	Багануур	10.1
3	АПУ	7.6
4	Таван толгой	4.7
5	Ремикон	4.5

Эх үүсвэр: Монголын Хөрөнгийн Бирж

2.1 Мөнгөний бодлогын зорилт, хэрэгжилт

Мөнгөний бодлогын үндсэн зорилт

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино” гэж заасан байдаг. Энэ нь төгрөгийн дотоод худалдан авах чадвар буюу дотоодын инфляциар хэмжигдэх үнийн тогтвортой байдлыг хангах зорилт юм. Инфляцийг нам, тогтвортой түвшинд барих нь хүн амын орлогын бодит худалдан авах чадварыг бууруулахгүй байх, орлогын зохисгүй хуваарилалтаас сэргийлэн нийгмийн доод давхаргынханд очих дарамтыг багасгах ач холбогдолтой бөгөөд инфляци тогтвортой түвшинд байснаар үр ашиггүй зардлаас зайлсхийх, эдийн засаг дахь тодорхой бус байдлыг бууруулах замаар дунд хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нэг чухал нөхцөл болдог.

Иймээс жил бүрийн “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д инфляцийн тоон зорилтыг тодорхойлж байна. Тухайлбал, “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэл”-д “ХҮИ-ээр хэмжигдэх инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх”-аар заасан бөгөөд энэ зорилтыг хангахын тулд сүүлийн жилүүдэд ихээхэн хүч тавин ажилласны үр дүнд 2011 онд инфляцийг зорилтот түвшний ойролцоо барьж чадсан. Харин валютын ханшийн хувьд “макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчим”-ыг баримтлан ажиллаж байна.

Мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүн

Тайлант онд Монголбанк үнийн тогтвортой байдлыг хангах буюу инфляцийг зорилтот түвшинд байлгах, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээг авч ажиллалаа. Төсвийн өндөр зардал, ялангуяа Хүний хөгжил сангаас олгосон бэлэн мөнгө болон хувийн хэвшлийн эрэлтээр өдөөгдсөн нийт эрэлт нь инфляцид өсөх дарамтыг учруулж байсантай зэрэгцэн төрийн зохицуулалттай зарим бараа, үйлчилгээний болон хүнс, шатахууны үнэ өсч байсан тул Монголбанк тайлант онд мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлэв.

Тайлант оны эхний хагаст инфляцийн түвшин нэмэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн. Нэгдүгээрт, цагаан сарын баяртай холбоотойгоор өрхийн хэрэглээ нэмэгдсэнээс өргөн хэрэглээний хүнсний бараа (ялангуяа мах)-ны үнэ өссөн, Засгийн газраас махны нөөц бүрдүүлсэн хэдий ч зүүн аймгуудад малын шүлхий өвчин гарсан нь оны эхэнд махны үнийг нэмэгдүүлэх шалтгаан болов. Түүнчлэн, дэлхийн зах зээл дээр нефть, хүнсний барааны үнэ өсөх хандлагатай байв. Хоёрдугаарт, 2011 оны батлагдсан төсвийн нийт зардал өмнөх оноос 33 хувь буюу 1017.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, урсгал зардлын нийт зардалд эзлэх хувь өндөр, иргэдэд бэлэн мөнгөний тэтгэмж үргэлжлэн олгосон нь инфляцийн дарамтыг нэмэгдүүлэх бас нэг хүчин зүйл болов. Гуравдугаарт, уул уурхайн салбарын томоохон төслүүдийн нөлөөгөөр өсөн нэмэгдсэн хөрөнгийн дотогш урсгал нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг нэмэгдүүлэн, улмаар зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн. Тухайлбал 2011 оны эхний хагас жилийн байдлаар M2 мөнгөний жилийн өсөлт өнгөрсөн оны мөн үеэс 1.5 дахин, банкуудын зээлийн өсөлт 4.5 дахин нэмэгдсэн байна. Ийнхүү инфляци тайлант

оны эхний хагаст төрийн зохицуулалттай зарим барааны үнийн өсөлт, эрэлтийн талын хүчин зүйлсийн нөлөөгөөр голчлон өдөөгдсөн байна. Ийм нөхцөл байдалд Монголбанкнаас дараах арга хэмжээг авсан. Үүнд:

1. 2011 оны 2 дугаар сард төсвийн тэлэх бодлого, ялангуяа иргэдэд олгох мөнгөн тэтгэмж, уул уурхайн бүтээн байгуулалтын нөлөөгөөр нэмэгдсэн дотоод эрэлт, худалдааны гол түнш (БНХАУ) орны инфляци, дэлхийн зах зээл дээрх хүнс, нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт зэргээс шалтгаалсан инфляцийн дарамтыг бууруулах зорилгоор мөнгөний бодлогын төлвийг чангаруулж, заавал байлгах нөөцийн хувийг хэмжээг 4 нэгж хувиар нэмэгдүүлэн 9 хувьд хүргэсэн. Бодлогын энэхүү арга хэмжээ нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, түүний хямралд өртөмтгий эмзэг байдлыг багасгах, гадны гэнэтийн сөрөг нөлөөлөлд цочрохгүй байх чадварыг нэмэгдүүлэх давхар зорилготой байв.
2. 2011 оны 4 дүгээр сард мөнгө, зээлийн өсөлтийн хурдацыг сааруулах, дунд хугацааны макро эдийн засгийн хэт халалтаас сэргийлэх, эдийн засгийн огцом идэвхжилээс шалтгаалан нэмэгдэж буй суурь инфляцийн өндөр дарамтыг бууруулан эдийн засгийн дунд хугацааны тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн агентуудын инфляцийн хүлээлтийг бууруулах зорилгоор бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 11.5 хувьд хүргэн мөнгөний бодлогыг дахин чангаруулсан.

Тайлант оны сүүлийн хагаст мөнгөний бодлогыг мөн чангаруулах чиглэлд барьсан нь дараах хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Нэгдүгээрт, Хүний хөгжил сангаас олгосон мөнгөн тэтгэмж, төсвийн өндөр зарлага, хувийн хэвшлийн эрэлт өссөөр байсан нь нийт эрэлтийг нэмэгдүүлсэн, мөн төрийн зохицуулалттай зарим барааны үнэ өссөнөөс суурь инфляци 2011 оны 3-7 дугаар саруудад тасралтгүй өсч 7 дугаар сард 12 хувьд хүрсэн. Хоёрдугаарт, хэрэглээний үнийн хэлбэлзэл махны үнийн нөлөө өндөр хэвээр байж, оны сүүлийн хагаст буурдаг олон жилийн хэв шинжээ эвдэн тайлант оны сүүлийн хагасын турш өндөр байв. Мөн шатахууны үнэ өссөнөөс тээврийн үйлчилгээний үнэ нэмэгдэн тээврийн зардлаар дамжин бусад бараа, үйлчилгээний үнэ өсөхөд нөлөөлсөн. Гуравдугаарт, хувийн секторт олгосон зээлийн өсөлт ДНБ-ий өсөлтөөс давж гарснаар хэт халалтыг бий болгохуйц нөхцөл бүрдсэн. 2011 оны эцсийн байдлаар нийт зээлийн жилийн өсөлт 72.8 хувь, хувийн секторт олгосон зээлийн өсөлт 67.5 хувь байсан бол нэрлэсэн ДНБ-ий өсөлт 28.7 хувь гарсан.

Дээрх эрэлт, нийлүүлэлтийн гаралтай хүчин зүйлсийн нөлөөгөөр хүлээгдэж буй инфляцийн дарамт эрчимжиж, хамрах хүрээ өргөссөн тул Монголбанк дараах бодлогын арга хэмжээг оны сүүлийн хагаст авч хэрэгжүүлэв. Үүнд:

1. 2011 оны 8 дугаар сард инфляцийн хүлээгдэж буй дарамтыг бууруулах, эдийн засгийн халалтыг сааруулахын зэрэгцээ түүнийг дагасан санхүүгийн салбарын эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, эрчимтэй нэмэгдэж буй хэрэглээний импортын улмаас төгрөгт ирж буй сулрах дарамтыг багасгах зорилгоор бодлогын хүүг 0.25 нэгж хувиар өсгөж 11.75 хувьд, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 11 хувьд тус тус хүргэв.
2. 2011 оны 10 дугаар сард 2011 оны төсвийн тодотгол, 2012 оны төсвийн төсөл мөчлөг дагасан байгаагаас нийт эрэлт, улмаар инфляци улам эрчимжихээр байгаа, гадаад эдийн засгийн таагүй байдлаас шалтгаалан валютын орох урсгал татарч

болзошгүйгээс төгрөгийн ханш сулрах дарамт бий болж байгаа тул макро эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор бодлогын хүүг 0.5 нэгж хувиар өсгөн 12.25 хувьд хүргэсэн.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2011 оны эцэст ХҮИ-ээр тооцсон инфляци улсын хэмжээнд жилийн 10.2 хувь, Улаанбаатар хотод 11.1 хувьд хүрч өмнөх оноос харгалзан 3.2 болон 2.7 нэгж хувиар буурлаа. Үнийн өсөлтийн 36.5 хувийг хүнсний барааны үнийн өсөлт бий болгов. Хувцас, бөс барааны үнийн өсөлт инфляцийн 18.3 хувийг, тээврийн үйлчилгээний үнийн өсөлт 16.5 хувийг, орон сууц, ус цахилгааны үнийн өсөлт 12.1 хувийг тус тус бий болгожээ. Үүнээс махны үнийн өсөлт дангаараа инфляцийн 3.4 нэгж хувь буюу 30.6 хувийг бүрдүүлсэн байна.

Макро зохистой бодлогын арга хэмжээ

Санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, системийн эрсдэл нэгэнт үүсэх нь гарцаагүй болсон тохиолдолд түүнд бэлтгэлтэй байх, улмаар тэрхүү эрсдэлийг хохирол багатайгаар даван туулах нь макро зохистой бодлогын үндсэн зорилт юм. Олон улсын туршлагаас үзэхэд санхүүгийн хөрөнгийн дотогш урсгал өндөртэй, бодит секторын бүтээмж хурдан нэмэгдэж байгаа үед нийгмийн амьжиргааг хамгаалахад мөнгөний бодлогын сонгодог хэрэгслүүд бүрэн хангалттай үр дүн өгөхгүй байна. Үүний улмаас макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлогын хэрэгслүүдтэй хавсран хэрэглэж санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах Европын төв банкны туршлага ихээхэн дэлгэрэх боллоо. Нэн ялангуяа, даяаршил гүнзгийрэх тусам санхүүгийн эх үүсвэр хил дамжин чөлөөтэй шилжих болсон орчинд улс дамнасан харьцангуй өгөөж нэмэгдэхийг даган урсч байгаа хөрөнгө тухайн улсын мөнгөний нийлүүлэлтийн үнэд шууд нөлөөлөн мөнгөний бодлогын сонгодог хэрэгслүүдийн үр ашгийг бууруулах болсон. Сүүлийн хямралын дараа энэ бодлого нь урт хугацаанд хамтын хариуцлага бүхий нэгдсэн макро бодлогыг цогцоор нь бүрдүүлж, түүнийг тууштай даган биелүүлэх үндсэн сонголт болоод байна.

Хөрөнгийн орох урсгал ихтэй, ханш чангарах хүлээлттэй зэрэгцэн төсвийн тэлэх бодлого тасралтгүй үргэлжилж буй манай улсын хувьд мөчлөг сөрсөн мөнгөний бодлогын арга хэмжээнээс гадна макро зохистой арга хэрэгслүүдийг цогцоор нь авч хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байна. Тиймээс Монголбанк тайлант онд эдийн засагт халалтын шинжүүд үүсч, зээлийн эрчимжилт ихэссэн тул зээлийн мөчлөгт чиглэсэн макро зохистой бодлого явуулах нь оновчтой гэж үзэн зээлийн өсөлтийн хурдацыг сааруулах арга хэрэгслүүд дундаас санхүүгийн зуучлалд дарамт багатай, илүү үр дүнд хүрэх хэрэгслийг сонгох бодлого баримталсан. Тайлант онд Монголбанк макро зохистой бодлогын хүрээнд эдийн засгийн халалт үүсэхээс сэргийлэх, халалтын шинж тэмдгийг намжаах зорилгоор дараах макро зохистой арга хэмжээг авсан байна. Үүнд:

1. 2011 оны 2, 8 дугаар сард мөчлөг сөрсөн байдлаар мөнгөний бодлогыг чангаруулан, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тус тус 4 ба 2 нэгжээр, нийт 6 нэгж хувиар өсгөх арга хэмжээг авсан. Эдийн засгийн төлөв байдал, түүний гол үзүүлэлтүүдийн төсөөлөлд үндэслэн шат дараалан авсан энэхүү арга хэмжээ нь хүлээгдэж буй зээлийн өсөлтийн хурдыг сааруулах, эдийн засгийн бууралтын үед хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, тодорхой нөөцийг эдийн засгийн тэлэлтийн үед бий болгох, мөнгөний бодлогын зорилтыг биелүүлэхэд туслах зэрэг давуу талуудтай.
2. 2011 оны 11 дүгээр сард банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой

харьцааны доод хэмжээг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 7 нэгж хувиар нэмэгдүүлж 25 хувь болгов.

3. 2011 оны 12 дугаар сард нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 7 хувьд, 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 8 хувьд, 2013 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 9 хувьд хүргэж, мөрдүүлэхээр тогтоосон. Мөн сүүлийн 6 сарын турш банкны системийн активын 5 хувиас дээш хувийг бүрдүүлж байгаа банкинд нэмэлт өөрийн хөрөнгийн хэмжээг 2013 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хагас жил тутам харгалзан 0.5 хувь, 1 хувь, 2 хувиар тогтоож, нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг 14 хувьд хүргэв.

Макро зохистой бодлогын эцсийн зорилго нь санхүүгийн тогтвортой байдал бөгөөд банк давамгайлсан санхүүгийн салбарын бүтэцтэй манай орны хувьд банкны системийн тогтвортой байдал өндөр байр суурь эзэлдэг. Иймд банкны салбарын чадавхийг бэхжүүлэх зорилгоор эдийн засгийн өсөлтийн энэ үед банкуудын хөрвөх чадварын зохистой харьцаа болон өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь макро зохистой бодлогын нэг арга хэмжээ юм.

3.1 Валютын ханшийн бодлого

Төгрөгийн валюттай харьцах ханшийн уян хатан бодлого нь макро эдийн засгийн ерөнхий тэнцвэрийг зах зээлийн зарчмаар хангах, аливаа гадаад зах зээлийн сөрөг өөрчлөлтийн нөлөөллийг төгрөгийн валюттай харьцах ханшаар дамжуулан шингээх замаар эдийн засгийн дунд ба урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, хямралаас урьдчилан сэргийлэх суурь нөхцөл нь болдог билээ. Ийм ч учраас Төрөөс мөнгөний бодлогын талаар сүүлийн жилүүдэд баримталсан үндсэн чиглэлд “Төгрөгийн валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлөөр тодорхойлогдон уян хатан тогтож байх”-аар заасан бөгөөд Монголбанк уг бодлого зарчмыг тууштай хэрэгжүүлсээр ирлээ.

Монгол Улсын эдийн засаг 2011 онд 17.3 хувиар хурдацтай өсч, банкуудын зээлийн үлдэгдлийн өсөлт 72.8 хувьд хүрэхийн зэрэгцээ улсын төсөв огцом тэллээ. Төсвийн энэхүү огцом тэлэлт нь дотоодын эрэлт, хэрэглээг нэмэгдүүлснээр бараа бүтээгдэхүүний үнэ өсөх дарамтыг нэмэгдүүлж, төгрөгийн валюттай харьцах ханшийг 2011 оны 8 дугаар сараас эхлэн сулруулах чиглэлд нөлөөлсөн дотоод суурь шалтгаан болсон.

Нөгөө талаар, 2011 онд Монгол Улсын урсгал тэнцлийн алдагдал 2.6 тэрбум ам.долларт хүрч 2010 оноос 2.9 дахин өсөн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувьтай тэнцэх хэмжээнд, гадаад худалдааны алдагдал 1.7 тэрбум ам.долларт¹¹ хүрч 4.6 дахин өссөн бол эдийн засагт цэвэр дүнгээр орж ирсэн валютын хэмжээ 2010 оноос 1.2 тэрбум ам.доллараар буюу 4 дахин буурч 403 сая ам.доллартай тэнцэх хэмжээнд хүрсэн байна. Хэдийгээр эдийн засагт орж ирсэн валютын урсгал 40 хувиар өссөн ч эдийн засгаас гадагшлах валютын урсгал 75 хувиар өссөн нь бараа бүтээгдэхүүний импортын эрэлт огцом өсч, үйлчилгээний төлбөр, зээлийн төлбөр хэлбэрээр гадагшлах валютын хэмжээ огцом нэмэгдсэнтэй холбоотой байна. Макро эдийн засгийн суурь нөхцөл ийнхүү төгрөгийн валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд үйлчилсэн юм. Түүнчлэн, дэлхийн зах зээлд ам.долларын ханш бусад голлох валютын эсрэг чангарсан нь төгрөгийн ханш ам.долларын эсрэг сулрахад нөлөөлсөн гадаад хүчин зүйл болжээ. Тухайлбал, ам.долларын ханш дэлхийн голлох валютын эсрэг 2011 оны 5 дугаар сарын эхнээс 2011 оныг дуусталх 8 сарын хугацаанд 10 хувиар, зөвхөн 9 дүгээр сард 6 хувиар, 2011 оны 9 дүгээр сарын эхнээс 2012 оны 1 дүгээр сарын дунд үе хүртэлх 4.5 сарын хугацаанд 9.4 хувиар тус тус чангарчээ.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан стратегийн болон томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт хувь хүртээх зорилгын хүрээнд “Хүний хөгжил сангийн тухай” хуулийг 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр баталж, тус санг бүрдүүлэх санхүүжилтийн эх үүсвэр болон сангаас Монгол улсын иргэнд хишиг, хувь хүртээх хэлбэрийг хуульчилсан.

Хүний хөгжил сангаас 2010 онд иргэн бүрт 120 мянган төгрөгийг бэлнээр олгож, иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөхөд нийт 316.0 тэрбум төгрөгийг зарцуулсан бол 2011 онд иргэн бүрт 252.0 мянган төгрөгийг бэлнээр олгож, орон сууц худалдаж авахад хөнгөлөлт үзүүлэх, оюутны сургалтын төлбөр төлөх зэрэгт нийт 804.0 тэрбум төгрөг зарцуулжээ. Дээрх зардлууд нь тухайн жилийнхээ төсвийн нийт

¹¹ C.I.F. нөхцөлөөр

зардал өсөхөд голлон нөлөөлжээ. Тухайлбал, Хүний хөгжил сангийн зардал 2010 оны төсвийн зардлын нийт өсөлтийн 42 хувийг, 2011 оны өсөлтийн 47 хувийг тус тус эзэлж байна.


Зураг 52
Төсвийн зардал
болон импортын
өсөлт



Төсвийн үр ашиггүй тэлэлт нь дотоодын зах зээл дэх хэрэглээг урамшуулж, улмаар бараа бүтээгдэхүүний импортын өсөлт, үйлчилгээний дансны алдагдлын өсөлтөөс шалтгаалсан урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлж байна.

Урсгал дансны алдагдал өсөх нь төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэх эдийн засгийн суурь нөхцөл болох бөгөөд гадаад зах зээлийн сөрөг өөрчлөлт буюу худалдааны нөхцөл муудах, санхүүгийн дансаар орж ирэх хөрөнгө оруулалт нь гадаад секторын эрсдэл, дотоодын эдийн засгийн тодорхойгүй байдал, хүлээлтээс хамаарч саатах зэрэг нь ханшийг огцом хэлбэлзэхэд нөлөөлж болзошгүй юм.

Зураг 53
Урсгал дансны
алдагдлын
санхүүжилт



Сүүлийн жилүүдэд урсгал дансны алдагдлын дийлэнх хэсгийг гадаадын хөрөнгө оруулалт, зээлээр санхүүжүүлсээр ирсэн ч хөрөнгө оруулалт орж ирэх хүлээлт тодорхой бус байдгаас шалтгаалан дотоодын валютын захад богино хугацаанд

хомсдол үүсэх, түүнээс шалтгаалсан ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэхэд гадаад валютын нөөцийг ашиглах шаардлага бий болдог. Тухайлбал, Монголбанк 2011 оны 4 дүгээр улиралд дотоодын захад валют нийлүүлж богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүгээс шалтгаалсан ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэн, зах зээлд үүсээд байсан хүлээлтийн гажилтыг арилгасан.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд, нийгмийн хавтгайрсан халамж нь дотоодын хэрэглээ, импортын эрэлтийг нэмэгдүүлж, бараа, үйлчилгээ, урсгал дансны алдагдал өсөхөд голлон нөлөөлж байна. Энэ нь бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх, төгрөгийн валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд нөлөөлөхөөс гадна эцсийн дүндээ улсын гадаад валютын нөөцөд учрах дарамтыг нэмэгдүүлж байна.

Ийнхүү улсын төсвийн огцом тэлэлтээр өдөөгдсөн дотоодын эрэлт, бараа бүтээгдэхүүний импорт, үйлчилгээний тэнцлийн алдагдлын өсөлтөөс шалтгаалсан урсгал тэнцлийн алдагдлын огцом өсөлт буюу макро эдийн засгийн суурь нөхцөл, гадаад эдийн засгийн орчны сөрөг өөрчлөлт буюу гадаад худалдааны нөхцөлийн бууралт¹², санхүүгийн дансаар орж ирэх хөрөнгө оруулалт дахь тодорхой бус хүлээлт¹³, дэлхийн зах зээл дэх ам.долларын ханшийн бусад валютын эсрэг чангарсан үзүүлэлт нь төгрөгийн валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд үйлчилсэн суурь шалтгаанууд болсон.

Зах зээлийн тогтвортой, үр ашигтай, дархлаа сайтай орчинг бүрдүүлэх, валютын захын тогтвортой байдлыг хангах замаар макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголбанк нь төгрөгийн валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр шаардлагатай үед нь валютын захад оролцон зохицуулалт хийсээр ирсэн. Тухайлбал, валютын орох урсгал эрс өссөн¹⁴ 2010 онд Монголбанк ханшийн огцом чангаралтыг зөөлрүүлэх чиглэлээр валютын захад оролцож байсан бөгөөд үүний үр дүнд валютын албан нөөц түүхэн дээд түвшин болох 2.6 тэрбум ам.долларт хүртэл нэмэгдэж байв.

Монголбанк 2011 оны эхэн үед төгрөгийн валюттай харьцах ханшийн огцом чангаралтыг сааруулах зорилгоор валютын захад оролцон валютын албан нөөцийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлж байсан бол валютын захын эрэлт, нийлүүлэлт тэнцвэртэй байсан 2-3 дугаар улиралд валютын захад оролцоогүй болно. Харин эдийн засгийн суурь нөхцөл нь төгрөгийн валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд үйлчилсэн үед ханшид огцом савлагаа үүсгэхгүй байлгах зорилгоор 2011 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн дотоодын захад валют нийлүүлж, богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүгээс шалтгаалсан ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэн зах зээлд үүсээд байсан хүлээлтийн гажилтыг арилгасан. Ингэснээр тайлант онд валютын захын тогтвортой байдлыг хангаж ажилласан болно.

Монголбанк нь Хятадын Ардын банктай үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээг 2011 оны 5 дугаар сард байгуулснаар шаардлагатай үед нь юанийг түргэн шуурхай бүрдүүлж эрэлтийг хангах, валютын дотоодын захад тогтворгүй байдал үүсэх эрсдэлтэй үед юанийг валютын захад нийлүүлэх замаар валютын захын болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зэрэгт чухал ач холбогдолтой болсон билээ.


12 Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2011 оны эцэст 1.636 байсан нь жилийн 7%-иар буурсан үзүүлэлт.

13 Улс төрийн сонгуультай онд гадаадын хөрөнгө оруулалтад тодорхой бус хүлээлт үүсдэг хандлага дэлхий нийтэд байдаг (Монголбанкны судалгааны ажил, 2011 он)

14 Валютын цэвэр орох урсгалын хэмжээ 1.6 тэрбум ам.долларт хүрсэн.

Зураг 54


Валютын цэвэр
урсгал ба төгрөгийн
ам.доллартай
харьцах ханш



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 55

Төгрөгийн
ам.доллартай харьцах
ханшийн өдөр тутмын
хэлбэлзлийн давтамж



Эх үүсвэр: Монголбанк

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар оны эхнээс 11.1 хувиар суларч 1396.37 төгрөгт хүрсэн бөгөөд тайлант хугацаанд ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.24 хувь, чангаралт болон сулралтын дундаж хэмжээ харгалзан 0.25 хувь, 0.23 хувь байв. Хэдийгээр төгрөгийн валюттай харьцах ханш 2011 онд суларсан ч жилийн нийт хоногийн 85.4 хувьд нь төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл 0.4 хувиас хэтрээгүй байна. Нэгээс дээш хувийн ханшийн хэлбэлзэл жилийн туршид зөвхөн 3 өдөрт л ажиглагджээ.

3.2 Улсын валютын нөөцийн удирдлага


Энэ онд гадаад валютын улсын нөөцийн ам.доллар, еврогийн багцын жишиг хөрөнгө оруулалтын үргэлжлэх хугацааг 8 сараар, хөрөнгө оруулалтын секторыг 0-3 жилээр тогтоож, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан нөөцийн удирдлагын өгөөжийг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан боловч дэлхийн дахинд үүссэн эрсдэлтэй нөхцөл байдлаас¹⁵ шалтгаалан урт хугацаат хөрөнгө оруулалтыг 2011 оны 3 дугаар сарын 16-ны

¹⁵ Ойрхи дорнод, умард Африкт гарсан улс төрийн тогтворгүй байдал, Евро бүсийн их өрийн хямрал, төсвийн тогтворгүй байдал, Япон улсад тохиолдсон байгалийн гамшигт үзэгдэл, цөмийн энергийн хямрал зэргээс шалтгаалан дэлхийн эдийн засгийн өсөлт удааширах, санхүүгийн зах зээлийн тодорхой бус байдал

өдрөөс зогсоосон.

Ингэснээр Монголбанк хуульд заасны дагуу нөөцийн найдвартай байдлыг хангах зорилгоор 2011 онд гадаад валютын улсын нөөцийг зээлийн эрсдэл нь харьцангуй бага дэлхийн эдийн засагт тэргүүлэгч орнуудын төв банкууд болох АНУ, Япон, Франц, ХБНГУ, Олон улсын төлбөр тооцооны банк (BIS)-ны харилцах, хадгаламж, богино хугацааны үнэт цаасанд байршуулан хөрөнгө оруулалт хийж ажиллав.

Гадаад валютын улсын нөөц 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2458.40 сая ам.долларт хүрсэн нь түүхэн дээд түвшин бөгөөд энэ нь валютын төлбөртэй импортын 2011 оны 12 дугаар сарын гүйцэтгэлээр авч үзэхэд Монгол Улсын импортын 17.42 долоо хоногийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд байлаа.



Зураг 56

Валютын
албан нөөцийн
хүрэлцээтэй байдал
(сая ам.доллар)

Эх үүсвэр: Монголбанк

Гадаад валютын улсын нөөц 2010 онтой харьцуулахад 14.4 хувь буюу 170.7 сая ам.доллараар нэмэгдсэн ба үүнд дараах эх үүсвэр, хүчин зүйлс голлон нөлөөлжээ:

- Банкуудын Монголбанкинд байршуулсан валютын харилцах, хадгаламжийн үлдэгдэл 69.5 сая ам.доллараар нэмэгдсэн;
- Валютын нөөцийн удирдлагын хүрээнд Монголбанк харилцах, хадгаламжийн хүүгийн орлогоос нийт 6.0 сая ам.доллар, богино хугацаат үнэт цаасны хөрөнгө оруулалтаас 2.5 сая ам.доллар, мөнгөжсөн алтны арилжаанаас 15.9 сая ам.доллар, нийт 24.7 сая ам.доллар ашиг олсон;
- Тайлант хугацаанд мөнгөжсөн алтны үнэ 12.37 хувиар өсч, паунд стерлингийн ханш ам.долларын эсрэг 0.97 хувиар чангарснаар валютын албан нөөц 19.32 сая ам.доллараар нэмэгдсэн;
- Дотоодын алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллагуудаас Монголбанк алт худалдан авч цэвэршүүлэн мөнгөжүүлснээр валютын албан нөөцийг нэмэгдүүлсэн;
- Валютын дуудлага худалдаагаар банкуудаас нийт 185.2 сая ам.доллар, форвард арилжаагаар 31 сая ам.доллар тус тус худалдан авсан бол банкуудад валютын дуудлага худалдаагаар 214 сая ам.доллар худалдсан (цэвэр 2.2 сая ам.доллар);

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх дотоодын чухал эх үүсвэр нь алт худалдан авалт юм. Тайлант онд Монголбанк дотоодын зах зээлээс худалдан авах алтны үнийн хөнгөлөлтийг хэвээр хадгалах бодлогыг баримталсан. Монголбанк

даамжирч болзошгүй болсноор АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны өгөөж гуравдугаар сарын дунд үе хүртэл унасан.

алт олборлогч 115 аж ахуйн нэгж, 24 иргэнээс нийт 3.3 тонн алтыг 197.31 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь 2010 оноос 1.2 тонн буюу 56 хувиар өссөн үзүүлэлт болов.

Зураг 57

Монголбанкны
худалдан авсан
алтны хэмжээ /
бохир жин, кг-аар/



Эх үүсвэр: Монголбанк

Гадаад валютын улсын нөөцийн эрсдэлийн удирдлага

Монголбанк гадаад валютын улсын нөөцийг удирдахдаа түүний найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд нөөцийн үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмаар ажилладаг.

Тайлант онд Монголбанкны эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг батлан, түүний хүрээнд ажиллалаа. Ерөнхий бүтцийн хүрээнд гадаад валютын улсын нөөцийн активын бүтэц, гадаад валютын бүтэц, хөрөнгө оруулалтын зохистой хугацаа, хөрөнгө оруулалтын боломжит хэрэгслүүдийг тус тус тодорхойлов. Мөн гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг тогтмол хийж, зах зээлийн эрсдэлүүдийг тооцох, зээлийн эрсдэл болон холбогдох лимитүүдэд хяналт тавих, дэлхийн зах зээлийн байдлыг байнга ажиглан холбогдох мэдээ тайлан бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.

2009 оноос эхэлсэн Евро-бүсийн өрийн хямралын улмаас дэлхийн санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал 2011 оны туршид үргэлжилсэн тул нөөцийн найдвартай байдлыг хангах зорилгоор бэлэн валют, биет хэлбэрээр байршуулсан мөнгөжсөн алт, Төв банкуудад байршуулсан харилцах данс болон хадгаламж, Олон улсын санхүүгийн байгууллагуудын хадгаламж, Олон улсын төлбөр тооцооны банкны богино хугацаат үнэт цаас, АНУ ба ХБНГУ-ын Засгийн газрын богино хугацаат үнэт цаас зэрэг зээлийн эрсдэл бага хэрэгслүүдэд хөрөнгө оруулах бодлогыг үргэлжлүүлээ. Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудад зэрэглэл харгалзахгүйгээр баталгаагүй хөрөнгө байршуулаагүй болно.

АНУ-ын Холбооны нөөцийн банк, Европын төв банк зэрэг Төв банкуудын хүүний түвшин тайлант онд бага хэвээр хадгалагдсан тул хүүний эрсдэлээс хамгаалж хөрөнгө оруулалтын зохистой хугацааг богино хугацаа буюу нэг ба түүнээс доош жилийн хугацаагаар тодорхойлж ажилласан.

Гадаад валютын улсын нөөцийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр нөөцийн удирдлагыг сайжруулах, бусад Төв банкууд болон хөрөнгө удирдлагын байгууллагуудаас туршлага судлах шаардлага гардаг. Энэхүү ажлын хүрээнд Монголбанк 2011 онд Дэлхийн банкнаас хөрөнгийн удирдлагын үйлчилгээний чиглэлээр төв банкуудад үзүүлдэг “Нөөцийн удирдлагыг сайжруулах зөвлөгөө ба нөөцийн удирдлагын хөтөлбөр”-г нэгдэж хамтын ажиллагаагаа эхлүүлээ.

4.1 Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд

Монгол улсад 2011 оны эцсийн байдлаар нийт 14 банк үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 1310 салбар нэгж, 1.9 сая хадгаламж эзэмшигч, 606 мянган зээлдэгч байна. Тайлант онд эдийн засгийн үйл ажиллагааны идэвх нэмэгдэж, хөрөнгийн урсгал өссөн, банкин дахь иргэд болон хувийн салбарын эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэж, улмаар банкуудын зээлийн хэмжээ өслөө.


Банкны салбарын нийт активын хэмжээ 9.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 3 их наяд төгрөгөөр өсч ДНБ-ий 77.8 хувьд хүрлээ. Банкуудын нийт өр төлбөрийн хэмжээ тайлант онд өмнөх оноос 48.2 хувиар нэмэгдсэн нь банкуудын хөрөнгө оруулалтын өсөлтөд нөлөөлснөөр зээлийн үлдэгдэл 5.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 75.4 хувиар буюу 2.3 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Тайлант үед чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ 3.7 нэгжээр буурч 3.1 хувьд хүрсэн нь зээлийн өндөр өсөлт нөлөөлсөн хэдий ч чанаргүй зээлийн хэмжээ 42.1 тэрбум төгрөгөөр буурч 167.6 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант оны эцсийн байдлаар хөрвөх активын хэмжээ 3.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар буюу 396.3 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Хөрвөх актив нийт активын харьцаа 32.2 хувьд хүрч 11.9 хувиар буурсан, хөрвөх актив богино хугацаат эх үүсвэрийн харьцаа 37.6 хувьд хүрч өмнөх оноос 15.7 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтөд хувийн секторын болон иргэдийн харилцах, хадгаламжийн өсөлт голлон нөлөөлж, нийт өр төлбөрийн хэмжээ 2.7 их наяд төгрөг буюу 48.2 хувиар нэмэгдэж 8.3 их наяд төгрөгт хүрлээ. Уг өсөлтийн 80.9 хувь болох 2.2 их наяд төгрөгийг харилцах, хадгаламжаас бүрдүүлсэн байна. Монгол Улсын их хурлаас 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр батлагдсан “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулийг үргэлжлүүлэн санхүүгийн салбарын эх үүсвэрийн тогтвортой байдлыг хадгалах, харилцагчдын мөнгөн хөрөнгийг хамгаалах зорилгоор хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоонд шилжих бэлтгэлийг хийж байна.

Банкны салбарын нийт орлогын хэмжээ 1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 56.6 хувиар буюу 366.2 тэрбум төгрөгөөр өссөн бол нийт зардал 0.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 43.3 хувиар буюу 239.8 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Хүүний орлого өмнөх оны эцэстэй харьцуулахад 45 хувиар өссөн нь банкуудын ашигт ажиллагаа өндөр гарахад гол нөлөөг үзүүлсэн байна. Хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт тайлант оны эцсийн байдлаар 2.9 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1 нэгжээр, өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт 18.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 7 нэгжээр тус тус өсчээ. Ашигт ажиллагааны үзүүлэлтүүдийг бүс нутгийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад өндөр байгаа нь манай орны банкны салбарын ашигт ажиллагаа өндөр байгааг харуулж байна.

Зураг 58

Нийт актив



Эх үүсвэр: Монголбанк, ҮСХ

Зураг 59


Зээлийн динамик



Эх үүсвэр: Монголбанк


Зураг 60

Активын өгөөж



Зураг 61

Өөрийн хөрөнгийн өгөөж



Эх үүсвэр: Монголбанк, ОУВС


Эх үүсвэр: Монголбанк, ОУВС

WHD –өрнөдийн бүс нутгийн орнууд (Western hemisphere countries), ED – хөгжиж байгаа эдийн засагтай орнууд (emerging and developing economies), OECD-эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн орнууд (organization for economic cooperation and development), G20-их 20 орнууд (group of 20 countries), EUR- европын орнууд (European countries), APD – ази, номхон далайн орнууд (Asian and pacific countries)

4.2 Банкны салбарын хөрөнгө болон эх үүсвэрийн бүтэц

Банкны салбарын нийт хөрөнгийн 22.1 хувийг мөнгөн хөрөнгө, 12.3 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 59.1 хувийг зээл, үлдэх 6.5 хувийг бусад актив эзэлж байгаа ба уг хөрөнгийн 36 хувийг 1 сар хүртэлх хугацаатай, 28 хувийг 1 сараас 1 жил хүртэлх хугацаатай, 28 хувь нь 1-5 жилийн хугацаатай, 9 хувийг 5-аас дээш жилийн хугацаатай байршуулсан байна.

Зээлийн үлдэгдлийг чанараар авч үзвэл нийт зээлийн багцын 95.6 хувь болох 5.2 их наяд төгрөгийн зээл хэвийн, 1.3 хувь болох 72.6 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн, үлдэх 3.1 хувь буюу 167.6 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд байна. Зээлийг олгосон салбараар авч үзвэл тайлант оны эцсийн байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 17 хувь буюу 929.7 тэрбум төгрөгийг худалдааны салбарт, 14.3 хувь буюу 778.4 тэрбум төгрөгийг үл хөдлөх хөрөнгийн салбарт, 11.7 хувь буюу 636.2 тэрбум төгрөгийг барилгын салбарт, 11.5 хувь буюу 624.2 тэрбум төгрөгийг боловсруулах салбарт, 11.3 хувь буюу 613.6 тэрбум төгрөгийг уул уурхайн салбарт олгожээ. Уг салбарууд дахь зээлийн чанарыг авч үзвэл чанаргүй зээлийн харьцаа уул уурхай (6.5%), боловсруулах (5.6%), тээвэр ба агуулах (4.1%), барилга (3.1%), хөдөө аж ахуй (3%) зэрэг салбаруудад илүү өндөр байна.



Зураг 62

Чанаргүй зээлийн харьцаа

Эх үүсвэр: Монголбанк

Банкны эх үүсвэрийг бүтцийн хувьд аваад үзвэл нийт эх үүсвэрийн 47.8 хувийг хадгаламж, 24.8 хувийг харилцах, 10.3 хувийг өөрийн хөрөнгө, 9.4 хувийг бусад эх үүсвэр, 5.6 хувийг банк санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр эзэлж байна. Нийт эх үүсвэрийн 56 хувь нь нэг сар хүртэлх хугацаатай байгаа нь өнгөрсөн оны эцсээс 2 нэгжээр буурсан бол 12 хувь нь нэг жилээс дээш хугацаатай эх үүсвэр нь өнгөрсөн оны эцсээс 4 нэгжээр өсчээ.

Харилцахын үлдэгдэл 2.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 34.2 хувиар буюу 582.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдсэнтэй холбоотойгоор хувийн секторын харилцах өссөн нь нөлөөлсөн байна. Хадгаламжийн үлдэгдэл 4.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 56.6 хувиар буюу 1.6 их наяд төгрөгөөр өсчээ. Иргэдийн хугацаатай хадгаламжийн хэмжээ 586.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 2.1 их наяд төгрөгт хүрсэн бол хугацаагүй хадгаламж 340.2 тэрбум

төгрөгөөр нэмэгдэж 1.2 их наяд төгрөгт хүрлээ. Хугацаатай хадгаламжийн хэмжээ 66.2 хувиар буюу 1.3 их наяд төгрөгөөр өссөн нь банкны салбарын эх үүсвэрийн хугацааг нэмэгдүүлэхэд гол нөлөөг үзүүллээ.

Дотоодын банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр болон банк хоорондын захаас авсан зээлийн хэмжээ 34.1 тэрбум төгрөгөөр буурч 209.9 тэрбум төгрөгт хүрсэн бол гадаадын банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн хэмжээ 83.2 тэрбум төгрөгөөр өсч 288.6 тэрбум төгрөгт хүрлээ.

Банкны гол эх үүсвэр болсон хадгаламжийн (харилцах) динамик үзүүлэлтийн ДНБ-д эзлэх хувийн жин тасралтгүй нэмэгдэж 2011 онд 56.5 хувьд хүрсэн нь банк, санхүүгийн зуучлал гүнзгийрч, харилцагчдын банкинд итгэх итгэл дээшилж байгаа ба эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаанд банкны салбарын оролцоо нэмэгдэж байгааг харуулж байна.

Өмнөх жилүүдэд ч банкны салбар эдийн засаг, хувийн хэвшлийн өсөлтийн гол эх үүсвэр байсан нь санхүүгийн салбарын зуучлалын үзүүлэлт (зээл/ДНБ)-ийн сүүлийн 5 жилийн дундаж 46.6 хувь байгаагаар (ГШХО/ДНБ, хөрөнгийн зах зээлийн хөрөнгөжилт сүүлийн 5 жилийн дунджаар 21.2, 13.7 хувь байв) нотлогдож байна. Цаашид ч банкны салбар эдийн засгийн өсөлтөд үнэтэй хувь нэмэр оруулсаар байх болно.

Зураг 63

Зээлийн үлдэгдэл
салбараар



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 64

Хадгаламж



Эх үүсвэр: Монголбанк, УСХ

4.3 Банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт, зээлийн төвлөрлийн эрсдэлийн зэрэг зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тооцоолдог.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 945.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 49.7 хувиар буюу 313.8 тэрбум төгрөгөөр, эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 65.8 хувиар буюу 2.5 их наяд төгрөгөөр нэмэгдэж 6.3 их наяд төгрөгт хүрлээ. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт оны эцсийн байдлаар банкны системийн хэмжээгээр 14.9 хувьд хүрлээ. Өөрийн хөрөнгийн харьцааны үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 1.3 нэгжээр, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 11 хувьд хүрч өмнөх оны эцсээс 0.9 нэгжээр буурчээ. Энэ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагаас нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 2.9 нэгжээр, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 5 нэгжээр өссөн байгаа боловч эрсдэлтэй активын өсөлтөөс хоцорч байгааг харуулж байна. Иймд банкны салбарын өсөлттэй холбоотойгоор ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор өөрийн хөрөнгийн шаардлага, тэр дундаа нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг шинээр мөрдүүлэх, системийн нөлөө бүхий банкуудад нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлага тавих зэрэг бодлогын чанартай арга хэмжээг авсан.

Хөрвөх чадвар

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 213 дугаар тушаалаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 18 хувиар тогтоосон ба мөн оны Монголбанкны Ерөнхийлөгчийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн 691 дугаар тушаалаар уг харьцааг 2012 оны 01 дүгээр сараас эхлэн 25 хувьд хүргэх шаардлагыг тавьсан. Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 39 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 3 нэгжээр өсчээ. Банкуудын түргэн борлогдох активын хэмжээ тайлант оны эцсийн байдлаар 3.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 0.5 их наяд төгрөгөөр өссөн ба нийт түргэн борлогдох активын 68.3 хувийг Төв банк, Засгийн газрын үнэт цаас, Монголбанкинд байршуулсан харилцах, хадгаламжууд эзэлж байна.

Гадаад валютын зохистой харьцаа

Банк нь гадаад валютын нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж

байх шаардлагатай. Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт нэгж валютын хувьд 0.3 хувь, нийт валютын хувьд 4.6 хувьтай байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байна.

Жилийн эцсийн байдлаар нийт гадаад валютын активын хэмжээ 3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 0.6 их наяд төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн бол гадаад валютын пассивын хэмжээ 2.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 0.3 их наяд төгрөгөөр буюу 22.6 хувиар өсчээ.


Төв банкнаас банкуудад зээлийн төвлөрлийн эрсдэлийг хэмжиж, зээлийн эрсдэлийг бууруулах үүднээс нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээнд хязгаарлалт тогтоодог. Монголбанкнаас хийгдсэн судалгаанаас аваад үзвэл зээлийн төвлөрлийн эрсдэл өндөр байна.

Зураг 65
Өөрийн хөрөнгө




Эх үүсвэр: Монголбанк

Зураг 66
Хөрвөх чадвар



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 67
Өөрийн хөрөнгийн
хүрэлцээ



Эх үүсвэр: Монголбанк, OYBC

4.4 Банкны хяналт шалгалт

Манай улсын хувьд банкны салбарын нийт актив санхүүгийн салбарын нийт активын 95 орчим хувийг эзэлж байна. Банкуудын эдийн засагт гүйцэтгэх үүрэг нэмэгдэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, техник технологи нэвтрүүлэхийн хэрээр тэдгээрт тавих хяналт шалгалтын орчинг улам боловсронгуй болгох асуудал тулгарч байгаа бөгөөд банкууд өөрсдийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг зөв тодорхойлон удирдаж, зохистой засаглалыг сайжруулан, цаашдын үйл ажиллагааныхаа чиг хандлагыг тодорхойлох асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд

Манай орны нөхцөлд тохирох макро зохистой бодлогын оновчтой арга хэрэгслүүдийг судалж, банкуудад зарим бодлогын хэрэгслүүдийг хэрэгжүүлэхээр боллоо. Энэ хүрээнд нийт банкны системд банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 213 тоот тушаалаар 18 хувьд хүргэх шийдвэр гаргасан ба мөн оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 691 тоот тушаалаар уг үзүүлэлтийг 25 хувьд хүргэх шаардлагыг тавьсан. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 726 болон 762 тоот тушаалаар системийн нөлөө бүхий банкуудад нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлагыг тавихаар болсон. Үүнд, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтийг үе шаттайгаар 2013 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 9 хувьд, нийт өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтийг мөн хугацаанд 12 хувьд хүргэх шаардлага тавьсан. Ингэхдээ “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 2.6.1 дэх заалтад банк болон банк бус санхүүгийн бусад байгууллагын өөрийн хөрөнгөд шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан байршуулсан хөрөнгийн 75 хувийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, үлдсэн 25 хувийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс тус тус хасах өөрчлөлтийг оруулсан. Түүнчлэн системийн нөлөө бүхий банкуудад 2 хувийн нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлагыг үе шаттайгаар тавьж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахаар бэлтгэж байна.

Банкны эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, хувь нийлүүлэгчдийн санхүүгийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 404 тоот тушаалаар банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 16.0 тэрбум төгрөг болгон хоёр дахин нэмэгдүүлсэн. Уг шаардлагыг банкууд 2013 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор ханган ажиллах шаардлагатай бөгөөд одоогийн байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний дээрх шаардлагад хүрээгүй байгаа долоон банкнаас төлөвлөгөө гаргуулан авч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Банкны салбарын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулах хүрээнд Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлийн дагуу банкууд санхүүгийн тайлан болон бусад мэдээллийг нийтэд үнэн зөв мэдээлж буй эсэхэд тогтмол хяналт тавин, цаашид улам боловсронгуй болгохоор ажиллаж байна.

Түүнчлэн Япон улсын ЖАЙКА байгууллагын техник туслалцааны хүрээнд одоогийн банкуудын тайлан бүртгэлийн системийг өргөтгөх ажлыг хийж, 2011 оны 11 дүгээр

сараас ашиглаж эхэлсэн. Үүний дүнд системийн боломжит үйлдлүүд нэмэгдэж, өмнө нь гар аргаар боловсруулдаг байсан зайнаас тавих хяналтад шаардлагатай тайлангуудыг систем автоматаар боловсруулдаг болж хяналт шалгалтын үйл ажиллагаанд дэвшил гарсан юм.

Банкны санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, иргэдийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс Монгол Улсын Их хурлаас 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулийг баталсан бөгөөд дээрх хууль нь зохих үр дүнгээ өгч банкны салбарын эх үүсвэр тогтмол өссөөр байна. Уг хуулийн баталгаа нь дөрвөн жилийн хугацаатай үргэлжлэх бөгөөд цаашид санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, харилцагчдын хөрөнгийг хамгаалж, банкны салбарын эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах шаардлага зайлшгүй бий болж байна. Дээрх зорилгын хүрээнд 2010 оны эцэст Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох байгууллагын төлөөлөлтэйгээр ажлын хэсэг байгуулагдан хадгаламжийн даатгалын хуулийн төслийг 2011 оны 4 дүгээр сард эцэслэн боловсруулж Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулж, улмаар Монгол Улсын Их хуралд өргөн барих үйл ажиллагааг эхлүүлсэн. Ингэснээр цаашид олон улсын жишигт нийцсэн хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хийж байна.

Барьцаа хөрөнгийн холбогдолтой болон зээлийг түргэн шуурхай барагдуулах эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 53 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Банкуудын холбооны хуульчидтай санал солилцон хамтарч ажиллаж байгаа бөгөөд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтүүдийн саналыг бэлтгэж байна.

Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа тэлэхийн хэрээр банкны байгууллага оролцсон санхүүгийн нэгдлүүд нэмэгдэх хандлагатай байгаагаас тухайн санхүүгийн нэгдлүүдэд нэгдсэн байдлаар хяналт шалгалт хийх тогтолцоог бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Энэ үүднээс Монголбанкнаас нэгдсэн хяналт шалгалтын журмын төслийг боловсруулаад байгаа бөгөөд цаашид Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөж байна.

БНСУ-ын “Камко” активын удирдлагын корпорацийн үйл ажиллагааны талаар судалж, уг корпорацийтай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар болоод байна. Цаашид банкны муу активыг шуурхай барагдуулах бүтцийг бий болгохоор төлөвлөн, холбогдох хуулийн төслийг боловсруулахаар бэлтгэл ажил хийж байна.

Хөрөнгийн зах зээл дэх банкуудын оролцоог дэмжих, банкуудын эдийн засгийн өсөлт болон харилцагчдын санхүүгийн эрэлт хэрэгцээг хангах, тэдгээрт зориулсан бага хүүтэй, урт хугацаат бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор зарим банкуудаас олон улсын зах зээл дээр бонд гаргах хүсэлт ирүүлсэнд холбогдох зөвшөөрлийг олгон дэмжиж ажиллалаа.

Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, үр өгөөжийг дээшлүүлэх, зээлийн мэдээллийн санд агуулагдаж буй мэдээллийн чанар, агууламжийг сайжруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Зээлийн мэдээллийн тухай хуулийн төслийн ажлын хэсэгт Монголбанкны зүгээс орж ажиллан, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжийг бүрдүүлэх талаарх зохицуулалтыг тусгуулах тал дээр анхаарсан бөгөөд хуулийн төсөл 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр батлагдаж, 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна.
- Зээлийн мэдээллийн сангийн хамрах хүрээг өргөтгөж, бүх банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршоодын мэдээллийг бүрэн хамруулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллав. Энэ хүрээнд зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх Микро Финанс 1.0 програмыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран туршиж, ашиглалтад орууллаа. Үүний дүнд тайлант оны байдлаар нийт 34 бичил санхүүгийн байгууллага буюу 31 банк бус санхүүгийн байгууллага, 2 хадгаламж зээлийн хоршоо, 1 санхүүгийн түрээсийн компанитай мэдээлэл солилцож байна.
- Зээлдүүлэгч байгууллагуудад бүртгэлгүй иргэд, аж ахуйн нэгжийн өр төлбөрийг зээлийн мэдээллийн санд хамруулах тал дээр анхаарч, суурин утас, татвар, нийгмийн даатгал болон зарим үүрэн утасны оператор компаниуд дахь өр төлбөрийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нэгтгэх ажлыг хийж эхлээд байна.

Банкуудад хийгдсэн хяналт шалгалтын талаар

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа 14 банкинд газар дээрх ээлжит, иж бүрэн шалгалт хийж банкуудын өөрийн хөрөнгө, санхүү, төлбөрийн чадварын байдал, үйл ажиллагаанд үнэлэлт өгөн, шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд иж бүрэн шалгалтыг 11 удаа, хэсэгчилсэн шалгалтыг 4 удаа хийж гүйцэтгэснээс гадна банк хоорондын зээл, хадгаламжийн үйл ажиллагаанд мөн хэсэгчилсэн шалгалт хийлээ.

Дээрх шалгалтуудаар банкууд актив болон түүнтэй адилтган тооцох хөрөнгийн ангиллыг зохих журмын дагуу хийгээгүй, активын эрсдэлийн санг дутуу байгуулсан, зээлийн хүүгийн авлагыг зохих журмын дагуу хуримтлуулан тооцдоггүй, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг зөрчсөн, зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл, тайлан мэдээ буруу гаргасан, нягтлан бодох бүртгэлийн заавар журмыг зөрчсөн, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг томилоогүй, Монголбанкинд бүртгүүлэх эрх зүйн баримт бичгийг бүртгүүлээгүй, санхүүгийн нэгдлийн нэгдсэн тайлан гаргаж ирүүлэхгүй байгаа зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн. Эдгээр зөрчлийг арилгуулах үүднээс Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тухайн банк өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулан хянуулсны үндсэн дээр хэрэгжүүлэх, активын өсөлттэй уялдуулан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, чанаргүй активыг бууруулах, нэг зээлдэгч болон банкны холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг ханган ажиллах, ашигт ажиллагааг сайжруулах, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хүртэл хугацаанд хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, санхүүгийн байдлыг тогтмол хянах, зээл олгох үйл ажиллагааг хязгаарлах зэрэг арга хэмжээг банкуудад авч хэрэгжүүлэн, тушаалаар өгөгдсөн үүргүүдийн биелэлтэд

тогтмол хяналт тавин ажиллалаа.

Банкуудын санхүүгийн тайлан болон бусад холбогдох мэдээллийг сар бүр хүлээн авч, хууль, журмын шинэ заалтуудын хүрээнд зохистой харьцааны болон бусад үзүүлэлтүүдийг хэрхэн хангаж байгаад зайнаас тогтмол хяналт тавин, шаардлагатай нөхцөлд хууль тогтоомжийн дагуу шат дараалсан арга хэмжээ авч, санхүүгийн зах зээлийн сахилга батыг өндөржүүлэн ажиллаж байна.

Өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай зарим банкинд хяналт шалгалтын дунд хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэн биелэлтийг сар бүр дүгнэж, байнгын хяналт тавин ажилласан бөгөөд үүний дүнд тухайн банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт тогтворжиж, төлбөрийн чадварын үзүүлэлт сайжирлаа.

Түүнчлэн эрх хүлээн авах үйл ажиллагаа үргэлжилж байгаа банкуудын үйл ажиллагааг дуусгавар болгох хүртэл хугацаанд хяналт тавих нэгжтэйгээр ажиллав.

Банкны зохистой засаглалын шилдэг туршлагыг нэвтрүүлэх, удирдлагын ил тод байдлыг хангах, жижиг хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын биелэлтийг жилд 2 удаа тогтмол үнэлэхээс гадна газар дээрх иж бүрэн шалгалтаар удирдлага зохион байгуулалт, мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын шалгалтыг хийж, үнэлгээ өгч хэвшив.

Банкуудын хараат бус гишүүдийг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нарын хамтарсан тушаалаар батлагдсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх, журам”-ын дагуу бүрэн томилуулах ажиллагаанд хяналт шаардлага тавьж ажилласны үр дүнд бүх банкуудыг төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнтэй болгоод байна.

Тайлант онд эдгээрээс гадна бусад газартай хамтран сургалт зохион байгуулах, төсвийн болон төрийн зарим байгууллагын харилцах дансны үлдэгдлийг баталгаажуулж шалгах ажлыг хийж гүйцэтгэсний зэрэгцээ зарим банкуудтай холбоотой асуудлууд дээр шинжээчээр томилогдон ажиллалаа.

Монголбанкнаас олон нийттэй харилцах чиглэлээр мөнгөний бодлого, арга хэрэгслийг олон нийтэд ил тод, нээлттэй байлган өөрийн хариуцлагыг дээшлүүлэх, мөнгөний бодлогын зорилт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хүлээгдэж байгаа үр дүнг тогтмол тайлбарлан таниулж иргэд, олон нийтийн зүгээс түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготойгоор ажиллав.

Энэхүү зорилтын хүрээнд Монголбанкнаас 2011 оны турш Төв банкны үндсэн зорилт, үйл ажиллагаа, ил тод байдал, төсөв мөнгөний бодлогын уялдаа зэрэг сэдвээр олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагынханд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулав. Үүний хүрээнд сэтгүүлчидтэй “зангиагүй уулзах”, ярилцлага өгөх, оюутан сурагчид, санхүүгийн захын оролцогчдод сургалт семинар зохион байгуулах, лекц унших, “Монголбанкнаас бичиж байна” буланг томоохон сонинуудад тогтмол ажиллуулах зэрэг ажлыг оны турш зохион байгуулсан болно.

“Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөл”-ийг сурталчлах, тайлбарлах

Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл”-ийг УИХ, Засгийн газар, хэвлэл мэдээллийн байгууллагууд, санхүүгийн зах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Үүний хүрээнд Монголын Банкны Холбоотой хамтран “Нээлттэй хэлэлцүүлэг”-ийг, Парламентийн сэтгүүлчдийн холбоотой хамтран сургалт семинарыг зохион байгуулав. Мөн үндсэн чиглэлийн төсөлтэй холбогдуулж Монголбанкны Ерөнхийлөгчийн хэлсэн үгийг өдөр тутмын томоохон сонинд нийтлэн олон нийтийн хүртээл болгов.

Мөнгөний бодлогын шийдвэр гаргалт ба хэвлэлийн хурал

Монголбанк 2011 онд сар бүр ээлжит хэвлэлийн хурал зохион байгуулж ажиллав. Хэвлэлийн хурлын товыг Монголбанкнаас урьдчилан зарласан нь Төв банкны үйл хөдлөлийг таамаглагдахуйц болгох ач холбогдолтой төдийгүй банк, санхүүгийн захын шийдвэр гаргалтад ч мөн эерэгээр нөлөөлөв.

Мөнгөний бодлогын асуудлаар болон цаг үеийн сэдвээр хийсэн хэвлэлийн хурлаар Монголбанкны удирдлагууд сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгөх, мөнгөний бодлогын шийдвэр гаргалт, түүний үндэслэл, шалтгаан, бодлогын хэрэгжилт, хүлээлт зэрэг сэдвээр зохих тайлбар, тодруулга өгч ажиллав. Монголбанк “Мөнгөний бодлогын мэдэгдэл”-ийг тухай бүр цахим хуудас дээр байршуулан бодлогын хүү, бусад хэрэгсэлд өөрчлөлт орсон, эс орсон тухай мэдээллийг олон нийтэд өгч ажиллав.

Монголбанкны хэвлэмэл бүтээгдэхүүн

Монголбанкны уламжлалт хэвлэмэл бүтээгдэхүүн болох Жилийн тайлан, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанкны судалгааны ажил зэргийг хэвлүүлэн олон нийтэд хүргэв.

Цахим хуудсыг боловсронгуй болгох

Монголбанк өөрийн цахим хуудасны үйл ажиллагааг боловсронгуй болгоход онцгой анхаарал хандуулан ажиллав. Төв банкны шинэчлэгдсэн цахим хуудсыг 2011 оны 4 дүгээр сард ашиглалтанд оруулж “Санхүүгийн тогтвортой байдал”, “Төлбөрийн

систем”, “Санхүүгийн мэдээллийн алба” зэрэг мэдээ материалыг шинээр нэмэв. Мөн “Мөнгөний бодлого” цэсийн агуулга, бүтцэд онцгой анхааран бодлогын үндсэн зорилт, арга хэлбэр, шилжих механизм, шийдвэр гаргалт зэрэг мэдээг шинээр оруулах, шинэчлэн найруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Төв банкны хараат бус байдал, хариуцлага, ил тод байдал, Төв банкинд итгэх итгэлийн талаархи мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэхэд онцгойлон анхаарч ажиллалаа.

Монголбанкнаас цахим хуудсаараа дамжуулан судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийг олон нийтэд танилцуулах ажлаа үргэлжлүүлэв. Тухайлбал, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдлын талаархи түүвэр судалгааг гүйцэтгэж хэрэглэгчдийн хүртээл болгохын сацуу “Арилжааны банкуудын улирлын зээлийн тайлан”, “Орон нутаг дахь банкуудын тайлан”, “Банкуудын ипотекийн зээлийн тайлан”-гийн статистик мэдээг олон нийтэд шинээр танилцуулж эхэллээ.

6.1 Төлбөр тооцооны систем

Төв банк нь төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгын хүрээнд төлбөр тооцооны системийн эрх зүйн орчинг сайжруулах, их, бага дүнтэй төлбөрийн системүүд, картын нэгдсэн сүлжээгээр төлбөр тооцоог түргэн, шуурхай гүйцэтгэх, төлбөр тооцооны эцэслэлт, баталгаажуулалт, нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах, үр дүнгийн тооцоог бодит цагаар хийх зэргээр төлбөр тооцооны олон улсын стандарт, үндсэн зарчмуудыг мөрдөж ажиллалаа.

Бэлэн бус төлбөрийн хэрэгсэл, мобайл банкны үйлчилгээг дэмжих, технологийн дэвшлийг ашиглаж олон улсын стандартад нийцсэн, үндэсний хэмжээний нэгдсэн, нээлттэй дэд бүтцийг хөгжүүлэхээр Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Хувьсан шинэчлэгдэх дэвшилтэд мобайл банкны үйлчилгээ” төслийг үргэлжлүүлж, банк, санхүү, мэдээллийн технологийн эрх бүхий байгууллагууд, төлбөрийн системийн оролцогчидтой хамтран ажиллаж, “Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого”-ын төслийг боловсрууллаа.

Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвийг Банксүлжээ системд 2011 оны 10 сард холбосноор төлбөрийн системээр зөвхөн банк хоорондын бус, мөн үнэт цаасны байгууллагын төлбөр тооцоог дамжуулах болсон. Энэ нь Монгол Улсад үнэт цаасны арилжааны хэлцлийн төлбөрийг урьдчилан хийдэг системийг халж, “Т+3” систем нэвтрүүлэх, үнэт цаасны гүйлгээний клиринг хийх, үр дүнгийн тооцоог Төв банкаар дамжуулан гүйцэтгэх боломжийг бүрдүүлж байна.

6.2 Банк хоорондын төлбөр тооцоо

Хүснэгт 16: 2008-2011 оны банк хоорондын гүйлгээний тоо, дүн (улирлаар) (Мянган ширхэг, их наяд төгрөг)


	2008 он		2009 он		2010 он		2011 он	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I улирал	499.9	2.4	502.0	1.7	693.8	2.2	798.9	3.7
Өөрчлөлт (%)	32.0	70.4	0.4	-29.1	38.2	25.8	15.1	68.2
II улирал	633.6	2.8	715.9	1.8	908.9	3.0	1,077.5	5.4
Өөрчлөлт (%)	31.2	49.6	13.0	-35.6	27.0	69.6	18.5	80.0
III улирал	494.3	2.6	626.2	1.9	801.9	3.4	903.6	6.0
Өөрчлөлт (%)	20.0	47.0	26.7	-24.4	28.1	74.2	12.7	73.5
IV улирал	624.2	2.9	800.3	2.5	983.1	4.7	1,139.3	8.3
Өөрчлөлт (%)	14.2	-0.4	28.2	-13.6	22.8	86.2	15.9	76.6
Нийт	2 252	10.7	2 644.4	7.9	3,387.7	13.2	3 919.3	23.4
Өөрчлөлт (%)	23.6	34.4	17.4	-25.4	28.1	66.5	15.7	77.3

Эх үүсвэр: Монголбанк

Банк хоорондын гүйлгээний үзүүлэлтийг өмнөх жилтэй нь харьцуулахад дүнгийн хувьд 2009 онд 25.4 хувиар буурсан, харин 2010 онд 66.5 хувь, 2011 онд 77.3 хувиар тус тус өссөн бол тооны хувьд 2009 онд 17.4 хувь, 2010 онд 28.1 хувь, 2011 онд 15.7 хувиар тус тус өсчээ.

Зураг 68

Банк хоорондын
гүйлгээ тоо, дүн



Эх үүсвэр: Монголбанк

Гүйлгээний дүн 2008-2011 онуудад огцом өссөн бол гүйлгээний тоо харьцангуй удаанаар нэмэгджээ. Банк хоорондын гүйлгээний тоо, дүн IV улиралд хамгийн их, I улиралд хамгийн бага үзүүлэлттэй байна.

6.3 Төлбөрийн карт

Төлбөрийн картын нэгдсэн сүлжээнд Хадгаламж банк бие даан нэгдсэнээр “Нэг карт-нэгдсэн сүлжээ” үйлчилгээний шууд оролцогч болсон.

Хүснэгт 17: Төлбөрийн картын хэрэглээ 2009-2011 он

Карт эзэмшигчийн тоо					Карт ашиглагчийн тоо				
2009	2010	2011			2009	2010	2011		
		Нийт	Орон нутагт	Өөрчлөлт (%)			Нийт	Орон нутагт	Өөрчлөлт (%)
1,885,103.0	1,538,336.0	2,169,838.0	852,401.0	41.1	476,230.0	670,887.0	440,177.0	102,489.0	-34.4

Эх үүсвэр: Монголбанк

Карт эзэмшигчийн тоо 2010 онд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байсан бол 2011 онд 41.1 хувиар өсчээ. Хүний хөгжил сангаас иргэдэд олгож буй эх орны хишгийг банкаар дамжуулан олгож эхэлсэн нь нийт карт эзэмшигчийн тоог огцом нэмэгдүүлсэн байна.

Харин карт ашиглагчийн хувьд 2010 онд өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байсан хэдий ч 2011 онд энэ үзүүлэлт 34.4 хувиар буурсан байна. Энэ нь нийт карт эзэмшигчид картыг бэлэн бус төлбөр тооцоонд төдийлөн хэрэглэж заншаагүйтэй холбоотой юм.

Хүснэгт 18: Төхөөрөмжийн тоо

Төхөөрөмж	2009	2010	2011	Өөрчлөлт (%)
ПОС	3,754.0	4,418.0	5,624.0	27.3
ПОБ	1,186.0	1,576.0	2,354.0	49.4
АТМ	292.0	367.0	634.0	72.8
Импринтер	417.0	412.0	373.0	-9.5

Эх үүсвэр: Монголбанк


Төлбөрийн картын хэрэглээ өсөхийн хэрээр төхөөрөмжийн тоо жил бүр нэмэгдэж байна. Үүнээс АТМ төхөөрөмж өмнөх оноос хамгийн их буюу 72.8 хувиар өсчээ.

Хүснэгт 19: ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо, дүн (сая ширхэг, тэрбум төгрөг)

		2009	2010	2011	Өөрчлөлт (%)
ПОС	Дүн	100.3	233.8	448.8	92.0
	Тоо	1.4	2.7	5.9	118.5
ПОБ	Дүн	453.5	376.5	515.5	36.9
	Тоо	3.2	2.2	2.2	-
АТМ	Дүн	874.9	1,541.5	2,603.8	68.9
	Тоо	15.3	22.1	36.7	66.1
Нийт	Дүн	1,428.7	2,151.8	3,568.1	65.8
	Тоо	19.8	26.9	44.8	66.5

Эх үүсвэр: Монголбанк

Төлбөрийн картын хэрэглээнд АТМ төхөөрөмж хамгийн их ашиглагддаг байна. Харин ПОС терминалаар хийсэн гүйлгээний тоо, дүн 2011 онд өмнөх оноос хамгийн их буюу 92 хувь ба 118.5 хувиар тус тус нэмэгджээ.



Зураг 69:

ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр хийсэн гүйлгээний дүн (тэрбум төгрөг)

Эх үүсвэр: Монголбанк

Төв банк нь удирдлага, 7 газар, 2 бие даасан алба, орон нутаг дахь Монголбанкны 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж байна. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Захирлуудын Зөвлөлийн 2011 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэр, Монголын банкуудын холбоо, Банк, санхүүгийн академийн хүсэлтийг тус тус үндэслэн Монголбанкны дэргэдэх Банкны сургалтын төвийг 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөр тасалбар болгон Монголын банкуудын холбоонд шилжүүлсэн болно.

Тайлант үеийн байдлаар Монголбанкинд нийт 398 ажилтан үүнээс 72.4 хувь нь Төв аппаратад ажиллаж байна. Ажилтнуудын 54 хувийг эрэгтэй, 46 хувийг эмэгтэй ажилтнууд тус тус эзэлж байна. Нийт ажилтнуудын 59.0 хувь нь банк санхүүгийн мэргэжлийн эдийн засагч, хянан шалгагч, нягтлан бодогч нар байна. Мэргэжлийн бүтцийг авч үзвэл эдийн засагч, нягтлан бодогч, бизнесийн удирдлага, эрх зүйч гэсэн мэргэжилтэй ажилтан нийт ажилтны 71.4 хувийг эзэлж байгаа нь Монголбанкны үйл ажиллагааны стратеги, алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн түвшний хувьд боломжийн, чадамжтай байгааг харуулж байна. Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, банк санхүүгийн мэргэжилтэй ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, тэдгээрийн мэргэжил боловсролыг дээшлүүлэх, мэргэшлийн ур чадварыг сайжруулах, спорт олон нийтийн бүх төрлийн арга хэмжээнд татан оролцуулах зэрэгт тодорхой бодлого баримталж ажилласан ба үүний үр дүнд мэргэжлийн ажилтнуудын тоо урд оноос 10 хувиар нэмэгдэж, ажилтнуудын бүтээлч идэвхи санаачилга өсч байна.

Ажилтнуудын цалин хөлс, урамшууллыг ажлын үр бүтээлтэй уялдуулан улирал бүр дүгнэж ажилласан ба цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, орон байр олгох асуудлыг тухай бүр төсөв хөрөнгөтэй уялдуулан шийдвэрлэж байна.

Тайлант онд нь Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 жил, Их Монгол улс байгуулагдсаны 805 жил, Тусгаар тогтнолын 100 жил, Ардын хувьсгалын 90 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн түүхэн жил байсан ба Банк, санхүүгийн байгууллагын хувьд Санхүүгийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлээ. Эдгээр түүхэн арга хэмжээний хурал зөвлөлгөөнд оролцох, ажилтнуудыг шагнаж урамшуулах, банкны ахмад настанд хүндэтгэл үзүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж ирлээ.

Гадаад харилцаа

Монголбанк дэлхийн олон орнуудын төв банкуудтай хамтран ажиллах боломжийг хайж тэдний үйл ажиллагаанаас туршлага судлах үйл ажиллагаагаа сайжруулах тал дээр ажиллаж ирсэн бөгөөд нийт 70-аад орны санхүүгийн болоод бусад үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай их бага хэмжээгээр хамтран үйл ажиллагаа явуулсаар ирсэн бөгөөд гадаад хамтын ажиллагааг улам өргөжүүлэх зорилгоор Монголбанкны гадаад харилцааны бодлогыг тодорхойлон ажиллаж байна. Үүн дээр тулгуурлан бид дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2011 оны 5 дугаар сарын 6-нд БНХАУ-ын Төв банкны ерөнхийлөгчийн айлчлалыг зохион байгуулж хоёр төв банкны хамтын СВОП хэлцэлд

гарын үсэг зурсан. Үүний үр дүнд хоёр улс таван тэрбум юань, нэг их наяд төгрөгтэй тэнцэхүйц хэмжээний үндэсний мөнгөн тэмдэгт солилцох болсон.

- 2012 оны 3 дугаар сарын 20-нд Ерөнхийлөгч Zhou Xiaochuan-тай 2011 онд зурсан СВОП хэлцэл болон цаашдын хамтын ажиллагааг үр дүнтэй болгох талаар ямар арга хэмжээ авах боломж байгааг ярилцах зорилгоор Хятадын Ардын банкинд айлчлал зохион байгуулав. Энэ уулзалт хоёр төв банкны хувьд болон хоёр улсын хоорондын хамтын ажиллагаанд их үр өгөөжтэй болж СВОП хэлцлийн гэрээний нэмэлт өөрчлөлтөд гарын үсэг зурлаа.
- 2011 оны 8 дугаар сарын 12-нд БНСУ-ын Төв банкны Ерөнхийлөгчийн айлчлалыг зохион байгуулж 8 дугаар сарын 14-нд хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Хамтын ажиллагааны санамж бичгийн дагуу Монголбанкны ажилтнуудыг БНСУ-ын нэртэй их дээд сургуулиудад бакалавр болон магистрын сургалтанд хамруулж байна.
- 2011 оны 9 дүгээр сарын 2-нд БНСУ-ын Санхүүгийн Үйлчилгээний Комисстой хамтын ажиллагааны гэрээ байгуулав.
- Мөн түүнчлэн БНТУ-ын Төв банктай хамтын ажиллагааны санамж бичигт харилцан гарын үсэг зурах ёслол 9 дүгээр сарын 24-нд Вашингтон хотод болсон. Үүний үр дүнд 2012 оны 7 дугаар сард БНТУ-ын Төв банкны Ерөнхийлөгчийн айлчлалыг зохион байгуулах гэж байна.
- 2011 оны 5 сарын 25-аас 28-ны хооронд Камбожийн Вант Улсын Төв банкны Ерөнхийлөгчийн айлчлалыг зохион байгуулж 5 дугаар сарын 26-нд хамтын ажиллагааны санамж бичигт хоёр төв банкны ерөнхийлөгч нар гарын үсэг зурсан.
- Тайландын Вант Улсын Төв банктай хамтран цаашид хэрхэн ажиллах талаар Дэд Ерөнхийлөгчийн 2012 оны 4 дүгээр сарын 3-нд хийх айлчлалыг зохион байгуулж байна.

ОХУ-ын нийслэл Москва хотноо байрлалтай Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк, Олон улсын хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаанд Монгол Улсыг төлөөлж оролцдогийн хувьд хоёр банкны үйл ажиллагаанд хяналт тавьж, Зөвлөлийн ээлжит хуралдаанд оролцож, Монгол Улсын эрх ашигт нийцсэн байх үндсэн зорилтын хүрээнд бодлого боловсруулж, байр сууриа илэрхийлж ирсэн юм.

Гишүүн төв банкны хувьд SEACEN-ний Төв банкуудын сургалтыг 2010 оноос 2 жил дараалан амжилттай зохион байгуулсан. SEACEN-ний Төв банкуудын Ерөнхийлөгч нарын жилийн уулзалтыг 2012 оны сүүлээр Улаанбаатар хотод зохион байгуулахаар боллоо.

Мэдээлэл технологийн талаар

Монголбанк нь тайлант онд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн технологийн техник, тоног төхөөрөмж, програм хангамжийн системүүдийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллалаа.

Банк хоорондын мөнгөний захын үйл ажиллагаанд ашиглагдаж буй програм

хангамжийн системийг өргөтгөж, банкуудтай своп, форвард арилжаа хийх болон засгийн газрын үнэт цаасны арилжааг гүйцэтгэхэд зориулагдсан шинэ програм хангамжуудыг өөрийн мэдээллийн технологийн албаны хүчээр дотооддоо боловсруулж, ашиглалтад оруулав. Түүнчлэн байгууллагынхаа дотоод үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн шинэ програм хангамжуудыг боловсруулах, одоо ашиглаж буй програм хангамжийн системүүдийг өргөтгөх, засварлах ажлууд хийж гүйцэтгэлээ.

Монголбанкинд ашиглагдаж буй мэдээллийн технологийн системүүдэд тохиолдож болзошгүй эрсдэлийг бууруулахад анхаарал хандуулан дотоод сүлжээний аюулгүй байдал, өгөгдлийн сангийн системүүдийн нөөцлөлт, цахим мэдээллийн системүүдийн хяналтыг сайжруулах зэрэг чиглэлд тодорхой ажлууд хийгдлээ.

Дотоод аудитын талаар

Монголбанк нь дотоод аудитын үйл ажиллагааны хүрээнд Дотоод аудитын 2007-2011 оны хөтөлбөр, 2011 оны төлөвлөгөөний дагуу Монголбанкны газар, хэлтэс, орон нутаг дахь салбар нэгжүүдэд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхэд хяналт тавьж, эрсдэлийг бууруулах, учирч болзошгүй аливаа эрсдэл, алдагдлаас хамгаалах, зөрчил дутагдлыг илрүүлэн тогтоох, холбогдох арга хэмжээ авах, санал, зөвлөмж болон үүрэг, даалгавар өгөх зэргээр ажиллалаа. Тайлант онд аудитыг Монголбанкны 6 газар, хэлтэс, орон нутаг дахь салбаруудыг бүрэн хамруулан эрсдэл ихтэй, эрсдэл бий болж болзошгүй талбарт голлон чиглүүлж ээлжит, гэнэтийн, хэсэгчилсэн шалгалтуудыг хийж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг цаг тухайд нь авч, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ирлээ. Дотоод аудитын үйл ажиллагааг улирал тутам нэгтгэн дүгнэж, Захирлуудын болон Хяналтын зөвлөлийн гишүүдэд тайлагнаж ажиллав.

Цаашид Монголбанкны дотоод аудитын бодлого, зарчим, хөтөлбөр төлөвлөлтийг боловсронгуй болгох, үйл ажиллагаандаа мөрдөх, эрх зүйн актуудыг шинэчлэх, боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх зэрэг ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Мөнгө угаах, терроризмтой тэмцэх

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэй Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба 2011 онд уг хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд буюу банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллалаа. Нийт 12 банк, 3 банк бус санхүүгийн байгууллагад газар дээрх хяналт шалгалтаар орж илэрсэн 14 зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, 89 хугацаат үүрэг даалгавар өгсөн байна. Илэрсэн зөрчлийн ихэнх нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан харилцагчийн мэдээллийг шалгах шаардлага бүрэн хангагдаагүй, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагааг зохих түвшинд авч хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Түүнчлэн, Санхүүгийн мэдээллийн алба нь 2011 оны турш банк, санхүүгийн

байгууллагуудаас хуулиар мэдээлэхийг үүрэг болгосон нийт 474880 ширхэг 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/-нөөс дээш хэмжээний бэлэн мөнгөөр хийсэн гүйлгээний тухай мэдээлэл (бэлэн мөнгөний гүйлгээний тайлан), 49221 ширхэг 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/-нөөс дээш хэмжээний гадаад төлбөр тооцоо, шилжүүлгийн тухай мэдээлэл (гадаад төлбөр тооцооны тайлан), мөнгө угаах, эсхүл терроризмыг санхүүжүүлж байж болзошгүй гэж мэдээлэгдсэн 71 ширхэг сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл (сэжигтэй гүйлгээний тайлан)-ийг мэдээллийн сандаа хүлээн авч бүртгэснээр бүх оны өссөн дүнгээр нийт 1227917 ширхэг бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, 52145 ширхэг гадаад төлбөр тооцооны тайлан, 158 ширхэг сэжигтэй гүйлгээний тайланг бүртгэн авч мэдээллийн сан үүсгээд байна. Дээрх мэдээллийн санг мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бүхий салбар, үйл ажиллагааны төрлийг илрүүлэх, хууль сахиулах байгууллагуудад гэмт хэргээс олсон орлого, эд хөрөнгийг олж илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тэдгээрийн лавлагаанд хариулах, сэжигтэй гүйлгээнд тактикийн дүн шинжилгээ хийхэд ашигладаг. Түүнээс гадна Санхүүгийн мэдээллийн алба 2009 оноос хойш тайлант хугацаа хүртэл нийт 10042 ширхэг Гаалийн декларацийн мэдээ (5 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгө улсын хилээр нэвтрүүлэхэд мэдүүлдэг мэдүүлэг)-г Гаалийн ерөнхий газраас хүлээн авч мөн мэдээллийн сандаа оруулсан.

Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны гол хэсэг бол ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангуудад дүн шинжилгээ хийж, мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй байх тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах үйл ажиллагаа юм. Эдгээр үйл ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба тайлант хугацаанд нийт 57 сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийж, 21 сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг үндэслэлтэй гэж үзэн хууль сахиулах байгууллагад шалгуулахаар шилжүүлжээ. Ингэснээр Санхүүгийн мэдээллийн алба байгуулагдсан цагаас хойш нийт 106 сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийж, 95 гүйлгээний талаарх мэдээллийг цааш хуулийн байгууллагад дамжуулжээ.

Сэжигтэй гүйлгээнд дүн шинжилгээ хийх, гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэхэд гадаадын Санхүүгийн тагнуулын алба, дотоодын хуулийн байгууллагад дэмжлэг үзүүлэх зорилгоор Санхүүгийн мэдээллийн алба гадаадын 130 санхүүгийн тагнуулын алба, дотоодын 4 хууль сахиулах байгууллага, 3 мэргэжлийн хяналт шалгалт, зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажиллах бололцоог бий болгосон. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд гадаад, дотоодын эдгээр байгууллагатай мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба дотоодын хууль сахиулах байгууллагуудаас ирүүлсэн санхүүгийн мэдээлэл авах 150 хүсэлтийн 137-д, гадаадын санхүүгийн тагнуулын албадаас ирүүлсэн мэдээлэл авах 22 хүсэлтийн 11-т хариу өгсөн байна. Ингэснээр, Санхүүгийн мэдээллийн алба онуудын өссөн дүнгээр дотоодын хууль сахиулах байгууллагуудаас ирүүлсэн санхүүгийн мэдээлэл авах нийт 328 хүсэлтийн 306-д, гадаадын санхүүгийн тагнуулын албадаас ирүүлсэн мэдээлэл авах 35 хүсэлтийн 15-д хариулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу олон нийтэд сургалт, сурталчилгаа хийх ажлын хүрээнд тайлант онд Санхүүгийн мэдээллийн алба нь банк, банк бус санхүүгийн байгууллага болон холбогдох бусад төрлийн байгууллагуудын 625 ажилтан, албан хаагчдад зориулж 13 сургалт, семинар, онуудын өссөн дүнгээр 1178 ажилтан, албан хаагчдад зориулж 27 сургалтыг зохион байгуулсан байна.

Банкны хууль тогтоомжийн хөгжил

Тайлант онд Улсын Их Хурлаас Хөгжлийн банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон Зээлийн мэдээллийн тухай хуулийг баталж, Банкны тухай хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргажээ.

Хөгжлийн банкны тухай хууль

2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр УИХ-аас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль батлав.

Хөгжлийн банк нь улсын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий тусгайлсан чиг үүрэгтэй ашгийн төлөө хуулийн этгээд байх бөгөөд дараах харилцааг зохицуулахаар тусгажээ:

- 1/ тус банкны эрх зүйн байдлыг тодорхойлж, түүний үйл ажиллагааны хүрээ, хязгаарлалт, хяналтын тогтолцоо, хүлээх хариуцлагыг тодорхой болгох;
- 2/ улсын дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох;
- 3/ зээлийн баталгаа, батлан даалт гаргах, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах харилцаа.

Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батлан гаргахаар тусгагдсан бөгөөд Хөгжлийн банкны үйл ажиллагааг банкны тухай хуулиар зохицуулахгүй юм.

Компаний тухай хууль /шинэчилсэн найруулга /

Улсын Их Хурлаас 2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр баталсан Компаний тухай хуулийн шинэчилсэн найруулгад ойролцоогоор 400 орчим нэмэлт, өөрчлөлт орж, компанийг нээлттэй ил тод болгон, хариуцлагын тогтолцоог нарийвчлан гаргаснаараа онцлог болжээ. Уг шинэчилсэн найруулгад хэд хэдэн зарчмын шинжтэй үндсэн өөрчлөлт оржээ:

- 1/ компаний төрөл болон хэлбэр;
- 2/ компаний хяналтын тогтолцоо;
- 3/ төрийн зохицуулагч байгууллага компаний дотоод асуудал, үйл ажиллагаанд хуульд заасан үндэслэлээр оролцох эрх зүйн үндэслэлийг нээлттэй болгов.

Хуулинд олон улсын шалгагдсан компаний засаглалын шилдэг туршлагыг хэрэгжүүлэх талаар тодорхой тусгасанаар компаний засаглалын орчинг

бүрдүүлж, дэлхийн жишигт нийцүүлэхэд түлхэц болох юм.

Түүнчлэн, компаний нэгдэлийн тухай ойлголт түүний дотор нэгдсэн тайлан гаргах зохицуулалтыг бий болгосон, толгой ба охин компани хоорондын харилцаа, үйл ажиллагаанаас үүсэх үр дагавар, хүлээх хариуцлагын зохицуулалтыг өөрчилсөн.

Зээлийн мэдээллийн тухай хууль

Энэ хуулийг 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр баталсан бөгөөд зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, зээлийн мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах; ашиглах, хэрэглэгчид зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх; зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих талаарх харилцааг зохицуулахаар тусгажээ.

Зээлийн мэдээллийн тухай хууль батлагдсанаар банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон энэ хууль, гэрээнд заасан иргэн, төрийн болон хувийн өмчит хуулийн этгээдийн хооронд зээл, төлбөртэй холбогдон үүсэх мөнгөн төлбөрийн үүргийн талаарх мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хяналт тавих эрх зүйн үндсийг бий болгосноороо санхүүгийн салбарын эрсдэлийг нэгдсэн хэлбэрээр нь үнэлж дүгнэх, нэг салбараас нөгөө салбарт хямрал дамнахаас урьдчилан сэргийлэх боломжийг бий болгох, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, шударга өрсөлдөөнийг дэмжихэд чухал алхам болов.

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

Дээрх хуулиуд батлагдсантай холбогдуулан Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулснаар банкны хувьцаа эзэмшигч, банкны хяналтын тогтолцоог сайжруулах, зээлийн мэдээллийн сангийн тогтолцоог бий болгон, түүний мэдээллийн хүртээмжийг боловсронгуй болгох, хууль зүйн нэр томъёог жигдрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно.

Д/д	Огноо	Дугаар	Нэр	Агуулга
1.	2011.01.20	42	Банкны эрх зүйн баримт бичгийг бүртгэх тухай журам	Банкны үйл ажиллагааг зохицуулахтай холбогдон гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэр /тушаал, дүрэм, журам, заавар/-ийг хүлээн авах, Монголбанкны банкны эрх зүйн актын бүртгэлд бүртгэх, хадгалах, холбогдох мэдээлэл лавлагааны сан бий болгохтой холбоотой харилцааг зохицуулсан.
2.	2011.01.31	65	Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл	Банк хоорондын төлбөр тооцоо, гадаад валютаар хийх төлбөр тооцоо, кассын үйлчилгээ, харилцах, хадгаламжийн дансны үйлчилгээ болон бусад үйлчилгээний шимтгэлийн нөхцөлийг батлав.
3.	2011.02.01	70	Төгрөгийн гадаад валют, үнэт металаар илэрхийлэгдэх ханшийн мэдээний загвар	Төгрөгийн ам.доллар болон бусад гадаад валюттай харьцах Монголбанкны албан ханшийг банк хоорондын зах дээр өмнөх өдөр хийгдсэн жигнэсэн дундаж ханшийн мэдээний загварыг шинэчлэн батлав.
4.	2011.04.05	200	Банкны салбарын ажилтны ёс зүйн нэгдсэн мэдээллийн сангийн журам	Банкны салбарын бүх шатны албан тушаалтан, хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, хараат болон хараат бус гишүүдийн хууль, дүрэм, журам, ёс зүйн хэмжээ зөрчсөн талаарх холбогдох мэдээллийг банкны салбарын ажилтны ёс зүйн нэгдсэн мэдээллийн санд төвлөрүүлэн Монголбанк, банк болон эрх бүхий төрийн байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах харилцааг зохицуулсан.
5.	2011.04.20	245	Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам, Банк хоорондын бага дүнтэй гүйлгээг гүйцэтгэх ажлын гэрээ	Монголбанк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасан банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоог Монгол Улсын хэмжээнд түргэн шуурхай, үнэн зөв явуулах, зохион байгуулж гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулсан.
6.	2011.07.08	404	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 16.0 /арван зургаан/ тэрбум төгрөгөөр тогтоов.
7.	2011.08.25	488	Заавал байлгах нөөцийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах тухай	Банкны төгрөгийн болон валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг шинэчлэн тогтоосон.
8.	2011.09.29	553	Төлбөрийн картын журам	Банкны төлбөрийн картын үйл ажиллагааны зарчмуудыг тогтоож, картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулсан.
9.	2011.10.07	572	Төгрөг, юаний своп хэлцлийн журам	Банкуудын юаниар төлбөр түргэн гүйцэтгэх богино хугацааны чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголбанкнаас банкуудтай төгрөг, юаний своп хэлцлийг хийх харилцааг зохицуулсан.

10.	2011.10.07	573	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам	Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн улирлын тайлан, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, асуулга, лавлагаанд хариулсан байдал, гуравдагч эх үүсвэрээс олж авсан мэдээлэл зэрэгт үндэслэн мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас үнэлэлт, дүгнэлт өгөх, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, энэ талаар санал, дүгнэлт боловсруулан журамд заасан холбогдох байгууллагад танилцуулах харилцааг зохицуулсан.
11.	2011.10.25	613	Төв банкны бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	Төв банкны бодлогын хүүгийн хувь хэмжээг шинэчлэн тогтоов.
12.	2011.11.25	691	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны тухай	Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны талаар тусгаж, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны тайланг баталсан.
13.	2011.12.14	726	Зохистой харьцааг шинэчлэн тогтоож, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
14.	2011.12.27	750	Гадаад гуйвуулгын төлбөрийн даалгаврын маягтын бүрдүүлбэрийн тухай	Банкны гадаад гуйвуулгын төлбөрийн даалгаврын маягтын бүрдүүлбэрийг батлав.

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.


Монголбанкны санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Захирлуудын зөвлөл нь 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны үйл ажиллагаа, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүн ба мөнгөн гүйлгээг энэхүү санхүүгийн тайланд үнэн зөвөөр илэрхийлэхийг баталгаажуулах үүрэгтэй.

Захирлуудын зөвлөл нь Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэх, нягтлан бодох бүртгэлийг зөв зохистой хөтөлж явуулдаг бөгөөд санхүүгийн тайлан нь Тодруулга 2-т тусгагдсан шаардлагуудад нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил, дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах нь Захирлуудын үүрэг байдаг.

Энэхүү санхүүгийн тайланг (1-63 дүгээр хуудсанд үзүүлсэн) бэлтгэхдээ зохих бодлогыг баримталж, үндэслэлтэй бөгөөд зохистой шийдэл, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж Захирлуудын Зөвлөл үзэж байна.

Захирлуудын Зөвлөлийн шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:



Л.ПҮРЭВДОРЖ
Монгол банкны Ерөнхийлөгч



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Монголбанкны Захирлуудын Зөвлөлд

Бид Монголбанк (цаашид “Банк” гэх) -ны 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодотголудаас бүрдсэн хавсралтаарх санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (“СТОУС”)-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах, залилан эсвэл алдаанаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардагдах дотоод хяналтыг бүрдүүлэх хариуцлагыг удирдлага хүлээдэг.

Аудиторын хариуцлага

Өөрсдийн гүйцэтгэсэн аудит дээр үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх нь бидний хариуцлага болно. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөх, мөн санхүүгийн тайлангууд материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэл бүхий баталгаа олж авахын тулд аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг агуулдаг. Сонгосон горимууд нь залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд материаллаг буруу илэрхийлэгдсэн байх эрсдэлийн үнэлгээ болон аудиторын мэргэжлийн бусад үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор бус, зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг төлөвлөх үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудаа бэлтгэн үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзан үздэг. Мөн аудит нь даган мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохицол, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын үндэслэлтэй байдал, түүнчлэн санхүүгийн тайлангуудыг толилуулсан ерөнхий байдлын талаарх үнэлгээг агуулдаг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний хязгаарлалттай аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэж байна.

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Сэнтрал Тауэр, 6 давхар, 601
Сүхбаатарын талбай СБД-8, Улаанбаатар 14200, Монгол Улс
У: +976 (11)329088, +976 (11)329089 Ф: +976 (11)322068, www.pwc.com/mn

Хязгаарлалттай дүгнэлт гаргах болсон үндэслэл

Санхүүгийн тайлангийн Тодруулга 13-т тусгасанчлан, 102,000 сая төгрөгийн (2010 оны 12 дугаар сарын 31-нээр 120,000 сая төгрөг) дүнтэй Анод банкинд холбогдох зээлд үнэ цэнийн бууралтын санг Банк байгуулаагүй бөгөөд Анод банк нь 2008 оноос хойш бүрэн эрхт төлөөлөгчийн хяналтанд байна. Удирдлага Монгол улсын Засгийн Газраас уг зээлийн үлдэгдлийг төлүүлж авна гэсэн дүгнэлттэй байгаа бөгөөд Анод банкны зээлийн эргэн төлөлтөнд ашиглагдах Сангийн Яамнаас гаргах засгийн газрын бондын шийдвэрийг хүлээж байгаа болно. Засгийн газрын бондыг гаргах Монгол Улсын Их Хурлын шийдвэр 2012 онд гарахаар хүлээгдэж байна. Гэсэн хэдий ч бондын нөхцөл нь Их Хурлын шийдвэр гарсны дараа тодорхой болох ба урьдчилсан байдлаар уг нөхцөлийг тохирсон талаар аливаа мэдээлэл байхгүй байгаагаас үүдэлтэйгээр тухайн зээлтэй холбоотой ирээдүйн мөнгөн урсгалын хугацаа, дүн нь тодорхой бус байна. Анод банкинд олгосон зээлийн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцох хангалттай мэдээлэл байхгүй байгаагийн улмаас бид 2011 оны 12 дугаар сарын 31, 2010 оны 12 дугаар сарын 31, мөн 2010 оны 1 сарын 1-ний өдрөөрх дотоодын банкуудад олгосон зээлийн дансны үлдэгдэл өртөг буюу бодит үнэ цэнэ, мөн 2010 оны 12 дугаар сарын 31 болон 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан дотоодын банкуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын хасагдуулгын өөрчлөлтийн талаар хангалттай нотолгоо авч чадаагүй болно.

Хязгаарлалттай дүгнэлт

Бидний дүгнэлтээр, “Хязгаарлалттай дүгнэлт гаргах болсон үндэслэл” хэсэгт тусгагдсан асуудлаас үүдэлтэйгээр гарч болзошгүй нөлөөг эс тооцвол, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Банкны санхүүгийн байдал, мөн тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу зөв бодитойгоор илэрхийлсэн байна.



Даваагийн Баярмаа
Гүйцэтгэх Захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Каролин Кларке
Партнер

2012 оны 6 дугаар сарын 7
Улаанбаатар хот, Монгол Улс

Сая төгрөгөөр	Тод- руулга	2011 оны 12-р сарын 31	2010 оны 12-р сарын 31 (залруулсан)	2010 оны 1-р сарын 1 (залруулсан)
Хөрөнгө				
Бэлэн мөнгө		44,505	14,609	47,749
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	7	2,244,580	1,097,256	933,789
Хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	8	212,540	1,087,375	421,759
Хөрөнгө оруулалт - дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших	9	-	72,702	-
Урвууг буцаан худалдан авах хэлцэл	10	678,496	491,280	469,933
Алт ба үнэт металл	11	268,085	125,433	63,388
Засгийн газрын үнэт цаас	12	155,276	53,044	170,000
Дотоодын банкуудад олгосон зээл	13	340,581	130,391	166,988
Үндсэн ба биет бус хөрөнгө	14	26,003	25,568	23,966
Бусад хөрөнгө	15	6,148	2,397	1,149
НИЙТ ХӨРӨНГӨ		3,976,214	3,100,055	2,298,721
Өр төлбөр				
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө		713,351	519,692	371,832
Төв банкны үнэт цаас	16	879,113	1,100,997	392,512
Төрийн байгууллагуудад өгөх өр төлбөр	17	1,170,890	822,381	722,492
Дотоодын банкны харилцах, хадгаламж	18	1,015,230	640,730	541,638
Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр	19	105,412	95,235	112,195
Бусад өр төлбөр	20	58,072	66,527	49,548
НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,942,068	3,245,562	2,190,217
Эзэмшигчдийн өмч				
Дүрмийн сан	21	5,000	5,000	5,000
Хуримтлагдсан алдагдал		(91,799)	(34,331)	-
Ерөнхий нөөцийн сан		-	-	29,961
Бусад нөөц	21	120,945	(116,176)	73,543
НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		34,146	(145,507)	108,504
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		3,976,214	3,100,055	2,298,721

2012 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Удирдлагын Зөвлөлийг төлөөлөн энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөв.


Л.Пүрэвдорж
Монгол банкны Ерөнхийлөгч


М.Амгалан
Төлбөр тооцоо, бүртгэлийн
газрын захирал

Хуудас 93-151-т хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно

<i>Сая төгрөгөөр</i>	Тод- руулга	2011	2010
Хүүний орлого	22	19,669	11,751
Хүүний зардал	22	(118,981)	(70,709)
Хүүний цэвэр зардал		(99,312)	(58,958)
Алт ба үнэт металлын арилжааны цэвэр ашиг	23	43,430	12,189
Валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг	24	252,306	(198,319)
Шимтгэлийн орлого		2,002	1,069
Үйл ажиллагааны бусад орлого		603	746
Үнэ цэнийн бууралтын сангийн буцаалт, цэвэр	25	3,536	9,794
Удирдлагын ба үйл ажиллагааны бусад зардал	26	(22,933)	(20,326)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ АШИГ		179,632	(253,805)
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэглүүрийн цэвэр олз/(гарз):			
-Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз/		21	21
-Борлуулах үед орлогын тайланд шилжүүлсэн		-	(227)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		21	(206)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО (АЛДАГДАЛ)		179,653	(254,011)

Хуудас 93-151-т хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

Сая төгрөгөөр	Тод руулга	Дүрмийн сан	Хуримтлагдсан алдагдал	Ерөнхий нөөцийн сан	Бусад нөөц	Нийт эзэмшигчдийн өмч
2010 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		5,000	-	29,961	73,543	108,504
Тайлант жилийн алдагдал		-	(253,805)	-	-	(253,805)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(206)	(206)
2010 оны нийт дэлгэрэнгүй алдагдал		-	(253,805)	-	(206)	(254,011)
Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	24	-	183,170		(183,170)	-
Бусад нөөцөөс хуримтлагдсан ашигт шилжүүлсэн		-	5,792		(5,792)	-
Борлуулсан барилгын дахин үнэлгээний нөөцийг шилжүүлсэн		-	551		(551)	-
Ерөнхий нөөцөөс хуримтлагдсан ашигт шилжүүлсэн	21	-	29,961	(29,961)	-	-
2010 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		5,000	(34,331)	-	(116,176)	(145,507)
Тайлант жилийн ашиг		-	179,632	-	-	179,632
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	21	21
2011 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	179,632	-	21	179,653
Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	24	-	(222,769)	-	222,769	-
Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	23	-	(14,331)	-	14,331	-
2011 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		5,000	(91,799)	-	120,945	34,146

2010 болон 2011 онд хуримтлагдсан ашгаас (хуримтлагдсан алдагдал) бусад нөөцөд шилжүүлсэн дүн нь хэрэгжээгүй ханшийн өөрчлөлтийн зөрүү болон алтны хэрэгжээгүй ашиг алдагдалтай холбоотой болно (Тодруулга 2).

Сая төгрөгөөр	Тодруулга	2011	2010 (залруулсан)
Тайлант жилийн ашиг (алдагдал):		179,632	(253,805)
<i>Тохируулгууд:</i>			
Алтны дахин үнэлгээний бодит бус ашиг	23	(14,331)	(6,458)
Гадаад валют хөрвүүлгийн хэрэгжээгүй олз/гарз	24	(222,769)	183,170
Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн элэгдэл	14	1,525	2,403
Үндсэн хөрөнгө борлуулсны олз		-	(2)
Сангийн яамны үнэт цаасны борлуулалтын гарз		-	1,000
Акталсан үндсэн хөрөнгө		4	231
Дотоодын арилжааны банкуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын буцаалт	25		(17,375)
Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал/(буцаалт)	25	(3,536)	7,581
Үнэ цэнийн бууралтад орсон зээлийн хүүгийн орлого		-	(492)
Нийгмийн хөгжлийн санд байгуулсан хасагдуулга		4,000	1,500
Хүүгийн орлого	22	(19,669)	(11,751)
Хүүгийн зардал	22	118,981	70,709
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		43,837	(23,289)
Алт ба үнэт металлын цэвэр өсөлт		(128,321)	(55,587)
Урвуу буцаан худалдан авах хэлцлийн өсөлт		(149,132)	(46,112)
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн өсөлт		(70)	205
Дотоодын банкуудад олгосон зээлийн цэвэр өсөлт		(209,899)	46,170
Засгийн газрын үнэт цаасны цэвэр өсөлт		(98,161)	115,956
Бусад хөрөнгийн цэвэр өсөлт		2,965	(809)
Төв банкны үнэт цаасны цэвэр (бууралт)/өсөлт		(230,656)	704,189
Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөрийн цэвэр өсөлт		16,057	1,492
Төрийн байгууллагуудын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт		15,192	(113,808)
Дотоодын банкуудын харилцах, хадгаламжийн цэвэр (бууралт)/өсөлт		(68,632)	153,348
Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт		(12,494)	15,479
Үйл ажиллагаанд (зарцуулсан)/-аас орсон хүүгийн өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ		(819,314)	797,234
Хүлээн авсан хүү		12,418	10,137
Төлсөн хүү		(109,680)	(66,413)
Нийт үйл ажиллагаанд (зарцуулсан)/-аас орсон цэвэр мөнгөн гүйлгээ		(916,576)	740,958

Хуудас 93-151-т хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

<i>Сая төгрөгөөр</i>	Тодруулга	2011	2010 (залруулсан)
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ			
Үндсэн ба биет бус хөрөнгийн худалдан авалт		(3,624)	(4,814)
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалт		(209,455)	(1,143,109)
Санхүүгийн хэрэглүүр борлуулсны орлого		1,096,047	418,964
Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалт		-	(72,702)
Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хэрэглүүр борлуулсны орлого		72,702	-
Үндсэн ба биет бус хөрөнгө борлуулсны орлого		1,660	580
Хөрөнгө оруулалтаас олсон/-д зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ			
		957,330	(801,081)
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Гүйлгээн дэхь бэлэн мөнгөний өсөлт		193,659	147,860
Санхүүжилтийн үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ			
		193,659	147,860
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд валютын ханшийн өөрчлөлтийн үзүүлсэн нөлөө			
		128,828	(76,934)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6	363,241	10,803
		420,833	410,030
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
	6	784,074	420,833

1. Танилцуулга

Монголбанк нь Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор Монгол Улсын Төв Банк (цаашид “Банк” гэх) болон байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Үндсэн Хууль, Төв Банкны тухай Хууль болон бусад хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол Улсад явуулдаг бөгөөд орон нутагт нийтдээ 17 салбар мөн Англи Улсын Лондон хотод нэг төлөөлөгчийн газартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Төв банкны тухай хуульд Банкны үндсэн зорилгыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах болон санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх явдал юм.

Банк ашгийн төлөө ажилладаггүй. Банк нь Засгийн газрын нэг онцгой субъектын хувьд түүний үйл ажиллагааны санхүүгийн үзүүлэлтүүд болон хөрөнгө, өр төлбөр болон эзэмшигчдийн өмчийн бүтэц нь банкы үйл ажиллагааны чиглэлд нь уялдан тодорхойлогддог.

Төв Банкны тухай хуулийн дагуу Банк нь дараах үйл ажиллагааны чиг үүрэгтэй:

- Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, зохицуулах;
- Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлогыг боловсруулах ба хэрэгжүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх (“Засгийн газар” эсвэл “Төрийн”);
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, зохицуулах;
- Бусад банкуудын хувьд үндсэн зээлдүүлэгч нь байх замаар дахин санхүүжүүлэх үйл ажиллагааг;
- Бусад орны Төв банкууд, олон улсын банкууд болон бусад хамтран ажилладаг хуулийн байгууллагуудад Монгол улсыг төлөөлөн ажиллах;
- Хуулинд заасны дагуу бусад санхүү зээлийн үйл үжллагааг явуулах.

Хуульд заасны дагуу Банк арилжааны банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор тэдэнд зээл олгох, хоёрдогч зах зэл дээр үнэт цаас худалдах ба худалдан авах, гадаад валют, үнэт металлыг худалдах ба худалдан авах, дотоодын болон гадаадын зах зээл дээр үнэт метал болон энгийн металаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаасыг гаргах үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газар болон Сангийн Яам (Монгол Улсын засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага) гэх мэт бусад төрийн байгууллагуудын дансуудыг өөр дээрээ байршуулах болон олон улсын байгууллагуудын дансыг мөн өөр дээрээ байршуулан шаарлагатай тохиолдолд дэмжиж ажиллах үүрэгтэй.

Монгол Улсын засгийн газар Банкны дүрмийн санг бүрэн хэмжээгээр эзэмшдэг.

Хуульд заасны дагуу Банкны Зөвлөлийн үндсэн үүрэг нь мөнгөний бодлогын зарчмыг тодорхойлж, үүний хэрэгжилтэнд хяналт тавих юм. Мөн, Банкны Зөвлөл нь Банкны дараа жилийн төсвийг болон тухайн жилийн санхүүгийн тайланг батлах, нийтэд тайлагнах болоод бусад хуульд заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Бүртгэгдсэн хаяг ба үйл ажиллагаа явуулж буй хаяг. Төв банкны бүртгэгдсэн албан ёсны хаяг нь: Бага Тойруу 9, Улаанбаатар 46, Монгол Улс.

Тайлагналын мөнгөн нэгж. Энэхүү санхүүгийн тайлан нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох “Төгрөг”-өөр, саячилсан дүнгээр илэрхийлэгдсэн болно.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Тайлан бэлтгэх үндэслэл. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (“СТОУС”)-ын дагуу, санхүүгийн хэрэглүүрүүдийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх, мөн борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг дахин үнэлэн бүртгэхээс бусад тохиолдолд түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан бэлтгэгдсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Тус бодлогуудыг өөрөөр заагаагүй бол толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай хэрэгжүүлсэн болно (Тодруулга 4-өөс үзнэ үү).

Санхүүгийн хэрэглүүрүүд – гол нэр томъёо. Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилалаас хамааран тэдгээрийг дор тайлбарласны дагуу бодит үнэ цэнэ, өртөг эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгадаг.

Бодит үнэ цэнэ нь мэдлэг бүхий холбоогүй талууд хоорондоо хөрөнгө солилцох эсвэл өр төлбөр барагдуулах үнийг хэлнэ. Бодит үнэ цэнэ нь санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл дээр зарласан өнөөгийн худалдаж авах үнэ, санхүүгийн өр төлбөрийн хувьд өнөөгийн худалдах үнэ болно. Хоорондоо саармагжих зах зээлийн эрсдэл бүхий хөрөнгө болон өр төлбөрийн хувьд Банк бодит үнэ цэнийг тогтоохдоо хоорондоо хаагдах хэсэгт зах зээлийн дундаж үнийг ашиглаж цэвэр буюу нээлттэй позицитай хувьд худалдах эсвэл худалдан авах үнийг зохих ёсоор ашиглаж болно. Санхүүгийн хэрэглүүрийн үнийг хөрөнгийн зах зээл эсвэл бусад байгууллагаас тогтмол хугацаанд нийтэд зарладаг бөгөөд бүгдэд нээлттэйгээр зах зээл дээр холбоогүй этгээд хооронд бодит гүйлгээ тогтмол хийгддэг тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийг идэвхитэй зах зээл дээр санал болгосон гэж үзнэ.

Зах зээлийн үнийн талаар мэдээлэл олдохгүй тохиолдолд зарим санхүүгийн хэрэглүүрүүдийг тэдгээрийн бодит үнэ цэнийг санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн дискаунтлагдсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар эсвэл үнэлгээний бусад аргачлалыг ашиглан тооцно. Үнэлгээний аргачлалуудад зах зээлийн нээлттэй мэдээлэлд тулгуурлах боломжгүй үед таамаглал ашигладаг. Хэрэв тус санхүүгийн тайлангуудад тийм таамаглал ашигласан бөгөөд уг таамаглалыг зохистой хэмжээгээр өөрчилснөөр ашиг, орлого, нийт хөрөнгө эсвэл нийт өр төлбөрийн дүнгүүд мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчлөгдөх тохиолдолд зохих тодруулгыг хийсэн болно.

Өртөг нь хөрөнгийг худалдаж авахад төлсөн мөнгө болон түүнтэй адилтгах зүйл эсвэл тухайн хөрөнгийн зах зээлийн үнээр илэрхийлэгдэх бөгөөд үүнд *гүйлгээний зардлуудыг* багтааг тооцдог. *Өртгийн* тооцоолол нь зах зээл дээр тодорхой жишиг үнэгүй буюу үнэ цэнийг нь бодитойгоор тодорхойлох боломжгүй хөрөнгөд хийсэн хөрөнгө оруулалтыг хэмжих үед ашиглагддаг. (дэлгэрэнгүйг Тодруулга 8-аас үзнэ үү).

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд агент, борлуулагч агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад, зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг болон хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлэлтэнд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу урамшуулал, санхүүгийн зардлууд, дотоодын удирдлагын буюу хадгалалтын зардлууд орохгүй.

Хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн төлбөрөөрх эргэн төлөлтийг хасан, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрсөн урамшууллын хойшлогдсон гүйлгээний зардал, мөн хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан урамшуулал буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй бөгөөд тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь холбогдох зүйлийн дансны үнэд оруулан тусгасан болно.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгах аргаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтлаж санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн хувь болно. Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалыг хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Тийм урамшуулал, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд өгч авалцах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрөх. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд нь анх бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардал нэмсэн дүнгээр бүртгэгддэг. Гүйлгээ хийсэн үнэ нь анх бүртгэх бодит үнэ цэнийг баталгаажуулах нотолгоо болно. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарзыг бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнийг зөвхөн гүйлгээний зардлыг тооцоохдоо ижил төрлийн хэрэглүүрийг зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэл дээр үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад хүлээн зөвшөөрнө.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон (“хэвийн” худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Банк тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Банк санхүүгийн хэрэглүүрийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах. Банк санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ Банк бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй тохиолдолд. Холбогдох тал хөрөнгийн борлуулалтанд нэмэлт хязгаарлалт хийлгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө. Гадаад болон дотоод хөрвөх чадварын өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор тодорхой хэмжээний мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлийг багтаадаг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд богино хугацааны мэдэгдлээр зарцуулж болох 3-аас доош сарын хугацаатай байршуулсан хугацаатай хадгаламж болон хугацаагүй хадгаламжаарх санхүүгийн хөрөнгө болон төгрөгөөр илэрхийлэгдсэн төрийн байгууллагууд, дотоодын банкуудын хугацаагүй хадгаламж орно. Тодруулга 6-аас харна уу Зарцуулалтад хязгаарлалт хийснээс эсвэл хөрвөх чадвар муутайгаас мөнгөнд шууд хөрвөдөггүй санхүүгийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулаагүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн арга ашиглан, хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Алт болон үнэт металлууд. Алтанд гадаадын банкинд байршуулсан олон улсын стандартаарх алтан болон мөнгөн гулдмай багтдаг. Алт нь олон улсын нөөцийн нэгээхэн хэсгийг илэрхийлнэ. Банкны металлууд нь трой унцаар хэмжигдэн бүртгэгдэх ба Монголбанкны албан ханшаар үнэлэгдэн төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Арилжааны албан ханшийг Лондонгийн Алтны Захын Холбооноос зарласан үнэт металлын ам долларын ханшид тулгуурлан Монголбанкны зарласан төгрөг/ам долларын ханшаар хөрвүүлэн төгрөгт илэрхийлдэг. Банк алтыг ийм байдлаар алтыг эзэмшихээс гадна Монгол дахь үйлдвэрлэгч, аж ахуй нэгжүүдээс цэвэршүүлээгүй алтыг худалдан авч худалдаалдаг. (Тодруулга 11-ээс харна уу)

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Алтыг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр тусгах бөгөөд өдөр бүр дахин үнэлгээг хийдэг. Бодит үнэ цэнийг тодорхойлохдоо алтны зах зээлийн үнэ цэнийг харгалзан үзнэ. Дахин үнэлгээний олз гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит бус ашиг алдагдлыг жилийн эцэст хуримтлагдсан ашгаас эзэмшигчдийн өмч дэх бусад нөөцийн “Үнэт металлын үнэлгээний нөөц” рүү хаана.

Бусад үнэт металл (алт, бусад хольц металл болон гулдмай, мөнгөний хүдэр), зоос болон соёлын үнэт зүйлсийг Банкны эрдэнэсийн санд хадгалдаг. Бусад үнэт металлыг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тусгадаг.

Гадаад валютаарх ажил гүйлгээ. Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм. Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг төлбөр төлсөн өдөр буюу анх хүлээн зөвшөөрсөн өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэх ба үүнээс хойш албан ханш өөрчлөгдөх бүр дахин үнэлнэ. Тайлант хугацааны эцэст гадаад валютаарх мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлант хугацааны өдрийн албан ханшаар төгрөг рүү хөрвүүлэн бүртгэнэ.

Гадаадын валютаарх мөнгөн бус хөрөнгө нь түүхэн өртөг (тухайн хөрөнгийг худалдаж авсан өдрийн Монгол төгрөгийн гадаад валюттай харьцах ханшаар үнэлнэ)эсвэл хамгийн сүүлд хөрвүүлсэн бодит үнэ цэнийг тооцсон дахин үнэлгээгээр бүртгэгддэг.

Мөнгөөр илэрхийлэгдэх гадаад валютаарх балансын үлдэгдлийг төгрөгт хөрвүүлэхэд ашигласан албан ханшийг дор харуулав:

	2011.12.31 (Төг)	2010.12.31 (Төг)
1 ам.доллар	1,396.37	1,257.18
1 (SDR) Зээлжих тусгай эрх	2,137.00	1,936.10
1 евро	1,806.76	1,679.97

Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө. Банк харилцагч банк руу арилжааны бус зорилгоор мөнгө шилжүүлснээр хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, дериватив бус, тусгайлан заасан буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлага үүсэх үед бусад банкуудад байршуулсан хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Эдгээр нь СТОУС-ын дагуу зээл ба авлага хэмээн ангилагддаг. Бусад банкуудад байршуулсан хөрөнгийг анх бүртгэхдээ бодит үнэ цэнэ дээр нь гүйлгээний өртгийг нэмэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Банкууд олгосон зээл болон засгийн газрын үнэт цаас. Банк харилцагчдаасаа хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, дериватив бус авлагыг тусгайлан заасан буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх, цааш арилжих зорилгогүйгээр мөнгө шилжүүлсэн үед, Банкууд болон бусад харилцагчдад (жишээ нь Сангийн Яам) олгосон зээлийг хүлээн зөвшөөрнө. Эдгээр нь (Сангийн яамнаас гаргасан засгийн газрын үнэт цаасыг багтаан) СТОУС-ын дагуу зээл ба авлага хэмээн ангилагддаг. Бусад банкуудад байршуулсан хөрөнгийг анх бүртгэхдээ бодит үнэ цэнэ дээр нь арилжааны өртгийг нэмэн хүлээн зөвшөөрөх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Худалдах, буцаан худалдан авах хэлцлүүд ба үнэт цаасны зээлжилт. Харилцагч этгээдэд зээлдэгч буцаан төлөхөөр олгогддог худалдах буцаан худалдан авах хэлцэл (“репо хэлцэл”)-ийг баталгаажсан санхүүгийн гүйлгээ гэж үздэг. Репо хэлцлээр худалдсан үнэт цаасыг бүртгэлээс хасдаггүй. Санхүүгийн байдлын тайланд үнэт цаасны ангилалыг өөрчилдөггүй боловч үнэт цаасаа шилжүүлж буй тал гэрээний дагуу эсвэл тогтсон заншлын дагуу үнэт цаасыг зарах эсвэл барьцаанд өгөх эрхтэй тохиолдолд үнэт цаасыг эргэн худалдан авах авлага гэж ангилна.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Зээлдэгчээс Банкинд эргэн төлөхөөр олгосон эргүүлэн худалдах хэлцлийн дагуу худалдан авсан үнэт цаас (“урвуу репо хэлцэл”)-ийг гадаад байгууллагаас авах авлага эсвэл дотоодын банкинд олгосон зээлийн аль тохиромжтойгоор нь бүртгэнэ. Худалдах болон дахин худалдан авах үнийн зөрүүгээр хүүгийн орлого хүлээн зөвшөөрөх ба репо хэлцлийн хугацааны турш үр ашигт хүүний аргаар хуримтлуулна.

Санхүүгийн хөрөнгө оруулалт - дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших. Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт нь идэвхитэй санхүүгийн зах зээл дээр арилжаалагддаг тусгайлан тогтоосон хугацаа эсвэл тодорхойлох боломжтой бүхий Банкны байршуулж үр ашгийг нь хүртэх зүрилготой үнэт цаасыг хэлнэ. Удирдлага эдгээр хөрөнгө оруулалтын ангилалыг анх хүлээн зөвшөөрөхдөө ангилах ба тайлант жил бүрийн эцэст ангилалыг зохистой байдлыг дахин нягталж үздэг. Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаасыг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт. Санхүүгийн хөрөнгийг анх бүртгэснээс хойш тохиосон нэг буюу олон үйл явдлын (“гарз учруулсан үйл явдлууд”) үр дүнд санхүүгийн дан ганц эсвэл бүлэг хөрөнгөөс ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын хэмжээ өөрчлөгдсөн бөгөөд үнэн зөв тооцох боломжтой тохиолдолд тайлант жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоог тодорхойлоход дараах гарз учруулах үйл явдлуудын мэдээлэл багтана:

- зээлдэгч санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлд орсон;
- зээлдэгч гэрээгээ зөрчсөн;
- зээлдэгч дампуурлаа зарлах буюу бусад санхүүгийн бүтцийн өөрчлөлт хийхээр магадлалтай;
- зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй холбоотойгоор зээлдүүлэгч концессын өөрчлөлт хийх (жишээ нь, хүүгийн хувийг өөрчлөх эсвэл эргэн төлөгдөх хугацааг сунгах гэх мэт);
- Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш бүлэг санхүүгийн хөрөнгөөс орж ирэх ирээдүйн мөнгөн урсгал хэмжигдэхүйц буурсныг тодорхойлох мэдээлэл.

Банк харьцангуй цөөхөн зээлдэгчид (харилцагч болон бусад зээлдэгчидтэй)-тэй учир санхүүгийн хөрөнгөө нэг бүрчлэн үнэлдэг. Жишээ нь, Монголбанк бүх авлага болон бусад санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлдэг.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн анхны үр ашигт хүүгээр дискаунтлан хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ (зардлаар хүлээн зөвшөөрөгдөөгүй ирээдүйн зээлийн алдагдал орохгүй) хүртэл хасагдуулгын дансаар хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа үнэ цэнийн бууралтын хэмжээ багасвал энэхүү бууралт нь үнэхээр дараа тайлант үед илэрсэн нь тогтоогдсоныг нягтлан өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасагдуулгын данснаас орлогын тайлангаар залруулан буцаалт хийнэ.

Хэрэв үнэ цэнэ буурсан хөрөнгийн нөхцлийг өөрчлөн дахин тохиролцсон эсвэл нөхцлүүдийг зээлдэгч санхүүгийн байдал муудсанаас өөрчилсөн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг нөхцөл өөрчлөгдөхийн өмнөх үр ашигт хүүг ашиглан тооцно. Хөвөгч хүүтэй зээл гаргасан тохиолдолд үнэ цэнийн бууралтыг тухайн үеийн үр ашигт хүүг ашиглан тооцно.

Эргэн төлөгдөх боломжгүй болсон хөрөнгийг данснаас хасахдаа хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авсны дараа үнэ цэнийн бууралтын сан руу хаана.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас. Банк тодорхой бус хугацаагаар эзэмшиж буй өрийн үнэт цаас, өмчөөрх хөрөнгө оруулалтууд (охин компани эсвэл хараат компани биш компанийн дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт) борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтад багтана. Өрийн үнэт цаасыг анх бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг оруулсан дүнгээр хүлээн зөвшөөрдөг ба үүний дараа бодит үнэ цэнээр бүртгэнэ. Өрийн үнэт цаасаарх борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн арга ашиглан тухайн тайлант хугацаанд орлогын тайланд тусгана. Бусад бүхий л бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Энэ нь хуримтлагдсан олз эсвэл гарзыг бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас тухайн тайлант үеийн орлогын тайланд шилжүүлсэн үед данснаас хасах эсвэл үнэ цэнэ буурах хүртэл үргэлжилнэ.

Өмчөөрх хөрөнгө оруулалтыг анх өртгөөр хүлээн зөвшөөрдөг ба түүний дараа өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр тусгадаг. Учир нь бодит үнэ цэнэ нь энэхүү хөрөнгө оруулалтын дүнг хангалттайгаар илтгэж чадахгүй. Тодруулга 8-аас харна уу.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрснөөс хойш тохиосон нэг буюу олон үйл явдлын (“гарз учруулсан үйл явдлууд”) үр дүнд үүссэн үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрнө. Өмчийн хэрэгслийн бодит үнэ цэнэ түүний өртгөөс доош их хэмжээгээр буюу үргэлжлэн буурах нь тухайн хэрэгсэл үнэ цэнээ алдсаны шинж тэмдэг болно. Худалдан авах өртөг болон тухайн үеийн бодит үнэ цэнийн зөрүү болох хуримтлуулсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг бусад дэлгэрэнгүй орлогоос орлогын тайланруу ангилна.

Үүсмэл санхүүгийн хэрэглүүр. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрт дотоодын банкуудтай хийсэн гадаад валютын форвард хэлцэл гэх мэт гадаад валютын хэлцлүүдийг голдуу оруулна. Бүх дериватив санхүүгийн хэрэглүүрүүд бодит үнэ цэнэ нь эерэг бол хөрөнгөөр, сөрөг тохиолдолд өр төлбөрөөр тусгагдана. Бодит үнийн өөрчлөлтийг тухайн жилийн орлого, зарлагаар хүлээн зөвшөөрнө. Банк хеджийн бодох бүртгэл хөтөлдөггүй.

Бусад хөрөнгө. Бусад хөрөнгө нь голдуу авлага болон урьдчилж төлсөн зардлаас бүрдэнэ. Авлага нь аккрузл сууриар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Авлагыг гэрээний дагуу эрх үүссэн үед хүлээн зөвшөөрнө. Урьдчилж төлсөн зардлыг төлбөр хийгдсэн үед хүлээн зөвшөөрч тухайн ажил үйлчилгээ нь хийгдсэний дараа дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэнэ. Хэрэв Банкинд тухайн авлага нь төлөгдөхгүй гэдгийг батлах хангалттай нотолгоо олсон бол, найдваргүй авлагын санг байгуулах ба авлагын дүнгээс нөхөн төлөгдөхгүй хэмжээг тооцон гаргаж уг дүнг байгуулсан найдваргүй авлагын санг авлагын дүнг төлөгдөх боломжтой хэмжээ хүртэл нь бууруулна. Үнэ цэнийн бууралтыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Банк авлагын үнэ цэнийн бууралтыг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг бусад санхүүгийн хөрөнгийг үнэлдэг аргаар тодорхойлно.

Байшин барилга болон үндсэн хөрөнгө. Барилгыг доор дурдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнэ бууралтын зардлыг хассан дүнгээр тусгадаг.

Банкны эзэмшиж буй барилгыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Барилга байгууламжийн дансны үнэ нь бодит үнээс материаллаг зөрүүтэй эсэхийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлнэ. Дансны үнэ дахин үнэлгээгээр нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн дүнгээр бусад дэлгэрэнгүй орлогыг болон өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний санг нэмэгдүүлнэ. Тухайн хөрөнгийн өмнө үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөд өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нөөцийг бууруулна; бусад бүх бууралтыг (илүү гарсан бүхий) тухайн жилийн орлого зарлагад хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүн бодитоор хэрэгжих үед барилга байгууламжийн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан алдагдал эсвэл хуримтлагдсан ашиг руу шууд хаана. 2010 болон 2011 оны 12 дугаар сарын 31-ий өдөр барилга байгууламжийн дансны үнэ бодит үнэ цэнээс материаллаг зөрүүтэй байгаагүй гэж Удирдлага үзэж байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Банкны эзэмшиж буй тоног төхөөрөмжийг үнэ цэнэ бууралтын алдагдал болон элэгдлийг өртгөөс хассан дүнгээр бүртгэнэ. Урсгал засварын зардлыг гарсан үед зарлагадана. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн аль нэг бүрэлдэхүүн хэсгийг сольсон томоохон зардлыг капиталжуулж, сольсон хэсгийг ашиглалтаас хасна.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг илэрсэн эсэхийг удирдлага тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Тийм шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь нөхөн сэргээгдэх өртгийг тооцож, дансны үнийг нөхөн сэргээгдэх өртөг хүртэл бууруулан гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэдэг (хэрэв тухайн өөрийн хөрөнгө дэх хөрөнгийн дахин үнэлгээний сангийн дүнгээс давсан тохиолдолд). Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ, бодит үнэ цэнэ эсвэл борлуулах өртгийн тооцоолдолд өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах бичилт хийнэ.

Борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулж тооцох бөгөөд олз, гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэнэ (бусад үйл ажиллагааны орлого, зардал хэсэгт).

Элэгдэл. Дуусаагүй барилгыг элэгдүүлдэггүй. Үндсэн хөрөнгийн бусад зүйлүүдийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь элэгдүүлнэ:

	<u>Ашиглалтын хугацаа, жилээр</u>
Байгууламж	25 – 60 жил
Тавилга, оффисын тоног төхөөрөмж	8 – 10 жил
Компьютер ба техникийн тоног төхөөрөмж	5 – 10 жил
Машин	6 – 8 жил

Ашиглаглалтын хугацаа нь дуусаж байгаа хөрөнгийг Банк тухайн үед борлуулснаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнгээр үлдэх өртгийг тооцдог. Хөрөнгийн үлдэгдэл өртөг, ашиглаглалтын хугацааг тайлант үе бүрийн эцэст дахин үнэлж шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

Биет бус хөрөнгө. Банкны биет бус хөрөнгө нь тодорхой ашиглалтын хугацаатай бөгөөд үндсэндээ капиталжуулсан компьютерын программ хангамжийн лицензүүд багтсан байна.

Худалдан авсан компьютерийн программ хангамжийн лицензүүдийг тэдгээрийг худалдан авч ашиглахад бэлэн болгоход гарсан зардлаар бүртгэлд тусгасан..

Биет бус хөрөнгүүдийг тэдгээрийн ашиглаглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна:

	<u>Ашиглалтын хугацаа, жилээр</u>
Компьютерийн программ хангамж (үндсэн банкны программ)	3 жил

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө. Гүйлгээн дэх бэлэн мөнгө ба зоосны хэмжээ нь 1993 оны 9-р сард Банкнаас нэвтрүүлсэн төлбөр тоцоо гүйцэтгэхэд хэрэглэгдэж буй цаасан мөнгөн тэмдэгт болон зоосны нэрлэсэн үнэ цэнийг илэрхийлнэ. Банк бусад банкуудад болон бусад харилцагчиддаа бэлэн мөнгө олгох үед гүйлгээн дэх бэлэн мөнгө ба зоос нь нэрлэсэн үнээрээ өр төлбөр болон бүртгэгдэнэ. Банкны төв фонд болон буй гүйлгээ кассд буй төгрөгөөрх бэлэн мөнгийг гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөнд оруулахгүй.

Төв Банкны үнэт цаас. Банкны гаргасан үнэт цаас нь бодит үнэ цэнээрээ анхлан бүртгэгдэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргаар, хорогдуулсан өртгөөрөө бүртгэгддэг. Хорогдуулсан өртгийг үнэт цаасыг гаргахад тооцсон хөнгөлөлт, урамшуулал болон үнийн дүнд үндэслэн үр ашигт хүүгийн аргаар бодно.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Зээл. Банк авсан зээлээ үр ашигт хүүгийн аргаар, хорогдуулсан өртгөөрөө бүртгэдэг ба эдгээр зээл нь Герман Улсын засгийн газар болон Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтын хөтөлбөртэй холбоотойгоор Сангийн Яамнаас авсан урт хугацаат зээлүүд бөгөөд өр төлбөр хэсэгт Төрийн байгууллагад өгөх өглөг хэмээн бүртгэгдсэн болно (Тодруулга 17-аас харна уу). Мөн зээлд HSBC банкнаас авсан зээл багтах ба Гадаадын этгээдэд төлөх өр төлбөр хэмээн бүртгэсэн болно (Тодруулга 19-аас харна уу).

Гадаадын этгээдэд төлөх өр төлбөр. Гадаадын этгээдэд төлөх өр төлбөр нь бодит үнэ цэнээрээ анхлан бүртгэгдэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргаар, хорогдуулсан өртгөөрөө бүртгэгддэг (Тодруулга 19-аас харна уу).

Төрийн байгууллагуудад өгөх өглөг. Засгийн газар болон Бусад Төрийн байгууллагуудын дансанд нь Засгийн газар болон Бусад харилцагчдад төлөх үүсмэл бус өр төлбөр ба хорогдуулсан өртгөөрөө бүртгэгддэг.

Дотоодын банкнуудын хадгаламж. Банкинд харилцагч банкуудаас мөнгө шилжин орж ирэхээр нь дотоодын банкуудын хадгаламжийг хүлээн зөвшөөрдөг. Үүсмэл бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр нь бүртгэнэ.

Өр төлбөр болон зардлын сан. Энэ нь цаг хугацаа ба дүн нь тодорхойгүй санхүүгийн бус өр төлбөр юм. Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн хууль зүйн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага байгаа бөгөөд энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн үр ашиг бүхий баялгийг зарцуулах нь тодорхой болсон үед санг байгуулах ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоогоор тооцоолох боломжтой байх ёстой..

Худалдааны болон бусад өглөг. Харилцагч талаас үзүүлэх ажил үйлчилгээгээ гэрээний дагуу үзүүлсэн тохиолдолд худалдааны өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрнө.

Олон Улсын Валютын Сан болон Банкны хамтын үйл ажиллагаа. Олон Улсын Валютын Сан (ОУВС) болон Монгол улсын хамтын ажиллагааны хувьд Банк нь Засгийн газрын хадгалагч банкны үүрэг гүйцэтгэдэг. Сангийн Яам нь Монгол Улсын хэрэгжүүлэгч агентаар ажилладаг. Тиймээс ОУВС-аас олгосон санхүүжилттэй холбоотой нэхэмжлэл нь Банкинд бус Сангийн Яаманд харьяалагдах ёстой ба тэрхүү хөрөнгө нь Монголбанкны тайланд тусгагдахгүй. Эдгээрийг балансын гадуурх дансанд бүртгэнэ. Үүнд, ОУВС-д оруулсан хувь хөрөнгө, Стэндбай болон Ядуурлыг Бууруулах, Өсөлтийг Хангах хөтөлбөрийн зээл багтдаг (Тодруулга 27-оос харна уу).

Энэхүү санхүүгийн тайлангийн хөрөнгө хэсэгт Зээлжих Тусгай Эрхийн (ЗТЭ) хадгаламжийн дүнг багтаасан. (Тодруулга 7-оос харна уу). Мөн өр төлбөрийн хэсэгт ЗТЭ-ийн хуваарилалт, ОУВС дах 1 ба 2-р дансны үлдэгдэл багтсан. ОУВС дах 1-р данс нь ОУВС-д оруулсан хувь хөрөнгийн төлбөр, санхүүжилтийг хүлээн авах, эргэх төлөх зэрэг ажил гүйлгээнд хэрэглэгддэг. ОУВС-ын 2-р данс нь монгол төгрөгөөр ОУВС-д төлөх төлбөр тооцоонд хэрэглэгддэг. (Тодруулга 19-өөс харна уу).

Зээлжих Тусгай Эрхээр илэрхийлэгдсэн хөрөнгө ба өр төлбөр нь тайлант өдрийн Монголбанкны Төгрөг ба ЗТЭ-ийн албан ханшаар төгрөгт хөрвүүлэгддэг. Энэхүү хөрвүүлгийн ханш нь ОУВС-аас тогтоосон ам.доллар/ЗТЭ-ийн албан ханш ба Монголбанкны ам.доллар/төг-ийн ханшид үндэслэн тооцоологддог. ЗТЭ-ийн хадгаламжаас олсон хүүгийн орлогыг Дэлгэрэнгүй Орлогын тайлангийн Хүүгийн орлого хэсэгт, ЗТЭ-ийн хуваарилалтаас үүссэн зардлыг Хүү ба хураамжийн зардал аль тохиромжтой хэсэгт тус тус тайлагнасан.

Дүрмийн Сан. Дүрмийн сан нь эзэмшигчдийн хөрөнгө хэмээн ангилагддаг. Тодруулга 21-ээс харна уу.

Ерөнхий нөөцийн сан. Ерөнхий нөөцийн санд Банкны тодорхой хугацааны туршид хуримтлуулсан Банк өөрөө зарцуулах бүрэн эрхтэй цэвэр ашгийг оруулдаг. Энэ санд Улсын төсөвт хуваарилсан ба цаашид хуваарилах дүнг оруулдаггүй, учир нь эдгээр нь Засгийн газарт тухайн жилдээ багтаад шилждэг. Тодруулга 21-ээс харна уу.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Бусад нөөц. Бусад нөөцөд бодит бус ханшийн олз/гарз, мөнгөжсөн алт болон үнэт металлын (мөнгө) дахин үнэлгээний олз/гарз, нөөцийн дахин үнэлгээ (барилга байгууламжтай холбоотой) болон борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын нөөцийн санг оруулдаг. Тодруулга 21-ээс харна уу. Банк өөрсдийн бодлогынхоо дагуу орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн бодит бус ханшийн олз, гарз болон мөнгөжсөн алт, үнэт металлын (мөнгө) дахин үнэлгээний олз/гарзыг бусад нөөцөд жил бүрийн эцэст шилжүүлдэг.

Цэвэршүүлэлт. Цэвэр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн цэвэр дүнгээрээ хөрөнгө ба өр төлбөрийн аль зохистой талд бүртгэгдэх хууль зүйн эрх байгаа бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь хааж, үлдэх дүнг тайланд тусгана.

Зээлтэй холбоотой үүрэг хариуцлага. Банкинд зээлтэй холбоотой үүрэг хариуцлага байгаа бөгөөд үүнд аккредит болон Хятадын Ардын Банк (БНХАУ-ын Төв Банк, цаашид “ХАБ” гэх) –тай байгуулсан хэлэлцээр орно. Хэлэлцээр нь ХАБ-аас Банкинд юаниар олгосон зээлийн хэрэгсэл ба Банкнаас ХАБ-д төгрөгөөр олгосон зээлийн хэрэгсэл юм. (Тодруулга 27-г харна уу).

Тайлант жилийн эцэст төлбөрийн үүрэг хариуцлага нь 1) анхны хүлээн зөвшөөрөлтөөр хорогдуулаагүй үлдсэн дүн ба 2) тайлант жилийн эцэст төлбөрийн үүрэг хариуцлагыг дуусгавар болгоход шаардагдах мөнгөний бодитой таамаглал хоёрын аль ихээр нь хэмжигддэг. Хэрэв дуусгавар болгоогүй төлбөрийн үүрэг хариуцлагын дүнд хураамж төлдөг бол энэ нь тухайн үүргийн хүчинтэй хугацааны турш орлого болон хүлээн зөвшөөрнө.

Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт. Хүүгийн орлого, зардлыг өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэль суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг аккруэль суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн байгаа үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

Бэлэн мөнгө гаргахтай холбогдон гарах зардлууд. Банк нь Монгол улсын цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосыг гаргадаг. Цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосыг гаргахтай холбоотой урьдчилж гарсан зардал нь “Бусад хөрөнгө” хэсэгт бүртгэгдэх ба тэдгээр нь үйлдвэрлэлээс Төв Банкны санд шилжих үед “Зардал” болгон бүртгэнэ.

Ажиллагсадын зардал болон холбогдох шимтгэлүүд. Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Банкны ажиллагсад холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд хүлээн зөвшөөрдөг. Цалинтай ээлжийн амралт болон нөхөн олговортой бусад богино хугацаат хуримтлагдах чөлөө авалтыг ажиллагсад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, нөхөн олговортой богино хугацаат хуримтлагдахгүй чөлөө авалтыг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авалтыг) чөлөө авах үед тус тус хүлээн зөвшөөрдөг.

Удаан жил ажилласан ажиллагсадын тэтгэвэр, тэтгэмж. Өөрийн дотоод журмандаа үндэслэн Банк ажилчиддаа тэтгэвэрт гарах үед нь (тэтгэвэрт гарахаас өмнө Банкинд хэдэн жил ажилласнаасаа хамаараад) цалингийн тодорхой хэмжээг олгох үүрэгтэй. Зарим холбогдох төлбөрүүдийг Нийгмийн Хөгжлийн Санд оруулсан байдаг (Тодруулга 20-оос харна уу). Удирдлага 2010 оны 12-р сарын 31-нээс 2011 оны 12-р сарын 31-ээрх Нийгмийн Хөгжлийн Сан нь эдгээр богино болон урт хугацаат төлбөрүүдээ (Нийгмийн Хөгжлийн Сан нь үүнд зориулан байгуулагдсан болно) бүрэн төлөх боломжтой хэмээн үзэж байна. Мөн тэтгэвэрийн олгогдсон бодит хэмжээ нь тайланд тусгагдсан тэтгэвэр тэтгэмжийн төлвөл зохих хэмжээнээс хүлээн зөвшөөрөгдөөгүй бодит олз/гарз болон гарсан үйлчилгээний зардлыг хассан дүнгээс материаллаг хэмжээгээр зөрөхгүй гэж итгэж байна.

Орлогын албан татвар. Монгол Улсын Эдийн засгийн байгууллагын тухай болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулинд зааснаар, Банк нь орлогын албан татвараас чөлөөлөгдсөн байдаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Залруулга. 2011 онд Банкны удирдлага Монголбанк ба ОУВС-ын хамтын ажиллагааны харилцаан дахь Монгол банкны оролцоонд нарийвчилсан судалгаа хийсэн. Үүний үр дүнд удирдлага ОУВС-ын хамтын ажиллагаанд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлдээ зарим нэгэн өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж үзсэн. Үүнээс гадна, Азийн Хөгжлийн Банк, Германы Засгийн Газар (зээлдүүлэгч) болон Монгол Улсын засгийн газрын (зээлдэгч) хооронд хийгдсэн зээлийн гэрээтэй холбоотойгоор гэрээний харилцаагаа дахин нягтлалсан. Мөн үндэсний мөнгөн тэмдэгтийг гаргагчийн байр сууринаас мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийн тодорхойлолтыг дахин хянасан. Ингэснээр НББОУС 8 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бүртгэлийн тооцоолол болон алдааны өөрчлөлт”-ын дагуу доорх залруулгууд болон дахин ангилалыг энэхүү санхүүгийн тайланд хийсэн:

- *ОУВС-тай хамааралтай дүн.* 2010 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон болон өмнөх жилүүдийн Банкны данс хөтлөлт ба СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн тайланд ОУВС-тай холбоотой зарим дансад (ОУВС-аас олгосон хувь хөрөнгө ба зээл, ЯБӨХ Хөтөлбөрийн дагуу олгосон зээл) СТОУС-ын дагуух хөрөнгө ба өр төлбөрийн тодорхойлолтонд нийцэхгүй байгаа юм. Учир нь Банкинд ОУВС-аас хөрөнгө татах эрхзүйн үндэс байхгүйд оршино. Харин Сангийн Яам нь Монгол Улсын хэрэгжүүлэгч агентийн хувьд ОУВС-д олгосон өрийн бичигт гарын үсэг зурж, санхүүжилтээрх хөрөнгөнд хариуцлага хүлээнэ. Тиймээс, эдгээр дүн нь санхүүгийн тайланд балансын гадуурх гүйлгээгээр бүртгэгдэнэ. (Тодруулга 27-оос харна уу).
- *Азийн Хөгжлийн Банк (АХБ) ба Германы Засгийн газар (ГЗГ)-аас Сангийн Яаманд олгосон зээл.* Удирдлага Монгол Улсын Засгийн газар (зээлдэгчээр)-ын АХБ ба ГЗГ (зээлдүүдэгчид)-тай хийсэн гэрээний нөхцлийг дахин авч үзсэнээр Банк нь АХБ ба ГЗГ-ийн өмнө аливаа хариуцлага хүлээхгүй боловч Сангийн Яамны өмнө эдгээр зээлтэй холбогдуулан хариуцлага хүлээнэ хэмээн дүгнэсэн байна. Тиймээс 2010 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн “Тадаадын банкинд төлөх өр төлбөр” дансанд тусгагдсан дүн нь “Төрийн байгууллагад төлөх өр төлбөр” хэмээн энэхүү санхүүгийн тайланд тусгагдсан болно. (Тодруулга 17-оос харна уу)
- *Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийн тодорхойлолт.* Удирдлага Мөнгөн Гүйлгээний Тайлангийн зориулалтаар мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийн тодорхойлолтыг дахин хянаж үзсэн ба Банкны үндэсний мөнгөн тэмдэгтийг гаргагчийн үүрэг ролийг мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод оруулж өөрчлөхөөр шийдвэрлэсэн. Иймд, 2010 оны 12 сарын 31-ний тайланд оруулсан зүйлсээс гадна дараах зүйлсийг энэхүү санхүүгийн тайланд нэмж мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсд оруулсан: дотоодын мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн дотоодын банк болон улсын байгууллагуудын хугацаагүй хадгаламж болон зээлжих тусгай эрхийн хадгаламж (Тодруулга 6).

Дахин ангилал. Шаардлагатай тохиолдолд өмнөх үеийн холбогдох дүнгүүдийг тайлант үеийн дүнгүүдийн толилуулгатай нийцүүлэх үүднээс ангилалыг өөрчилдэг. Эдгээр санхүүгийн тайлангуудад дараах ангилалын өөрчлөлтүүд орсон болно:

- *Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал.* 2010 болон түүнээс өмнөх жилүүдийн Дэлгэрэнгүй Орлогын тайланд “Үйл ажиллагааны бусад зардал” нь тусдаа толилууллагдсан байсныг энэхүү тайланд “Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал” болгон нэгтгэн толилуулахаар Удирдлага шийдэв.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Дээрх залруулгууд 2010 оны 12-р сарын 31-нээрх Санхүүгийн Байдлын Тайланд хэрхэн нөлөөлснийг дор толилуулав:

Сая төгрөгөөр	2010.12.31 (өмнөх тайлагнасан дүн)	Залруулга	2010.12.31 (залруулсан)
Хөрөнгө			
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	1,457,584	(360,328)	1,097,256
Сангийн Яамд олгосон Зээл	247,230	(247,230)	-
Өр төлбөр			
Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр	802,966	(19,415)	822,381
Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр	722,207	(626,972)	95,235

Дээрх залруулга болон дахин ангилал нь 2010 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон Дэлгэрэнгүй Орлогын тайланд материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

Дээрх залруулга болон ангилалын өөрчлөлтүүдийн 2010 оны 1-р сарын 1-нээрх Санхүүгийн Байдлын Тайланд үзүүлсэн цэвэр нөлөөг дор толилуулав:

Сая төгрөгөөр	2010.01.01 (өмнөх тайлагнасан дүн)	Залруулга	2010.01.01 (залруулсан)
Хөрөнгө			
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	1,271,630	(337,841)	933,789
Сангийн Яамд олгосон Зээл	262,755	(262,755)	-
Өр төлбөр			
Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр	698,227	24,265	722,492
Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр	737,056	(600,596)	112,195

Санхүүгийн байдлын тайланд хийгдсэн залруулгууд болон ангилалын өөрчлөлтүүд тодруулга 7, 17 ба 19-д нөлөөлсөн бөгөөд санхүүгийн байдлын тайлангийн бусад данс болон холбогдох тодруулгуудад ямар нэгэн нөлөө үзүүлээгүй болно.

Аливаа компани нь санхүүгийн тайлангуудаа залруулсан тохиолдолд санхүүгийн байдлын тайлангийн эхлэлтийн тайланг нэмэлтээр толилуулах шаардлагатайг удирдлага мэдэж байсан боловч санхүүгийн байдлын 2010 оны 1 сарын 1-нээрх гуравдагч мөрийг энэхүү санхүүгийн тайлангуудад толилуулаагүй болно. Энэхүү нь мөн холбогдох тодруулгуудад мөн хамаарна. Удирдлага дээр дурдагдсан залруулгууд болон дахин ангилалуудын тооцооллыг хийх боломжит байдлыг харгалзаж үзсэн ба дэлгэрэнгүй мэдээлэл байхгүйн улмаас санхүүгийн байдлын тайланд гурав дахь баланс буюу 2009 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэлүүдийг тайлагнахгүй байхаар шийдвэрлэсэн. Ийнхүү тайлагнахгүй байх нь материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж Удирдлага үзэж байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн талаарх бүртгэлийн бодлого өөрчилснөөс гадна Удирлага мөнгөн гүйлгээний тайланг тодорхой хэмжээнд сайжруулахаар шийдсэн. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн бодлого, мөнгөн гүйлгээний тайлангийн өөрчлөлт нь 2010 оны 12-р сарын 31-ээрх тайланд дараах нөлөөг үзүүлэв:

Сая төгрөгөөр	2010.12.31 (өмнөх тайлагнасан дүн)	Залруулга	2010.12.31 (залруулсан)
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	27,430	713,528	740,958
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(4,234)	(796,847)	(801,081)
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	126,732	21,128	147,860
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд үзүүлсэн ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл	-	(76,934)	(76,934)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	870,174	(460,144)	410,030
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,020,102	(599,269)	420,833

Санхүүгийн тайлангуудыг нийтэлсний дараа хийгдэх өөрчлөлтүүд. Банкны удирдлага санхүүгийн тайлангуудыг нийтэлсний дараа өөрчлөх эрх мэдэлтэй болно.

3. НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үнэлэлтүүд

Банк нь ирэх жилийн хөрөнгө, өр төлбөр болон санхүүгийн тайлангуудад тайлагнасан дүнгүүдэд нөлөө үзүүлэхүйц тооцоолол, таамаглал хийдэг. Тооцоолол болон үнэлэлтүүд нь үргэлж хянагддаг бөгөөд удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилдаг. Удирдлага нь мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэгжүүлэхдээ тооцооллуудаас гадна тодорхой үнэлэлт хийдэг болно. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилд хөрөнгө болон өр төлбөрийн тайлагнасан дүнгүүдэд мэдэгдэхүйц залруулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлүүд хамаарна:

Сангийн яамнаас авсан зээлийн анх хүлээн зөвшөөрөлт болон дотоодын банкинд олгосон зээлийн анхны бүртгэл. Банк 20,793 сая төгрөг (2010: 19,425 сая төгрөгийн үлдэгдэлэй байсан) -ийн Сангийн яамнаас авсан зээлтэй ба энэхүү хөрөнгийн эх үүсвэр нь Германы Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буюу Сангийн яаманд олгосон бүс нутгийн хөгжлийг дэмжих Азийн Хөгжлийн Банк болон Германы Засгийн газрын санхүүжилт юм. Энэхүү санхүүжилт нь жилийн 0.75% -аас 1% хүртэлх маш бага хүүтэй бөгөөд эдийн засгийн зорилтот салбар эсвэл бусад тодорхой зорилгоор бага хүүтэйгээр олгох нөхцөлтэй болно. Удирдлага ийм төрлийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөхөд олз үүсэх эсэхийг нягталж үзсэн. Энэхүү санхүүжилт нь бүс нутаг болоод нийгмийн хөгжилд зориулагдсан учир энэхүү хөрөнгө нь ямар нэгэн ашиг олох зорилгоор нийтэд олгогдох ёсгүй хэмээн дүгнэжээ. Мөн түүнчлэн, эдгээр байгууллагуудаас Монголын арилжааны банкуудад харьцангуй хүүтэй санхүүжилт олгосон. Тиймээс анх хүлээн зөвшөөрөлтийн олзыг бүртгээгүй болно.

Ийм төрлийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр Банк арилжааны банкуудад харьцангуй бага хүүтэй зээлийг олгох боломжтой болсон. Удирдлага ийм төрлийн хэрэглүүрээс анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз бүртгэх эсэхийг нягталж үзсэн бөгөөд ажил гүйлгээг холбоотой бус талуудтай зах зээлийн хүүгээр хийж байгаа тул гарз бүртгэхгүй байх нь зөв гэж үзсэн. Дээрх дүгнэлтийг хийхдээ удирдлага эдгээр хэрэглүүрүүдийг салангид зах зээлийн сегмент гэж тооцсон.

3. НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үнэлэлтүүд (Үргэлжлэл)

Дотоодын банкуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт. Банк зээлийн багцын үнэ цэнийн бууралтыг үнэлэхээр тогтмол хяналт тавьдаг. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг тогтоохдоо ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахуйц аливаа мэдээлэл байгаа эсэхийг нягталж үздэг. Тодруулга 13-д толилуулсан 2011 оны 12-р сарын 31-ээрх Анод банкинд олгосон 102 сая төгрөгийн (2010: 120 сая төгрөг) зээлийн бодит үнэ цэнэ болон үнэ цэнийн бууралтын санг тогтоох хангалттай зөв, бодитойгоор ирээдүйн мөнгөн урсгалыг тооцоолох боломжгүй байсан нь мэдэгдэхүйц тодорхой бус байдалтай холбоотой. Банкны удирдлага энэхүү зээлийг Монгол Улсын Засгийн Газар төлж барагдуулна гэж үзэж байна. Анод банкинд олгосон зээлийг барагдуулах зорилгоор Сангийн Яам Засгийн газрын бонд гаргах бөгөөд үүнийг Банк хүлээж байна. Засгийн газрын бонд гаргах зөвшөөрлийг УИХ-аас 2012 онд батална гэж хүлээгдэж байгаа боловч бондын хугацаа, нөхцөл нь УИХ баталсны дараа тодорхой болно. Одоогийн байдлаар аливаа урьдчилсан таамаглал байхгүй ба энэхүү авлагын ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын дүн болон цаг хугацаа нь тодорхойгүй байдалд байна.

Эрх хүлээн авагчаар томилогдсон банкуудад тавих хяналт. Банк нь эрх хүлээн авагчаар томилогдсон банкуудад хяналт тавьж байгаа эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайланд нэгтгэгдэх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Банк болон тухайн банкнуудын хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Банк энэхүү үнэлэлтийг хийхдээ дараахийг харгалзан үзсэн:

- Монгол Банк нь хуулийн шаардлагын дагуу эрх хүлээн авагчаар томилогдсон;
- Эрх хүлээн авагч нь зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр сууринаас хандаж банкныг татан буулгах тодорхой зорилготой ба тухайн банкны ямар нэгэн стратегийн шийдвэрийг гаргадаггүй;
- Эрх хүлээн авагч нь хуулиар тодорхойлсон хүрээнд ажиллах ба өр барагдуулах дарааллыг мөн хуулиар тодорхойлсон. Иймд, эрх хүлээн авагч нь Монгол Банкныг хамаарах үр өгөөжөнд нөлөөлөх зорилготой тодорхой шийдвэр гаргах эрхгүй болно;
- Хэдийгээр Монгол Банк нь эдгээр банкуудад зээл олгож болох боловч энэхүү зээлийг хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийг эргүүлэн төлөх баталгааны хуулийн дагуух Засгийн Газрын үүргийг биелүүлэхийн тулд Засгийн Газрын нэрийн өмнөөс олгох болно. Иймд, эдгээр зээлийн авлагын үр өгөөж нь Засгийн Газрын бондын хэлбэртэй байна гэж Удирдлага үзэж байна.

Дээрх зүйлүүд дээр үндэслэн хэдийгээр Монгол Банк нь эрх хүлээн авсан банкнуудын үйл ажиллагааг удирдах эрхтэй боловч эдгээр эрхээ өөрийн үр ашигт нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй ба тэдгээр үр ашиг нь эрх хүлээн авсан банкны гүйцэтгэлээс хамаардаггүй болно. Иймд удирдлага эдгээр банкуудыг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлага байхгүй гэж үзэж байна.

4. Шинэ болон шинэчилсэн стандартуудын хэрэгжүүлэлт

2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Банкны мөрдөж буй шинээр батлагдсан стандартууд ба хэрэглээний тайлбарууд:

Эрх Олголтын Ангилал - НББОУС 32 стандартын нэмэлт өөрчлөлт (2009 оны 10-р сарын 8-ны өдөр батлагдаж, 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилжилж байгаа). Энэхүү нэмэлт өөрчлөлт нь зарим төрлийн хувьцааг гаргаснаас олох орлого нь гадаад валютаар илэрхийлэгдсэн тохиолдолд түүнийг санхүүгийн үүсмэл хэмээн ангилахаас чөлөөлсөн юм. Уг нэмэлт өөрчлөлт нь энэхүү санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлээгүй болно.

НББОУС 24-ын нэмэлт өөрчлөлт, Холбоотой Талын Тодруулга (2009 оны 11 дүгээр сард батлагдаж, 2011 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн мөрдөгдөх). НББОУС 24 нь 2009 онд шинэчилэгдэж, (а) “холбоотой тал” гэсэн тодорхойлолтыг хялбаршуулж, утгыг нь тодруулж, олон янз байдлыг устгасан, (б) тодруулгатай холбоотой шаардлагуудын заримаас нь засгийн газартай холбоотой аж ахуйн нэгжүүдийг чөлөөлсөн. Банк НББОУС-н дагуу “зарим толилуулгаас төрийн байгууллагуудыг чөлөөлөх” эрхээ эдэлсэн.

СТОУС 19 – Өмчийн хэрэглүүр бүхий санхүүгийн өр төлбөрийг хүчингүй болгох (2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилжилж байгаа). Энэхүү СТОУС нь аж ахуйн нэгж зээлсэн зээлийнхээ нөхцлийг дахин хэлэлцэж, өөрийн гаргасан санхүүгийн хэрэглүүрийг зээл олгогч талд шилжүүлэх замаар өр төлбөрөө хүчингүй болгох санхүүгийн бүртгэлийг тодорхойлж өгсөн юм. Олз гарз нь тухайн үеийн өрийн хэмжээгээр бус, хөрөнгийн хэрэглүүрийн үнэ цэнээр Ашиг ба алдагдлын тайланд тусгагдана. ба or loss based on the fair value of the equity instruments compared to the carrying amount of the debt. СТОУС 19 нь энэхүү санхүүгийн тайлангуудад ямар нэгэн нөлөө үзүүлээгүй болно.

СТОУС 14 – Эх үүсвэрийн доод хязгаартай Урьдчилгаа төлбөр (2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилжилж байгаа). Уг СТОУС нь тэтгэвэр, тэтгэмжийн санд эх үүсвэрийн урьдчилгаа төлбөрийг зайлшгүй хийхээр шаардагддаг компаниудад хамаарах тул энэхүү санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлээгүй болно. Энэ нь эх үүсвэрийн доод хязгаартай тэтгэвэрийн санд сайн дураараа хуримтлал үүсгэх үйл ажиллагаанаас гарах хүсээгүй үр дагаварыг арилгаж байгаа юм. It removes an unintended consequence of IFRIC 14 related to voluntary pension prepayments when there is a minimum funding requirement. СТОУС 14 нь энэхүү санхүүгийн тайлангуудад ямар нэгэн нөлөө үзүүлээгүй болно.

СТОУС 7-ын Харьцуулсан Толилуулгаас тодорхой хэмжээгээр чөлөөлөгдөх (анхлан хэрэглэгчдийн хувьд) - СТОУС 1-д гарсан өөрчлөлтүүд (2010 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойшхи тайлант жилүүдэд мөрдөгдөх). 2009 оны 3-р сард СТОУС 7, “Санхүүгийн хэрэглүүрүүд: Тодруулга”-д орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу СТОУС-ын дагуу тайлан бэлтгэгчид (одоогийн) шинэ тодруулгуудад харьцуулах мэдээллийг үзүүлэх журмаас чөлөөлөгдсөн юм. Энэхүү СТОУС 1-д гарсан өөрчлөлт нь анхлан хэрэглэгчдэд СТОУС 7-той адилхан хэлбэрийн шилжилтийн нөхцлийг бүрдүүлж өгчээ. Уг нэмэлт өөрчлөлт нь энэхүү санхүүгийн тайланд онцгой нөлөө үзүүлээгүй болно.

4. Шинэ болон шинэчилсэн стандартуудын хэрэгжүүлэлт (Үргэлжлэл)

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудад хийгдсэн шинэчлэлүүд (2010 оны 5 дугаар сард нийтлэгдсэн бөгөөд 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөнө). Эдгээр шинэчлэлүүд нь дараах стандартууд, хэрэглээний тайлбаруудад орсон агуулгын шинжтэй өөрчлөлт мөн асуудлыг илүү тодорхой ойлгомжтой болгоход чиглэсэн өөрчлөлтүүдээс бүрдэнэ: СТОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд: (i) тухайн нэг үндсэн хөрөнгө эсвэл биет бус хөрөнгийг үнийн зохицуулалт бүхий үйл ажиллагаанд ашиглаж байсан бол өмнөх НББНХЗЗ-аарх дансны үнийг авч уг хөрөнгийн жишиг өртөг болгон ашиглахыг зөвшөөрсөн, (ii) дахин үнэлгээ нь СТОУС-аар гаргасан анхны санхүүгийн тайлангийн хамрах хугацаанд хийгдсэн байсан ч ялгаагүй ямар нэг үйл явдлаас үүдэн хийгдсэн дахин үнэлгээний дүнг үндсэн хөрөнгийн жишиг өртөг болгон ашиглахыг зөвшөөрсөн, мөн (iii) СТОУС 1 дэх хэрэгжүүлэхгүй байхыг зөвшөөрсөн заалтуудын хэрэглээний тухайд СТОУС-аар гаргасан анхны завсар үеийн тайлан ба жилийн эцсийн санхүүгийн тайлан хооронд гарсан аливаа өөрчлөлт, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтүүдийг тайлбарлах шаардлагыг анхны удаа хэрэгжүүлэгчдэд тавьсан; СТОУС 3-ийн нэмэлт өөрчлөлтүүд: (i) эзэмшлийн хувь оролцоог төлөөлөхгүй буюу татан буугдах үед цэвэр хөрөнгөд ногдох өөрийн хувийг эзэмших эрхгүй тэдгээр хяналтын бус оролцоог (өөр хэмжилтийн суурь хэрэглэхийг бусад СТОУС-уудад заагаагүй бол) бодит үнэ цэнээр хэмжихийг шаардсан, (ii) нэгдэж буй компаний хувьцаанд суурилсан төлбөрийн хэлцлүүд нь бизнесийн нэгдлийн үр дүнд солигдоогүй эсвэл сайн дурын үүднээс сольсон аль ч тохиолдолд хэрхэн бүртгэх талаар удирдамж өгсөн, мөн (iii) шинэчлэгдсэн СТОУС 3 (2008 оны 1 дүгээр сард нийтлэгдсэн) -ийг мөрдөж эхлэхээс өмнө хийгдсэн бизнесийн нэгдэлтэй холбоотой худалдан авалтын болзошгүй төлбөрийг СТОУС 3-ийн өмнөх хувилбарт заасан удирдамжийн дагуу бүртгэнэ гэдгийг тодорхой болгосон; СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлтүүд нь зарим нэг нэмэлт тодруулгын шаардлагуудыг тодорхой болгосон, тухайлбал: (i) санхүүгийн эрсдэлийн шинж чанар, хэр хэмжээг тусгасан чанарын ба тоон шинжтэй тодруулга хоорондын уялдаа холбоог онцолсон нэмэлт оруулсан, (ii) нөхцлийг дахин тохиролцоогүй бол хугацаа хэтэрсэн зээлд тооцогдох буюу үнэ цэнийн бууралт хийгдэх байсан санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнийг тодруулах шаардлагыг хассан, (iii) барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийг тодруулах шаардлагыг, барьцаа хөрөнгийн үзүүлэх санхүүгийн нөлөөг тодруулах гэсэн илүү ерөнхий шаардлагаар сольсон, мөн (iv) тайлант хугацааны турш хураагдсан барьцаа хөрөнгөөс олж авсан мөнгөн дүнг бус харин тайлагнах өдрийн байдлаарх хурааж авсан барьцаа хөрөнгийн дүнг тодруулахыг тодорхой болгож өгсөн; НББОУС 1 өмчийн өөрчлөлтийн тайлангийн толилуулга болон агуулгад тавигдах шаардлагыг тодорхой болгон өөрчлөгдсөн; шинэчлэгдсэн НББОУС 27-аар (2008 оны 1 дүгээр сард нэмэлт өөрчлөлт хийгдсэн) НББОУС 21, 28 ба 31 гэсэн стандартуудад оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх зарчмыг илүү тодорхой болгож өгсөн; завсар үеийн хураангуй санхүүгийн тайланд нэмж тодруулах шаардлагатай гол үйл явдал, ажил гүйлгээний нэмэлт жишээг НББОУС 34-д оруулж өгсөн, үүнд бодит үнэ цэнийн шатлалын түвшин хооронд хийсэн шилжилт, санхүүгийн хөрөнгийн ангилалд орсон өөрчлөлт буюу байгууллагын санхүүгийн хэрэглүүрд нөлөөлж буй бизнес, эдийн засгийн орчны өөрчлөлт гэх зэрэг орно; СТОУТХ 13-д урамшууллын бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг хэрхэн хэмжих тухай илүү тодорхой болгосон. Дээр дурьдсан өөрчлөлтүүдтэй холбоотойгоор зарим тодруулгад өөрчлөлт орж, зарим шинэ тодруулга бий болсон боловч эдгээр санхүүгийн тайлангуудын үлдэгдэл болон гүйлгээний хэмжилт болон хүлээн зөвшөөрөлтөд материаллаг нөлөө үзүүлэхгүй.

Дараах зүйлсийн хувьд барьцааны үнэ цэнийг тус тусад нь тодруулах замаар СТОУС 7-гын шинэчлэлээр шаардсан барьцааны санхүүгийн нөлөөг тодруулсан: (i) барьцаа болон зээлийн нөхцлийн бусад сайжруулалт нь бүртгэлийн дүнтэй тэнцүү эсвэл түүнээс илүү санхүүгийн хөрөнгө (“илүү барьцаатай хөрөнгө”), ба (ii) барьцаа болон зээлийн нөхцлийн бусад сайжруулалт нь бүртгэлийн дүнгээс бага санхүүгийн хөрөнгө (“дутуу барьцаатай хөрөнгө”). Энэхүү шинэчлэл нь энэхүү санхүүгийн тайланд нэмэлт тодруулга оруулахад хүргэсэн. Тодруулга 13-г харна уу.

Эдгээр стандартуудыг дээрхээс өөрөөр тайлбарлаагүй бол эдгээр шинэ өөрчлөлтүүд болон тайлбарууд нь Банкны санхүүгийн тайлагналд ямар нэгэн онцгой нөлөө үзүүлээгүй болно.

5. Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд

2012 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн заавал мөрдөх зарим шинэ стандартууд ба тайлбарууд батлагдаж гарсан боловч Банк тэдгээрийг хараахан санхүүгийн тайлагналдаа нэвтрүүлээгүй байгаа болно Үүнд:

СТОУС 9, Санхүүгийн хэрэглүүр: Ангилал ба хэмжилт. 2009 оны 11 дүгээр сард гарсан СТОУС 9 нь НББОУС 39 дахь санхүүгийн хөрөнгийн ангилал ба хэмжилттэй холбоотой хэсгүүдийг орлох болсон. Мөн 2010 оны 10 дугаар сард СТОУС 9-д нэмэлт өөрчлөлт оруулж, санхүүгийн өр төлбөрийн ангилал, хэмжилтийн асуудлыг багтаасан. Уг стандартын гол агуулгаас дурьдвал:

- Санхүүгийн хөрөнгүүдийг хэмжилтийн үүднээс хоёр хэсэгт ангилна: дараагийн тайлант үеүдэд бодит үнэ цэнээр нь хэмжих санхүүгийн хөрөнгүүд ба хорогдуулсан өртгөөр нь хэмжих санхүүгийн хөрөнгүүд. Санхүүгийн хөрөнгүүдийг анх хүлээн зөвшөөрөх үед шийдвэрийг гаргана. Ангилалыг шийдэхэд тухайн байгууллага өөрийн санхүүгийн хэрэглүүрүүдийг удирдахдаа ашигладаг бизнес загвар түүнчлэн гэрээний дүнд тухайн хэрэглүүрийн үүсгэх мөнгөн урсгалын шинж чанараас шалтгаална.
- Дараах хоёр нөхцлийг хангасан өрийн хэрэглүүрийг дараагийн тайлант үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжинэ: (i) байгууллагын бизнес загварын зорилго нь гэрээгээр үүсэх мөнгөн урсгалыг цуглуулахын тулд хөрөнгийг эзэмшихэд оршино, (ii) гэрээний дүнд хөрөнгийн бий болгох мөнгөн урсгал нь зөвхөн зээлийн үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрөөс бүрдэнэ (өөрөөр хэлбэл зөвхөн энгийн зээлд байх шинжүүдийг агуулсан). Бусад бүх өрийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зарлагын дансанд бүртгэнэ.
- Бүх өмчийн хэрэглүүрүүдийг дараагийн тайлант үеүдэд бодит үнэ цэнээр хэмжинэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй өмчийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зарлагын дансанд бүртгэнэ. Бусад бүх өмчийн хэрэглүүрийн хувьд тэдгээрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн хэрэгжээгүй болон хэрэгжсэн олз, гарзыг орлого, зарлагын дансанд бүртгэх бус бусад дэлгэрэнгүй орлого байдлаар хүлээн зөвшөөрөх буцалтгүй сонголтыг хийж болно. Бодит үнэ цэнийн олз, гарзыг дахин ангилж орлого, зарлагын дансанд бүртгэхгүй. Хэрэглүүр тус бүрээр энэ сонголтыг хийнэ. Харин хөрөнгө оруулалтын өгөөжийг төлөөлж байгаа тохиолдолд ногдол ашгийг орлогын тайланд толилуулна.
- НББОУС 39-ийн санхүүгийн өр төлбөрийн ангилал, хэмжилттэй холбоотой ихэнхи шаардлагууд ямар нэг өөрчлөлтгүйгээр СТОУС 9-д орж ирсэн байгаа. Гол өөрчлөлт нь хэрэглүүрийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зарлагын дансанд бүртгэдэг санхүүгийн өр төлбөрүүдийн зээлийн эрсдэлд гарсан өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт толилуулах шаардлага тавигдсан.

СТОУС 9-ийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн заавал мөрдөнө, энэ хугацаанаас өмнө хэрэгжүүлж эхлэхийг мөн зөвшөөрсөн. Банк нь энэхүү стандартын утга агуулга, Банкинд үзүүлэх нөлөө болон стандартыг хэрэгжүүлж эхлэх хугацааг судалж байгаа.

Тодруулга-Санхүүгийн хөрөнгийн шилжүүлэг-СТОУС 7-д орсон өөрчлөлтүүд (2010 оны 10 дугаар сард гарсан бөгөөд 2011 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойшихи тайлант жилүүдэд мөрдлөгө болгоно). Нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгийн шилжүүлгээс үүдэн гарч байгаа эрсдлүүдийн талаар нэмэлт тодруулга хийхийг шаардсан. Энэхүү өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгийг нөгөө этгээдэд шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд бүртгэгдсэн хэвээр үлдсэн тохиолдолд хөрөнгийн үндсэн шинж, үнэ болон санхүүгийн хөрөнгийн эрсдэл болон урамшууллын талаар тодорхой тодруулга хийх талаар тодорхойлсон. Компани санхүүгийн хөрөнгө байхгүй ч гэсэн, аж ахуйн нэгж нь шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой тодорхой эрсдлүүд болон урамшуулалттай тулгардаг бөгөөд, энэхүү эрсдлүүдээс үүсэх нөлөөллийн талаар нэмэлт тодруулга хийх шаардлагатай. Групп болон Компани нь одоогоор санхүүгийн тайлангуудад шинэ стандарт хэрхэн нөлөө үзүүлэх талаар үнэлгээ хийж байна.

5. Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд (Үргэлжлэл)

Мөнгөний ханшны эрс уналт ба Анхлан хэрэглэгчдийг заасан хугацаанаас нь чөлөөлөх тухай – СТОУС 1-д орсон Нэмэлт өөрчлөлт. (2010 оны 12-р сард батлагдсан бөгөөд 2011 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойшхи тайлант жилүүдэд мөрдөгдөх). Мөнгөний ханшны эрс уналттай холбоотойгоор гарсан нэмэлт өөрчлөлт нь хэрэв аж ахуйн нэгж СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэхдээ анх удаагаа энэхүү ханшийн огцом өөрчлөлтийг мэдэрч байгаа бол нэмэлт чөлөөлөлт эдэлнэ. Энэхүү чөлөөлөлт нь аж ахуйн нэгжийг зарим хөрөнгө ба өр төлбөрөө бодит үнэ цэнээр нь үнэлэх боломж олгодог бөгөөд бодит үнэ цэнэ нь СТОУС-ын дагуух санхүүгийн тайлангийн эхлэлийн балансын дүнгээр тодорхойлогдоно.

Хөрөнгийн нөхөн сэргээлт -НББОУС12-д орсон Нэмэлт өөрчлөлт. (2010 оны 12-р сард батлагдсан бөгөөд 2012 оны 1-ээр сарын 1-ний өдрөөс хойшхи тайлант жилүүдэд мөрдөгдөх). Уг нэмэлт өөрчлөлт нь бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн, хөрөнгө оруулалтын зорилгоор олж авсан хөрөнгийг худалдах замаар бүхэлд нь нөхөн сэргээх гэсэн саналыг оруулсан. Мөн НББОУС 12 “Орлогын татвар”-т бодит үнээр тусгагдсан хөрөнгө оруулалтын хөрөнгө нь түүнийг худалдах үед буцаан нөхөгдөх гэсэн урьдчилсан таамаглалыг нэвтрүүлэхээр өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь НББОУС 16-тай төстэй бөгөөд үүнд, үндсэн хөрөнгөнөөс хөрөнгө оруулалтын зориулалттай бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн хөрөнгийг НББОУС 12-ын аргаар хасах талаар заасан байдаг. Банк уг нэмэлт өөрчлөлтийг энэхүү санхүүгийн тайланд материаллаг хэмжээгээр нөлөөлөхгүй хэмээн үзэж байна.

СТОУС 13, Бодит үнэ цэнийн хэмжилт, (2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө), бүх СТОУС-уудад ашиглах боломжтой болгон бодит үнэ цэнийн тодорхойлолтыг өөрчилснөөр, бодит үнэ цэнийн хэмжилт болон тодруулгын шаардлагуудын хүндрэлтэй байдлыг багасгаж зохицлыг нэмэх зорилготой. Энэхүү өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад үзүүлэх нөлөөг Банкны Удирдлага судалж байгаа.

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын сайжруулалт (2010 оны 5 дугаар сард батлагдаж, 2011 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн мөрдөгдөх). Дараах стандартууд болон тайлбаруудад бодит өөрчлөлтүүд, мөн тодруулгууд хийх замаар сайжруулалтыг хийсэн: СТОУС 1 -ийн нэмэлт өөрчлөлтүүд нь (i) үндсэн хөрөнгө эсвэл биет бус хөрөнгө нь үнийн зохицуулалттай үйл ажиллагаанд хэрэглэгдсэн бол өмнөх Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудын үед тооцогдож байсан өртгийг уг үндсэн хөрөнгө эсвэл биет бус хөрөнгүүдийн жишиг өртөг болгон хэрэглэхийг зөвшөөрсөн, (ii) дахин үнэлгээ нь СТОУС –ын дагуух эхний санхүүгийн тайлангуудын тайлант хугацааны үед хийгдсэн байсан ч гэсэн үйл ажиллагаанд суурилсан дахин үнэлгээг үндсэн хөрөнгийн жишиг өртөг гэж хэрэглэхийг зөвшөөрсөн, (iii) нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад гарсан өөрчлөлтүүд эсвэл СТОУС 1 дэх хэрэгжүүлэхгүй байхыг зөвшөөрсөн заалтуудын хэрэглээний тухайд СТОУС-аар гаргасан анхны завсар үеийн тайлан ба жилийн эцсийн санхүүгийн тайлан хооронд гарсан өөрчлөлтүүдийг тайлбарлахыг анхны удаагийн хэрэгжүүлэгчээс шаардсан.

СТОУС 10, нэгтгэсэн Санхүүгийн Тайлангууд (2011 оны 5 дугаар сард сард гаргасан, 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө),НББОУС 27, Нэгтгэсэн ба тусдаа санхүүгийн тайлан болон СТХ-12 “Нэгтгэл – тусгай зориулалттай аж ахуйн нэгж стандартад заасан нэгтгэл болон хяналтын заавруудыг өөрчилсөн. СТОУС 10 хяналтын тодорхойлолтыг өөрчилснөөр бүх аж ахуйн нэгжүүд хяналтыг тодорхойлоход нэгэн ижил тодорхойлолтыг хэрэглэх болсон.

Тодорхойлолтыг өргөн хүрээний хэрэглээний заавраар хангасан. Энэхүү өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайлангуудад материаллаг нөлөө үзүүлэхгүй хэмээн үзэж байна.

СТОУС 11, Хамтарсан хэлцэл, (2011 оны 5 дугаар сард сард гаргасан, 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө), НББОУС 31, “Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо” болон СТХ-13, “Хувь нийлүүлэгчдээс мөнгөн хөрөнгө нийлсэн хамтын хяналттай аж ахуйн нэгжүүд” стандартуудыг сольсон. Тодорхойлолтод өөрчлөлт оруулснаар хамтарсан хэлцлийн төрлийг 2 болгон бууруулсан: хамтарсан үйл ажиллагаа болон хамтарсан үйлдвэр. Хамтран хянадаг байгууллагын пропорционалиар нэгтгэх журмыг халсан. Хамтарсан хэлцэлд оролцогчид бүртгэлийг заавал өмчийн аргаар хөтөлнө. Одоогийн байдлаар эдгээр өөрчлөлтүүдийн Банкны санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг удирдлага үнэлэх шатандаа байна.

5. Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд (Үргэлжлэл)

СТОУС 12, Бусад Аж Ахуйн Нэгжүүд дэх Хувь Оролцооны Тодруулга, (2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө), охин компани, хамтарсан хэлцэл, хараат компани болон нэгтгэгдээгүй бүтцийн байгууллагад хувь оролцоо бүхий компаниудад хамаарна. Энэ стандарт нь НББОУС 28 “Хараат Компани дахь Хөрөнгө Оруулалт” –д заасан тодруулгын шаардлагыг өөрчилсөн. СТОУС 12 аж ахуйн нэгжүүдийг охин, хараат компани, хамтарсан хэлцэл болон нэгтгэгдээгүй бүтцийн байгууллагад оруулсан хувь оролцоотой холбоотой гарах эрсдэл болон санхүүгийн нөлөөг үнэлэхэд тус болох мэдээллээр санхүүгийн тайлан хэрэглэгчдийг хангахаар заасан. Энэ шаардлагыг хангахын тулд шинэ стандартын дагуу компани хянадаг, хамтран хянадаг, өөр байгууллагын шийдвэрт ихээр нөлөөлдөг эсэхийг тодорхойлоход ихээхэн тооцоолол болон таамаглалуудыг ашигладаг. Бүлэг үйл ажилагаа болон мөнгөн гүйлгээн дахь хяналтын бус эрхийн хувь оролцооны дэлгэрүүлсэн тодруулга нь материаллаг хяналтын бус оролцоо бүхий охин компаниудын санхүүгийн мэдээллийг цуглуулж, нэгтгэгдээгүй бүтцийн байгууллагад оруулсан хувь оролцооны тодруулгыг илүү нарийн болгож өгсөн. Банкны Удирдлага одоогийн байдлаар эдгээр өөрчлөлтүүдийн Банкны санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг үнэлэх шатандаа байна.

НББОУС 19 дэх нэмэлт өөрчлөлтүүд, Ажилчдын тэтгэмж (2011 оны 6 дугаар сард гарсан бөгөөд 2013 оны 1 дугаар сарын 1-ний өдрөөс хойшхи тайлант жилүүдэд мөрдлөг болгоно), энэхүү өөрчлөлт нь ажилчдын тэтгэмжийн зардлыг хүлээн зөвшөөрөх, тооцоолох мөн дуусгаварын тэтгэмж, тэдгээрийн тодруулга зэрэгт онцгой өөрчлөлт оруулж байгаа. Стандарт нь цэвэр тодорхойлогдсон өгөх буюу өгсөн тэтгэмжийн өөрчлөлтийг гарах үед нь зөвшөөрөхийг шаардаж байгаа: (i) үйлчилгээний өртөг болон ашиг алдагдал дахь цэвэр сонирхол, (ii) бусад дэлгэрэнгүй орлогын дахин тооцоолол. Групп болон Компани нь одоогийн байдлаар энэхүү стандарт санхүүгийн тайланд ямар өөрчлөлт оруулах эсэхийг судалж байгаа болно.

НББОУС 1 дэх нэмэлт өөрчлөлтүүд, Санхүүгийн тайлангийн толилуулга (2011 оны 6 дугаар сард гарсан бөгөөд 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойшхи тайлант жилүүдэд мөрдлөг болгоно), бусад дэлгэрэнгүй орлогод тусгагдах тодруулгын талаарх өөрчлөлтүүд. Энэхүү өөрчлөлт нь аж ахуйн нэгж ирээдүйд бусад дэлгэрэнгүй орлогод багтсан зүйлсийг ашиг эсхүл алдагдал болж ангилагдах ангилагдахгүйгээс хамааран бусад дэлгэрэнгүй орлогоо хоёр тусдаа хэсэг болгон тайлагнахыг тодорхойлсон. НББОУС 1-ийн санал болгосон нэр нь “ашиг эсхүл алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлагнал” гэдэг нэрээр солигдсон. Групп болон Компани нь санхүүгийн тайлангийн толилуулгад өөрчлөлт хийх хэрэгцээтэй боловч энэ нь гүйлгээ болон тэнцэлд ямарваа нэгэн нөлөө үзүүлэхгүй.

НББОУС 27, Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан, (2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө), хараат компани, хамтарсан компани болон охин компани дангаараа санхүүгийн тайлан бэлтгэж байхад, тэдгээрт оруулсан хөрөнгө оруулалтын бүртгэлийн болон тодруулгын шаардлагуудыг тодорхойлох зорилготой. Нэгтгэсэн санхүүгийн тайлан болон хяналтын талаарх зааврыг СТОУС 10, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан стандартаар орлуулсан. Банкны удирдлага энэхүү өөрчлөгдсөн стандарт өөрийн санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй хэмээн үзэж байгаа.

НББОУС 28, Хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт, (2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө). Зөвлөлийн хамтарсан бизнес-төслөөс шалтгаалан НББОУС 28-д өөрчлөлт орсон. Энэхүү төслийг хэлэлцэхдээ Зөвлөл НББОУС 28-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн аргаар хамтарсан бизнес-төслөө хөтлөхөөр шийдсэн. Учир нь энэ арга нь хамтарсан бизнес ба хамааралтай талуудын харилцаанд зэрэг хамааралтай юм. Банк энэхүү өөрчлөлт нь өөрийн санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй хэмээн үзэж байгаа.

СТОУС 7-д орсон нэмэлт өөрчлөлтүүд- Тодруулга-Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж (2011 оны 12 дугаар сард гарсан бөгөөд 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшхи тайлант жилүүдэд мөрдлөг болгоно). Энэхүү өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж болох эсэх, ингэснээр үүсч болох нөлөөллийг үнэлэхийн тулд санхүүгийн тайланг хэрэглэдэг хүмүүст дэмжлэг болох зорилгоор тодруулга хийх шаардлагатай гэдгийг тодорхойлсон. Өөрчлөлт нь санхүүгийн тайлангийн тодруулгад нөлөөлөх боловч санхүүгийн хэрэгслийн хэмжилт болон түүнийг хүлээн зөвшөөрөлтөд нөлөө үзүүлэхгүй.

5. Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд (Үргэлжлэл)

НББОУС 32-д орсон нэмэлт өөрчлөлтүүд- Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хаах (2011 оны 12 дугаар сард гарсан бөгөөд 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшихи тайлант жилүүдэд мөрдлөг болгоно). Зарим хаах шалгууруудыг хэрэгжүүлэх үед гардаг нийцэмжгүй зүйлүүдийг шийдвэрлэхийн тулд НББОУС 32-д зааварчилгаа нэмж оруулсан. Энэ өөрчлөлт нь “одоогийн байдлаар хооронд нь хаах хуулиар хүлээсэн эрхтэй байна” гэсэн утгыг тодорхой болгож өгөхийн зэрэгцээ зарим нийт тооцооны систем нь цэвэр тооцоотой тэнцүү байж болно гэсэн тодорхойлолтыг мөн тайлбарласан. Групп болон Компани нь өөрчлөлтийг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхээр бол хэзээ хэрэгжүүлж эхлэх мөн санхүүгийн тайланд ямар нөлөө учирч болохыг судалж байна.

IFRIC 20 (Олон Улсын Санхүүгийн Тайлагналыг Тайлбарлах Хороо), “Гадаргуун уурхайн үйлдвэрлэлийн явцад гарсан хөрс хуулалтын зардал” (2011 оны 10-р сард батлагдсан бөгөөд 2013 оны 1-ээр сарын 1-ний өдрөөс хойшихи тайлант жилүүдэд мөрдөгдөх). Энэ нь уурхайн салбар дахь хөрс хуулалтын үйл ажиллагаанаас үүссэн өгөөжийг хэзээ, хэрхэн дансжуулахыг тодорхойлох бөгөөд Банк уг стандартын өөрчлөлт нь санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй хэмээн үзсэн.

Дээр дурдсанаас бусад тохиолдолд, шинэ стандарт болон тайлбарууд нь санхүүгийн тайлангуудад ноцтойгоор нөлөөлөхгүй гэж үзэж байна.

6. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Сая төгрөгөөр	Тодруулга	2011.12.31	2010.12.31	2009.01.01
Бэлэн мөнгө		44,505	14,609	47,749
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө:				
- Гадаад валютаархи богино хугацаат хадгаламж-	7	2,059,287	958,852	749,334
- Хугацаагүй хадгаламж	7	87,290	46,641	73,091
-Зээлжих тусгай эрхийн хадгаламж	7	97,153	90,983	110,379
Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр (ТӨГ)	17	(858,660)	(508,668)	(311,538)
Банкуудын харилцах (ТӨГ)	18	(645,501)	(181,584)	(258,985)
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		784,074	420,833	410,030

Дээрх дүнгүүд нь Мөнгөн Гүйлгэний тайлангийн зорилгоорх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болно.

2011 оны 12 сарын 31-нээрх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд тооцогдох санхүүгийн хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт энд Пүүрс, Мүүдийс болон Фичийн өгсөн зэрэглэлийн хамгийн багаар нь нэгтгэн харуулж болно. Харилцагч байгууллага нь гадаад улсын төв банк, олон улсын санхүүгийн байгууллага (Олон Улсын Төлбөр Тооцооны Банк гэх мэт) бол үнэлгээг тухайн орны зээлжих зэрэглэлийг хэрэглэсэн болно. Гар дээрх бэлэн мөнгө болон ОУВС дэх зээлжих тусгай эрхийн хадгаламж зээлийн эрсдэлд орохгүй.

Сая төгрөгөөр	Хугацаагүй хадгаламж	Богино хугацаат хадгаламж гадаад валютаарх
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй		
- AAA зэрэглэлтэй	37,364	58,720
- AA- с AA+ зэрэглэлтэй	49,926	2,000,567
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд багтсан гадаадын байгууллагад байршуулсан хөрөнгө, Зээлжих Тусгай Эрхийн хадгаламжийг оруулахгүйгээр	87,290	2,059,287

6. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (Үргэлжлэл)

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн балансын үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт ба Пүүрсийн зэрэглэл эсвэл Мүүдийс болон Фичийн зэрэглэл дээр үндэслэн 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх зээлийн эрсдэлийн чанарыг нэгтгэн үзүүлбэл :

Сая төгрөгөөр	Хугацаагүй хадгаламж	Богино хугацаат хадгаламж валютаар илэрхийлэгдсэн
<i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i>		
- AAA рейтингтэй	32,509	-
- AA- с AA+ рейтингтэй	14,132	958,852
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд багтсан гадаадын байгууллагад байршуулсан хөрөнгө, Зээлжих Тусгай Эрхийн хадгаламжийг оруулахгүйгээр	46,641	958,852

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн газарзүйн болон зээлийн эрсдэлийн чанарын шинжилгээ, валютийн ханш, хүү болон дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 28-с үзнэ үү.

7. Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө

Сая төгрөгөөр	2011.12.31	2010 .12.31 (залруулсан)	2009.01.01 (залруулсан)
Богино хугацаат хадгаламж–гадаад валютаарх	2,059,287	958,852	749,334
Хугацаагүй хадгаламж	87,290	46,641	73,091
Хязгаарлагдсан бэлэн мөнгө	590	530	554
Зээлжих тусгай эрхийн хадгаламж	97,153	90,983	110,379
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	256	247	427
Бусад хувь хөрөнгө	4	3	4
Нийт гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	2,244,580	1,097,256	933,789

Залруулгатай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 2-оос харна уу.

Гадаад валютаарх богино хугацаат хадгаламж. Үүнд гадаадын Төв Банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад ам.доллар ба еврогоор 90 хүртэлх хоногийн хугацаатай (2010: 89 хоног), богино хугацаат хадгаламжууд багтана.

Хугацаагүй хадгаламж. Үүнд гадаадын Төв Банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан хүү тооцдоггүй харилцах дансууд багтана.

Хязгаарлагдсан бэлэн мөнгө. Үүнд гуравдагч талын хүсэлтээр Цюрикийн харьяа Шүүхээс хязгаарлалт тогтоосон швейцар франкаарх 397,703: монгол төгрөгөөрх 590 сая (2010: 530 сая төгрөг) төгрөгийн багтана. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 27-аас харна уу.

Зээлжих тусгай эрхийн хадгаламж. Энэ үлдэгдэл нь Банкнаас ОУВС-д оруулсан хувь хөрөнгөтэй холбоотой зээлжих тусгай эрхийн хадгаламжийг илэрхийлнэ. Энэ дүн нь 45.5 сая зээлжих тусгай эрх (2010: 47.2 сая зээлжих тусгай эрх) -ээр илэрхийлэгдсэн ба энэ дүнд хүү тооцдог болно.

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө. Энэ нь Дэлхийн банкны группийн гишүүн болох шаардлагын дагуу Дэлхийн банкинд байршуулсан хадгаламж болон түүнд оруулсан хувь хөрөнгө юм. Энэ дүн нь харгалзах өр төлбөрийн дүнтэй таарч байгаа (Тодруулга 19-аас харна уу) ба хүү тооцдоггүй.

7. Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө (Үргэлжлэл)

Бүх үлдэгдэл дүнгүүд хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй бөгөөд удирдлагын зүгээс энэхүү хөрөнгө нь Эдийн засгийн Хамтын ажиллагаа-Хөгжлийн Байгууллагууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул бүрэн эргэн төлөгдөнө гэж үзэж байна. Эдгээрийн ихэнх нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө бөгөөд олон улсын зэрэглэл тогтоох агентлагын тогтоосон зэрэглэлд үндэслэн зээлийн чанарыг Тодруулга 6-д толилуулсан. Үлдсэн хэсэг нь ОУВС болон Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгүүд болон материаллаг бус хязгаарлагдсан бэлэн мөнгө бөгөөд эдгээр нь зээлийн эрсдэлгүй гэж удирдлага үзэж байна.

Эдгээрийн аль нь ч барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй. Удирдлага энэхүү хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны дүнтэйгээ ойролцоо гэж итгэж байна. Газарзүйн болон зээлийн эрсдэлийн чанарын шинжилгээ, валютын ханш, хүү болон дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 28-с үзнэ үү.

8. Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Өрийн үнэт цаас - борлуулахад бэлэн		
ОУ-ын Төлбөр Тооцооны Банкны Бонд (ам.доллараар)	209,456	1,084,291
Өмчийн үнэт цаас - борлуулахад бэлэн		
Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр	3,084	3,084
Нийт санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн	212,540	1,087,375

Олон Улсын Төлбөр Тооцооны Банкны (ОУТТБ) Бонд нь зах зээлд арилжаалагддаг өрийн үнэт цаас учир бондын зах зээлийн үнэд үндэслэн бодит үнэ цэнээр бүртгэгддэг. Бүх бондууд 3 сар бүхий богино хугацаатай ба хүүгийн түвшин нь жилийн 0.3% байна. Эдгээр үнэт цаасны зээлийн эрсдэл бага бөгөөд ОУТТБ нэр хүнд сайтай учир Банк хөрөнгө оруулалт хийсэн. Мөн түүнчлэн, эдгээр хөрөнгө оруулалтын хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ буураагүйгээс гадна барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй. Дэлгэрэнгүйг Тодруулга 29-өөс харна уу.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй энгийн хувьцаа нь Монголын ипотекийн корпораци, Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банкинд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй зах зээлийн үнэ байхгүйн улмаас эдгээр хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэдэг. Эдгээр хөрөнгө оруулалтуудад зах зээл байхгүй ба Банк эдгээрийг урт хугацаагаар эзэмших төлөвтэй байна. Удирдлага энэхүү хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь бүртгэлээрх дүнгээсээ материаллаг хэмжээгээр зөрөхгүй хэмээн үзэж байна.

Удирдлага боломжит мэдээлэлд үндэслэн 2011 оны 12 сарын 31-ны болон 2010 оны 12 сарын 31 байдлаар хөрөнгө оруулалтанд үнэ цэний бууралт хийх шаардлагагүй гэж үзсэн.

Банкны зээлийн эрсдэлд учруулах хөрөнгө оруулалтын үнэт цаасны зээлийн чанарыг (өрийн үнэт цаас) олон улсын зэрэглэл тогтоогч агентлагуудын зэрэглэлд үндэслэн тогтоосон. ОУТТБ-нд зэрэглэл тогтоодоггүй учир зээлийн эрсдэлийг тухайн орны зээлийн зэрэглэлтэй тэнцүү гэж үзсэн. 2010 болон 2011 оны 12-р сарын 31-ээрх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн –ын зэрэглэлийг Стандарт ба Пүүрсийн рейтинг эсвэл Мүүдийс болон Фичээс тогтоосон хамгийн бага зэрэглэл дээр үндэслэвэл AAA байна.

9. Санхүүгийн хөрөнгө оруулалт - Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших

Сая төгрөгөөр	2011.12.31	2010 .12.31
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн гадаадын бондууд	-	72,702
Нийт санхүүгийн хөрөнгө оруулалт - Дуусгавар хугацаа хүртэл зэмших	-	72,702

2010 оны 12-р сарын 31-ний байдлаар Банк Канадын Роял Банкнаас гаргасан бондонд 44,470 сая төгрөгийн, Нова Скотиа Банкнаас гаргасан бондонд 28,232 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байсан. Эдгээр бүх бонд нь богино хугацаатай байсан бөгөөд бүгд 2011 онд дуусгавар болсон. Тиймээс удирдлага 2010 оны 12-р сарын 31-ний байдлаарх эдгээр бондуудын бодит үнэ цэнэ нь бүртгэлээрх дүнтэйгээ ойролцоо байсан гэж итгэж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 29-с үзнэ үү. Уг бонд барьцаагаар баталгаажуулаагүй.

Эдгээр бондны хугацаа нь хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй бөгөөд 2010 оны 12 сарын 31-ны байдлаар Стандарт ба Пүүрс, Мүүдийс болон Фичийн гаргасан зэрэглэлийн хамгийн багаар тодорхойлбол AAA гэж үнэлэгдсэн.

10. Урвуу буцаан худалдан авах хэлцэл

Сая төгрөгөөр	2011.12.31	2010 .12.31
Урвуу буцаан худалдан авах гэрээ	678,496	491,280
Нийт урвуу буцаан худалдан авах гэрээ	678,496	491,280

Нью-Йоркийн Холбооны Нөөцийн Банкинд байршуулсан хадгаламжаараа Автомат Хөрөнгө оруулалтын Хөтөлбөрт хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу 100,000 ам.доллараас давсан дүн Нью-Йоркийн Холбооны Нөөцийн Банкны буцаан худалдан авах пүүлд ("репо пүүл") хөрөнгө оруулагддаг. 2011 оны 12-р сарын 31-ээрх репо пүүлд оруулсан хөрөнгө оруулалт нь 486.9 сая ам.доллар (678,496 сая төгрөгтэй тэнцэх) байсан. Энэхүү хөрөнгө оруулалт нь нэг сар хүртэлх хугацаатай, жилийн 0.12%-ийн хүүтэй. Холбогдох хөрөнгө оруулалт нь ихэнхдээ барьцаагаар баталгааждаг боловч хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн дагуу үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийснийг тодорхойлоход бэрх. Дэлгэрэнгүйг Тодруулга 28-өөс харна уу.

2010 оны 12 дугаар сарын 31-ний болон 2011 оны 12 сарын 31-ний байдлаарх Урвуу буцаан худалдан авах хэлцлийн зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт ба Пүүрсийн рейтинг эсвэл Мүүдийс болон Фичийн рейтингийн аль багаар үнэлэхэд AA+ байсан ба, хөрөнгө оруулалт нь хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй гэж үзсэн.

11. Алт ба үнэт металл

Сая төгрөг	2011.12.31	2010.12.31
Үнэлгээгээр		
Алт	245,564	115,042
Мөнгө	383	148
Өртгөөр		
Алт болон төмрийн хүдэр	19,289	7,392
Зоос болон соёлын үнэт зүйл	2,849	2,851
Нийт алт болон үнэт метал	268,085	125,433

Банк Английн Банк болон Скотиа Мокатта Банкинд мөнгөжсөн алт байршуулдаг ба бусад үнэт металл (алт, бусад хольц металл болон гулдмай, мөнгөний хүдэр), зоос болон соёлын үнэт зүйлсийг Банкны эрдэнэсийн санд хадгалдаг. Эдгээр зүйлст цэвэршүүлэхээс өмнө алт олборлогчдоос худалдан авсан хадгалагдаж байгаа алт орно. Алтыг цэвэршүүлсний дараа Английн Банк болон Скотиа Мокатта Банк руу шилжүүлдэг.

12. Засгийн газрын үнэт цаас

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Сангийн Яамны үнэт цаас, хорогдуулсан өртгөөр	155,276	53,044
Засгийн газрын нийт үнэт цаас	155,276	53,044

2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк Сангийн Яамнаас гаргасан дараах үнэт цаасыг эзэмшиж байсан:

- 24,182 сая төгрөгийн үлдэгдэлтэй (2010: 21,887 сая төгрөг) Зоос Банктай холботойгоор гаргасан бонд.
- 30,000 сая төгрөгийн үлдэгдэлтэй (2010: 30,000 сая төгрөг) Засгийн газраас төрийн албан хаагчдын орон сууцны санхүүжилтын бонд. 100,000 сая төгрөгийн үлдэгдэлтэй (2010: 0 үлдэгдэлтэй) Засгийн газраас ноолуур болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжих зорилгоор гаргасан бонд.

2010 болон 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх үлдсэн дүн нь хуримтлагдсан хүү болно..

2010 оны 3-р сарын 26-ны өдөр эрх хүлээн авагчаар томилогдсон банкинд (Зоос банк)-д өмнө нь олгосон зээлийг хаахаар Монгол Улсын Сангийн Яам 33 тэр бум төгрөгийн Засгийн газрын бондыг гаргасан. Энэ бонд нь жилийн 0.1%-ийн нэрлэсэн хүүтэй, 4-6 жилийн хугацаатай бол Зоос Банкинд олгогдсон зээл нь жилийн 10%-ийн хүүтэй байсан. 2010 оны 3-р сарын 26-нд бондыг 10%-ийн үр ашигт хүүгийн арга ашиглан бодит үнэ цэнээр нь бүртгэсэн ба хүүгийн хувь тухайн үеийн засгийн газрын бондын хүүтэй ойролцоо байсан. 2011 оны 12 дугаар сарын 31-ний ба 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар, бонд нь хорогдуулсан өртгөөрөө санхүүгийн байдлын тайланд тусгагдсан.

Төрийн албан хаагчдын орон сууцны санхүүжилтэнд зориулан гаргасан Засгийн газрын бонд нь 5 жилийн хугацаатай, жилийн 7.8%-ийн хүүтэй. Энэхүү авлагын эргэн төлөх нь найдвартай учир Банк найдваргүй авлагын санг байгуулах шаардлагагүй гэж үзсэн.

12. Засгийн газрын үнэт цаас (Үргэлжлэл)

Засгийн газраас ноолуур болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжих зорилгоор гаргасан бонд нь дараах нөхцлүүдтэй: 2 жилийн хугацаатай, жилийн 12.25%-ийн хүүтэй. Эдгээр бондууд нь 2011 оны 12 сард гарсан ба энэхүү авлагын эргэн төлөлт нь найдвартай учир Банк найдваргүй авлагын санг байгуулах шаардлагүй гэж үзсэн.

Эдгээр үнэт цаас нь хорогдуулсан өртгөөрөө бүртгэгддэг ба эдгээрийн хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ буураагүй. 2011 оны 12 сарын 31 ба 2010 оны 12- сарын 31-ний байдлаар Стандарт ба Пүүрс, Мүүдийс болон Фичийн гаргасан рейтингийн хамгийн багаар үнэлэхэд ВВ- байсан. Засгийн газрын аль ч үнэт цаас нь барьцаа хөрөнгөөр баталгаажуагүй байна. Эдгээр үнэт цаасны бодит үнэ цэнийг Тодруулга 29-аас харна уу. Холбоотой талуудын ажил гүйлгээтэй холбоотой мэдээллийг Тодруулга 31-ээс харна уу.

13. Дотоодын банкуудад олгосон зээл

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Урвуу репо хэлцэл	223 244	-
Анод Банктай холбоотой зээл	102 000	120 000
Төгрөгийн зээл	11 029	5 389
Валютийн зээл	5 233	5 927
Дотоодын банкуудад олгосон нийт зээл	341 506	131 316
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(925)	(925)
Дотоодын банкуудад олгосон нийт зээл	340 581	130 391

Урвуу буцаан худалдан авах хэлцэл. Урвуу буцаан худалдан авах хэлцэл нь арилжааны банкинд олгосон Төв банкны үнэт цаасаар баталгаажсан богино хугацаатай бөгөөд тогтсон үнээр тогтсон хугацаанд буцаан худалдах нөхцөлтэй (Тодруулга 16-аас харна уу) байдаг. Эдгээр үнэт цаасны дуусгавар хугацаа нь нэг хүртэлх сар бөгөөд жилийн 16.5%-ийн хүүтэй байдаг. Эдгээрийн дүн нь хугацаа хэтрээгүй ба үнэ цэнийн бууралтгүй бөгөөд бүгд 2012 онд төлөгдөж дууссан байна.

Анод Банктай холбоотой зээл. 2008 оны 12-р сарын 12-нд Анод банкны богино хугацаанд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор Банк Анод банкны бүрэн эрхт төлөөлөгчидтэй зээлийн гэрээнд гарын үсэг зурсан. Зээлийн гол зорилго нь харилцагчдын хадгаламжийг “Банкин дах мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулийн дагуу эргэн төлөх байсан бөгөөд дээрх хуулинд хэрэв Монголын арилжааны банк нь дампуурсан тохиолдолд Монгол Улсын засгийн газар нь Монголын арилжааны банкинд байршсан ард иргэдийн харилцах-хадгаламжийн дансны мөнгөнд буцаан төлөгдөх баталгааг өгнө хэмээн заажээ.

Энэхүү зээлийн гэрээнд зээлийн хэмжээ нь 147.9 тэрбум төгрөгийн зээлийн шугам тусгасан ба энэхүү нийт дүнгийн хязгаараас хэтрэхгүйгээр Анод Банк нь хэсэгчлэн зээл авч болно. Хэсэгчилсэн авсан зээл тус бүр нь анх олгогдсон өдрөөсөө 6 сарын дотор буцаан төлөгдөхөөр заасан. Зээлийн хүү нь 7 хоногийн төв банкны үнэт цаасын хүүтэй тэнцүү бөгөөд зээл олгох үед Төв Банкны долоо хоногийн хугацаатай Үнэт цаасны хүү жилийн 9.75%-тай тэнцүү байв. Гэрээний дагуу хүүг 90 хоног бүр хуримтлуулж, Анод Банкны харилцах данснаас шууд хасахаар заасан байна. Анод банкинд олгосон энэхүү зээл нь Анод банкны харилцагчиддаа олгосон 186.3 тэрбум төгрөгийн зээлээр баталгаажсан. Зээлийн анхны олголт нь гэрээнд гарын үсэг зурсан үед буюу 2008 оны 12-р сарын 12-ний өдөр байсан.

13. Дотоодын банкуудад олгосон зээл (Үргэлжлэл)

Энэхүү зээлийг эргэн төлөхөд хүндрэл учирсан тул, 2009 оны 7-р сарын 28-ний өдрийн Гэрээний хавсралтанд заасны дагуу зээлийн хугацааг 6 сараас 12 хүртэлх сар болгон сунгасан. Мөн, 2009 оноос хойш хүүг хуримтлуулахыг зогсоосон ба 2010 ба 2011 онууд дахь зээлийн эргэн төлөлт муу байсан. Тиймээс шинээр ямар ч зээл 2010 ба 2011 онд олгогдоогүй бөгөөд Банк Монгол улсын Засгийн газар болон Сангийн яамтай энэхүү зээлийг нөхөн төлүүлэх талаар тохиролцоо хийсээр байна.

Банкны удирдлагын энэхүү зээлийг Засгийн газар эргэн төлнө гэж үзэж байна. Анод банкинд олгосон зээлийг барагдуулах зорилгоор Сангийн Яам Засгийн газрын бонд гаргах бөгөөд үүнийг Банк хүлээж байна. Засгийн газрын бонд гаргах зөвшөөрлийг УИХ-аас 2012 онд батална гэж хүлээгдэж байна. Хэзээ төлөгдөх нь тодорхойгүй байгаагийн улмаас Удирдлага энэхүү зээлд байгуулсан үнэ цэнийн бууралтын санг 2010 онд буцаасан.

Гадаад валютаар олгосон зээл. Валютаар олгосон зээлийн ихэнхи хувийг дотоодын банкуудад жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон, 4,525 сая төгрөгийн (2010 онд 5,304 сая төгрөг байсан) зээл, арилжааны банкны ажилчидын ур чадварыг дээшлүүлж, банкны системийг сайжруулах зорилготой 657 сая төгрөгийн (2010 онд 621 сая төгрөг байсан) зээл эзэлж байгаа ба үлдсэн нь хуримтлагдсан хүүгийн дүн юм.

Монголд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор дотоодын банкуудад олгосон зээлийн эцсийн хэрэглэгч нь Монголын аж ахуй нэгжүүд бөгөөд Герман Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хоёр салангид санхүүжилтийн хөтөлбөрийн дор хэрэгжиж байна. Энэхүү зээлийн хөтөлбөртэй холбоотой болон Банкны Сангийн яамд төлөх бусад өглөгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 17-аас харна уу. Эдгээр зээл нь дунджаар жилийн 1.25% - 1.75% (2010 онд 1.25% - 1.75% байсан) хүүтэй бөгөөд ямар нэгэн үнэт цаасаар баталгаажуулж байна. Эдгээр зээл нь Германы засгийн газрын шалгуурт нийцсэн дотоодын 3 банкаар дамжин зээлдэгчдэд хүрч байгаа юм. Банкны зээлийн эрсдэл нь зээлдэгчдийн энэхүү зээлийг эргэн төлөхөөс хамааралгүй, учир нь Монгол банк зээлийн төлөх хугацаа болмогц, автоматаар тухайн арилжааны банкны харилцах данснаас хөрөнгө татах чадвартай. Удирдлагын энэхүү зээлтэй холбоотой дүгнэлтийг Тодруулга 3-аас харна уу.

Арилжааны банкны ажилчидын ур чадварыг дээшлүүлж, банкны системийг сайжруулах зорилготой зээл нь Монгол улс ба Азийн Хөгжлийн Банкны хооронд байгуулагдсан гэрээний дагуу “Ди-Эй-Ай” (Тайланд) лимитед компаний “Банкны Сургалтын Төв” дээр банкны ажилтнуудад явуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон зээл бөгөөд эргэн төлөгдөх хугацаа нь 14 жил.

Төгрөгөөр олгосон зээл. Төгрөгөөр олгосон зээлийн ихэнхи хувь нь дотоодын арилжааны банкуудад олгосон зээл бөгөөд хуримтлагдсан хүүгийн хамт нийт 4,667 сая төгрөг (2010: 4,667 сая төгрөг байсан), овернайт зээл нь 5,000 сая төгрөг (2010: тэг), Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ний дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон зээл нь 1,362 сая төгрөг байсан. Үлдсэн дүн нь хуримтлагдсан хүү юм.

Анод банкинд олгосон барьцаат зээлээс дотоодын банкинд олгосон зээлд шилжүүлсэн зээл нь жилийн 12.25%-ийн хүүтэй, 3 жилийн хугацаатайгаар олгогджээ. Уг зээл нь барьцаа хөрөнгөөр баталгаажуулж бөгөөд эргэн төлөлтөд ямарваа хүндрэл учраагүй байна.

2011 оны 12 сарын 31-ний байдлаар уг банк нь дотоодын банктай жилийн 21.25%-ийн хүүтэй 5,000 сая төгрөгний овернайттай байсан.

АХБ-тай холбоотой зээл нь Монголын хэд хэдэн арилжааны банкуудад олгогдсон бөгөөд 2 өөр хөтөлбөрийн дор Дотоодын банкуудад үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ ажлын байрыг бий болгох, мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх зорилгоор олгогдсон. Нэгдүгээр хөтөлбөрийн дагуух зээл нь жилийн 10%-ийн (2009 онд 10%) хүүтэй ба эргэн төлөлтийн хугацаа нь олгогдсон өдрөөсөө хамааран ялгаатай байна. Дараах хөтөлбөрийн дагуух зээл нь жилийн 5.5% (2009 онд 5.5%) –ийн хүүтэй ба 1 жил хүртэлх хугацаанд эргэн төлөгдөх бөгөөд олгогдсон өдрөөсөө хамаараад ялгаатай байна. Германы Засгийн газрын зээлийн нөхцлийн адил Банкны зээлийн эрсдэл нь зээлдэгчдийн зээлээ эргэн төлөлтөөс хамаарахгүй бөгөөд Монгол банк зээлийн төлөх хугацаа болмогц, тухайн арилжааны банкны данснаас хөрөнгө шууд татах эрхтэй. Удирдлагын энэхүү зээлтэй холбоотой дүгнэлтийг Тодруулга 3-аас харна уу.

13. Дотоодын банкуудад олгосон зээл (Үргэлжлэл)

2011 онд зээлийн үнэ цэнийн бууралтын санд өөрчлөлт гараагүй. 2010 оны хэмжээнд зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг дор харуулав:

Сая төгрөгөөр	Урвуу репо хэлцэл	Анод Банктай холбоотой зээл	Төгрөгөөр олгосон зээл	Гадаад валютаар олгосон зээл	Нийт
2010.01.01-ний байдлаарх					
Зээлийн найдваргүй	-	18,300	13,161	-	31,461
авлагын сан					
Хүлээн авсан засгийн					
газрын бондтой холбоотой	-	-	(13,161)	-	(13,161)
(Тодруулга 12)					
Жилийн турших үнэ цэний	-	(18,300)	925	-	(17,375)
бууралтын сан (Тодруулга 25)					
2010.12.31-ний байдлаарх	-	-	925	-	925
найдаргүй авлагын сан					

Зоос банктэй холбоотой зээлийн үнэ цэнийн бууралтын сан зээлийг буцаахад данснаас хассан. Энэхүү зээлийг 2010 онд засгийн газрын үнэт цаасаар төлөгдсөн. Тодруулга 12-ыг харна уу.

2011 оны 12-р сарын 31-ний байдлаарх зээлийн эрсдэлийн шинжилгээг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	Урвуу репо хэлцэл	Анод банктэй холбоотой зээл	Төгрөг-өөр олгосон зээл	Гадаад Валютаар олгосон зээл	Нийт
<i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i>					
<i>ВВ зэрэглэлтэй</i>	200,486	-	5,000	3,711	209,197
<i>В+ зэрэглэлтэй</i>	-	-	5,020	-	5,020
<i>Зэрэглэлгүй</i>	22,758	-	1,009	1,522	25,289
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	223,244	-	11,029	5,233	239,506
<i>Дангаараа үнэ цэнэ нь буурсан зээлүүд</i>					
- 360-аас дээш хоногоор хугацаа нь хэтэрсэн	-	102,000	-	-	102,000
Нийт дангаараа үнэ цэнэ буурсан зээлүүд	-	102,000	-	-	102,000
<i>Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан</i>	-	-	(925)	-	(925)
Нийт дотоодын банкуудад олгосон зээл	223,244	102,000	10,104	5,233	340,581

13. Дотоодын банкуудад олгосон зээл (Үргэлжлэл)

2010 оны 12-р сарын 31-ний байдлаарх зээлийн эрсдэлийн шинжилгээг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	Урвуу репо хэлцэл	Барьцаатайгаар олгосон зээл	Төгрөгөөр олгосон зээл	Валютаар олгосон зээл	Нийт
<i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i>					
BB зэрэглэлтэй	-	-	-	2,885	2,885
B+ зэрэглэлтэй	-	-	4,667	-	4,667
Зэрэглэлгүй	-	-	722	3,042	3,764
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	-	-	5,389	5,927	11,316
<i>Дангаараа үнэ цэнэ буурсан зээлүүд</i>					
- 360-аас дээш хоногоор хугацаа нь хэтэрсэн	-	120,000	-	-	120,000
Нийт дангаараа үнэ цэнэ буурсан зээлүүд	-	120,000	-	-	120,000
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	-	-	(925)	-	(925)
Нийт дотоодын банкуудад олгосон зээл	-	120,000	4,464	5,927	130,391

Тодруулга 28-д дурдсанчлан, Монголын томоохон арилжааны банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог. Дээрх шинжилгээ нь олон улсын үнэлгээний байгууллагад тогтоосон хамгийн бага зэрэглэлд суурилсан болно. Зэрэглэлгүй арилжааны банкуудыг, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, зохистой харьцааны шинжилгээ болон холбогдох зээлийн эрсдэлийг тодорхойлоход хэрэглэдэг бусад олдоцтой мэдээлэлд тулгуурлан санхүүгийн байдалд дүгнэлт гаргадаг.

2011 оны 12-р сарын 31-нээрх барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл:

Сая төгрөгөөр	Урвуу репо хэлцэл	Анод Банктай холбоотой зээл	Төгрөгөөр олгосон зээл	Гадаад Валютаар олгосон зээл	Нийт
Баталгаажгаагүй	-	-	11,029	5,233	16,262
Барьцаа хөрөнгөөр баталгаажсан зээл:					
-Төв банкнаас гаргасан үнэт цаас	223,244	-	-	-	223,244
- Арилжааны зээл	-	102,000	-	-	102,000
Барьцаа хөрөнгөөр баталгаажсан зээл	223,244	102,000	-	-	325,244
Найдваргүй авлагын санг хасаж тооцохоос өмнөх Нийт дүн	223,244	102,000	11,029	5,233	341,506

13. Дотоодын банкуудад олгосон зээл (Үргэлжлэл)

Буцаан худалдах болон буцаан худалдан авах гэрээнд Тодруулга 16-д толилуулсны дагуу холбогдох банкнуудад олгосон төв банкны үнэт цаасаар баталгаажсан зээл багтана. Энэ санхүүгийн хэрэглүүрүүд нь барьцаа өндөртэй гэж тооцогддог. Банкны журмын дагуу 2011 оны 12 сарын 31-нээрх төв банкны үнэт цаасны дансны үнэ нь буцаан худалдах болон буцаан худалдан авах гэрээнд заагдсан дүнтэйгээ ойролцоо байсан. Анод Банктай холбоотой зээлийн барьцаат хөрөнгийн мэдээллийг доор толилуулав.

2010 оны 12-р сарын 31-нээрх барьцаат хөрөнгийн талаарх мэдээлэл:

Сая төгрөгөөр	Урвуу репо хэлцэл	Анод Банктай холбоотой зээл	Төгрөгөөр олгосон зээл	Гадаад Валютаар олгосон зээл	Нийт
Баталгаажуу	-	-	5,389	5,927	11,316
Барьцаа хөрөнгөөр баталгаажсан зээл:					
- Арилжааны зээл	-	120,000	-	-	120,000
	-	120,000	-	-	120,000
Барьцаат зээл					
Нийт үнэ цэнийн бууралтын сангаас өмнөх дотоодын банкуудад олгосон зээл	-	120,000	5,389	5,927	131,316

Анод Банкны бүрэн эрхт төлөөлөгчтэй хийсэн зээлийн зээлийн гэрээнд зааснаар Анод Банкны зээлийн багц энэхүү зээлийн баталгаа болж байгаа бөгөөд дээр дурдсанчлан энэхүү зээлийн эргэн төлөлтийг Засгийн газрын бонд гарган төлөхөөр хүлээгдэж байгаа бөгөөд Улсын Их Хурал бонд гаргах зөвшөөрөл олгоно. Гэхдээ ямар нэгэн албан ёсны гэрээ хийгдээгүй байна. Анод банк одоогоор татан буугдах үе шатандаа байгаа бөгөөд Банкны удирдлага Анод банкны харилцагчдадаа олгосон зээлийн нөхөн төлөгдөх хэмжээг тодорхойлох ба барьцаа хөрөнгийн хэмжээ нь хангалттай эсэх талаарх мэдээллийг гаргах боломжгүй байна.

14. Үндсэн хөрөнгө ба Биет бус хөрөнгө

Сая төгрөгөөр	Барилга байгууламж	Дуусаагүй барилга	Тавилга, компьютер тоног төхөөрөмж	Нийт үндсэн хөрөнгө	Биет бус хөрөнгө	Нийт
2009 оны 12-ын 31-нээрх өртөг	22,734	33	7,231	29,998	66	30,064
Хуримтлагдсан элэгдэл/хорогдол	(2,632)	-	(3,461)	(6,093)	(5)	(6,098)
2009 оны 12-р сарын 31-нээрх дансны үнэ	20,102	33	3,770	23,905	61	23,966
Нэмэгдсэн	1,360	104	1,339	2,803	2,011	4,814
Хасагдсан	(576)	-	(2)	(578)	-	(578)
Акталсан	(2)	-	(229)	(231)	-	(231)
Элэгдэл/хорогдол (Тодруулга 26)	(370)	-	(941)	(1,311)	(1,092)	(2,403)
2010 оны 12-р сарын 31-нээрх дансны үнэ	20,514	137	3,937	24,588	980	25,568
2010 оны 12-ын 31-нээрх өртөг эсвэл үнэлгээ	23,516	137	8,339	31,992	2,077	34,069
Хуримтлагдсан элэгдэл/хорогдол	(3,002)	-	(4,402)	(7,404)	(1,097)	(8,501)
2010 оны 12-р сарын 31-нээрх дансны үнэ	20,514	137	3,937	24,588	980	25,568
Нэмэгдсэн	404	396	987	1,787	179	1,966
Хасагдсан	-	-	(2)	(2)	-	(2)
Акталсан	-	-	(4)	(4)	-	(4)
Элэгдэл/хорогдол (Тодруулга 26)	(384)	-	(986)	(1,370)	(155)	(1,525)
2011 оны 12-р сарын 31-нээрх дансны үнэ	20,534	533	3,932	24,999	1,004	26,003
2011 оны 12-ын 31-нээрх өртөг	23,920	533	9,320	33,773	2,256	36,029
Хуримтлагдсан элэгдэл	(3,386)	-	(5,388)	(8,774)	(1,252)	(10,026)
2011 оны 12-р сарын 31-нээрх дансны үнэ	20,534	533	3,932	24,999	1,004	26,003

14. Үндсэн хөрөнгө ба Биет бус хөрөнгө (Үргэлжлэл)

Монгол улсын мөрдөгдөж буй хуулийн дагуу Төв банк нь 5 жилд нэг удаа барилгаа дахин үнэлэх үүрэгтэй. Хамгийн сүүлд Хөрөнгө Үнэлгээний Төв ХХК-ны хөндлөнгийн үнэлгээчдээр 2008 оны 12 сарын 31-ний байдлаар дахин үнэлгээг хийлгэсэн.

Удирдлага 2010 болон 2011 оны 12-р сарын 31-ны байдлаарх барилгын үлдэх өртөг нь барилгын бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо гэж үзэж байгаа. Одоогийн үлдэгдэл өртөгтэй харцуулбал дундаж үнэ 20%-иар илүү байвал барилгын үлдэх өртөг болон бусад нөөцийн сангийн дахин үнэлгээний нөөцийн 2011 оны 12 сарын 31-ний байдлаар дунджаар 4,106 тэрбум (2010 оны 12 сарын 31-ны байдлаар 4,103 тэрбум)-аар өснө. Одоогийн үлдэх өртөгтэй харцуулбал дундаж үнэ 20%-иар бага байвал барилгын үлдэгдэл өртөг болон банкны дахин үнэлгээний нөөц 2011 оны 12 сарын 31-ний байдлаар дунджаар 4,106 тэрбум (2010 оны 12 сарын 31-ны байдлаар 4,103 тэрбум)-аар өснө. Удирдлага банкны барилгын үнэ цэнийн бууралт нь одоогийн зах зээлийн нөхцөл байдлаас гажууд гэж үзэж байна. Санхүүгийн тайланг ашиглагчдын хувьд барилгын үнэ цэнэ аливаа өсөлт нь санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй.

Дахин үнэлэгдсэн барилга нь түүхэн өртгөөрөө бүртгэгдсэн бол 2011 оны 12-р сарын 31-нээрх Санхүүгийн тайланд энэхүү барилгын дансны үнэ 5,704 сая (2010 онд 5,865 сая) төгрөг байх байсан.

1,666 сая (2010 онд 1,696 сая) төгрөгөөр дансанд бүртгэгдсэн барилга нь Тодруулга 19-д харуулснаар зээлийн баталгаа болон бүртгэгдсэн байна.

15. Бусад хөрөнгө

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Бусад санхүүгийн хөрөнгө		
Аж ахуйн нэгжүүдээс авах авлага	43,946	43,932
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага	12,208	10,985
Сангийн яамнаас авах хуримтлагдсан хүүгийн авлага	3,177	-
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	(56,154)	(54,917)
Бусад санхүүгийн бус хөрөнгө		
Урьдчилж төлсөн зардал	870	2,036
Бусад	2,101	361
Нийт бусад хөрөнгө	6,148	2,397

Аж ахуйн нэгжүүдээс авах авлагад өмнөх жилд Банктай хийсэн алтны опцион хэлцлийнхээ үүргийг биелүүлээгүй алт олборлогч компаниудаас авах 26,769 тэрбум төгрөг (2010 онд 24,240 тэрбум төгрөг)-ийн авлага орж байгаа ба эдгээр авлага найдваргүйд тооцон үнэ цэнийн бууралтын санг бүрэн байгуулсан. Банк үүнээс хойш ямар нэгэн алтны опцион хэлцэл хийгээгүй байна. Мөн 2011 оны 12-р сарын 31-нээрх ба 2010 оны 12-р сарын 31-нээрх Аж ахуйн нэгжүүдээс авах авлагын үлдэгдэл дүнг найдваргүйд тооцсон байна.

Эдгээр үлдэгдлүүд нь Төв банкны тухай хуулийн 23-р зүйлийн “Засгийн газар болон банкнаас бусад хуулийн этгээд, иргэний мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчихөд хүргэсэн. Гэвч банкны удирдлага хууль нийцээгүй үйлдэл нь Банкны үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөөгүйг онцолжээ.

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах заргыг бүхэлд нь найдваргүй авлагад тооцсоны шалтгаан нь тэдгээр байгууллагуудын үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.

Сангийн яамнаас авах авлага нь 2011 онд олгосон зээлийн хүүгийн төлбөр бөгөөд зээл 2011 оны 12-р сарын 31-нээр эргэн төлөгдөж, хуримтлагдсан хүүгийн төлбөр нь 2012 үны 2-р сард бүрэн төлөгдөж дуусчээ. Тиймээс Банк энэхүү авлагыг үнэ цэнэ нь буурсан бус хугацаа хэтэрсэн гэж үзжээ.

Бусад хөрөнгө нь урьдчилж төлсөн төлбөр, ажилтнуудад олгосон урьдчилгаа, бичиг хэргийн болон аж ахуйн материалаас бүрдэж байна.

15. Бусад хөрөнгө (Үргэлжлэл)

2011 ба 2010 оны санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг дор харуулав:

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
1-р сарын 1	54,917	47,369
Гадаад валютаарх сангийн ханшийн хөрвүүлэг	4,773	(33)
Үнэ цэнийн бууралтын сангийн алдагдал (Тодруулга 25)	-	8,028
Үнэ цэнийн бууралтын сангийн буцаалт (Тодруулга 25)	(3,536)	(447)
12-р сарын 31	56,154	54,917

16. Төв Банкны Үнэт Цаас

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Төв Банкны Үнэт Цаас	879,113	1,100,997
Нийт Төв Банкны Үнэт Цаас	879,113	1,100,997

Энэ нь төв банкнаас дотоодын банкуудад гаргасан үнэт цаас юм. Эдгээр үнэт цаасны дуусах хугацаа нь 1 - 24 долоо хоног (2010: 1 - 12 долоо хоног) бөгөөд 2011 оны 12-р сарын 31-нээрх хүүгийн түвшин нь 10.4% -16.25% (2010: 8.5% - 12.9%) байв.

17. Төрийн Байгууллагуудад төлөх Өр Төлбөр

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31 (залруулсан)	2010.01.01 (залруулсан)
Сангийн яамд төлөх зээлийн өр төлбөр			
- Германы Засгийн газар (ГУЗГ)	13,741	12,920	16,446
- Азийн Хөгжлийн Банк (АХБ)	7,055	6,506	7,819
Сангийн яамны харилцах, хадгаламж	1,150,094	802,955	698,227
Төрийн Байгууллагуудад төлөх Нийт Өр Төлбөр	1,170,890	822,381	722,492

Сангийн яамны дансууд. Эдгээр харилцах дансууд нь Банкинд байршуулсан Сангийн яамны харилцах дансууд юм.

Олон улсын байгууллагуудаас авсан Зээллэгтэй холбоотойгоор Сангийн яамд төлөх Өр төлбөр. Эдгээр нь Монгол улсын Засгийн газраас Герман улсын Засгийн газар болон Азийн Хөгжлийн Банктай байгуулсан зээлийн гэрээтэй холбоотой. Энэхүү зээлд Монгол улсын Сангийн яам хэрэгжүүлэгч агентаар, Монгол банк нь энэ төслийг хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

Герман улсын Засгийн газраас авсан зээл нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилготой 1995 он болон 2003 оны хөтөлбөрийн дагуу олгогдсон. Эдгээр зээлүүд нь Еврогоор олгогдсон бөгөөд жилийн 0.75%-ийн хүүтэй, 40 жилийн хугацаатай (2010: жилийн хүү 0.75%). 2012 оноос эхлэн зээлийн үндсэн төлбөр төлөгдөж эхэлнэ.

17. Төрийн Байгууллагуудад төлөх Өр Төлбөр (Үргэлжлэл)

АХБ-аас авсан зээл нь Монголд ядуурлыг бууруулах, хувийн бизнесийн салбарыг хөгжүүлэх, Засгийн газарт болон төрийн бус байгууллагууд, банкуудад зөвлөгөө өгөх, сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгогджээ. Зээлийн гэрээнүүд нь 1994, 1997 онуудад байгуулагдсан ба жилийн хүү нь 1% - 1.5% (2010: жилийн хүү нь 1% - 1.5%), дуусгавар хугацаа нь 30- 40 жил байна.

Сангийн яам нь Монгол улсын Засгийн газрыг төлөөлөн хэрэгжүүлэгч агентийн үүрэг гүйцэтгэдэг учир Банк ГУЗГ болон АХБ-д төлбөр тооцоонд шууд хариуцлага хүлээхгүй. Гэхдээ эдгээр зээлийн төслүүдийг хэрэгжүүлэгчийн хувьд Банк нь зээлийн хөрөнгийг арилжааны банкуудад оновчтой хуваарилах үүрэгтэй бөгөөд тэдгээр арилжааны банкууд нь ГУЗГ болон АХБ-ны шалгуурт тэнцсэн зээлийн эцсийн хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааг хариуцна. Сангийн яам ба Монгол Банкны хоорондын гэрээний дагуу Банк нь Сангийн яамнаас ГУЗГ болон АХБ-ны гэрээний ижил нөхцөлтэйгээр эдгээр зээлүүдийг авсан байна. Банк нь эдгээр зээлийн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж буйн хувьд, ГУЗГ ба Сангийн яамны хоорондын төлбөр тоог зохицуулах үүрэгтэй. Энэхүү зээлийн хөрөнгөөс дотоодын банкуудад олгосон зээлийн талаар Тодруулга 13-д харуулав. Энэхүү Сангийн яамд төлөх өглөг болон дотоодын банкуудад олгосон зээлийн талаарх Банкны удирдлагын дүгнэлтийг Тодруулга 3-аас харна уу.

Холбоотой талуудын ажил гүйлгээ, тэдгээрийн үлдэгдлийг Тодруулга 31-д харуулав.

18. Дотоодын банкны хадгаламж

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Харилцах дансууд:		
- төгрөгөөрх	645,501	181,584
- валютаарх	369,729	459,146
Нийт дотоодын банкны хадгаламж	1,015,230	640,730

Эдгээр дансны дүн нь дотоодын банкуудаас Банкинд арилжааны банкуудын зайлшгүй байлгах нөөц болон бусад төрлийн хадгаламжуудаас бүрдэнэ. Зайлшгүй байлгах нөөцийг банкууд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тодорхой хувиар тооцож тогтооно.

19. Гадаадын Байгууллагуудад төлөх Өр төлбөр

	2011.12.31	2010.12.31 (залруулсан)	2010.01.01 (залруулсан)
Сая төгрөгөөр			
Барьцаатай			
Лондонгийн HSBC-ээс авсан зээл	565	677	977
Барьцаагүй			
Олон Улсын Валютын Сан ("ОУВС"):			
- ОУВС дахь данс No.1	272	272	272
- ОУВС дахь данс No.2	6	6	7
- ЗТЭ-ийн хуваарилалт	104,197	93,927	110,304
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	256	247	427
ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	34	34	34
Дэлхийн банкны харилцах данс	77	72	174
АХБ-ны харилцах данс	5	-	-
Нийт Гадаадын Байгууллагуудад төлөх Өр төлбөр	105,412	95,235	112,195

19. Гадаадын Байгууллагуудад төлөх Өр төлбөр (Үргэлжлэл)

Лондонгийн HSBC-ээс авсан зээл. Энэ нь үндсэн хөрөнгийн худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор Лондонгийн HSBC банкнаас 10 жилийн хугацаатайгаар авсан зээл юм. Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2005 онд эхэлсэн бөгөөд хүүгийн түвшинг HSBC банкны жилийн үндсэн хүүн дээр 1.75%-ийг нэмж тооцдог. Зээлийн барьцаанд Тодруулга 14-д дурьдсан барилгыг тавьсан.

Зээлжих Тусгай Эрхийн Хуваарилалт. ОУВС-ын гишүүн орнуудад ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн ЗТЭ хуваарилсан. Энэ хуваарилалт нь Банкны ОУВС-д өгөх идэвхигүй өр төлбөрийг илэрхийлэх ба үүний оронд ОУВС-аас ЗТЭ-ийн хэлбэрээр хөрөнгө авсан. Тодруулга 7-оос харна уу. Энэ хуваарилалтын цэвэр хуримтлал нь 104,197 сая төгрөг (2010 онд 93,927 сая төгрөг) буюу 48.757 сая ЗТЭ (2010 онд 48.757 сая ЗТЭ) –тэй байна.

Дэлхийн Банк болон Олон Улсын Хөгжлийн Агентлагт Оруулсан Хувь Хөрөнгө. Энэ үлдэгдэл нь Банкнаас Дэлхийн Банк ба Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-т оруулсан хувь хөрөнгө юм.

20. Бусад Өр Төлбөр

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Бусад санхүүгийн өр төлбөр		
Дотоодын банкны дүрмийн санд анх оруулсан хөрөнгийн хэмжээ	3,000	16,700
Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж	4,061	-
Бусад өр төлбөр	6,653	12,258
Бусад Өр төлбөр		
Нийгмийн хөгжлийн сан	8,740	5,581
Аккредитивийн заргатай холбоотой байгуулсан сан	35,618	31,988
Нийт Бусад Өр төлбөр	58,072	66,527

Дотоодын банкны дүрмийн санд анх оруулсан хөрөнгийн хэмжээ нь Монгол Улсын арилжааны банкны дүрмийн санг нэмэгдүүлсэнтэй холбоотой нээсэн тусгайлсан дансууд юм. Эдгээр дансуудыг тухайн арилжааны банкууд хөрөнгө оруулалт хийх гэх мэт зорилгоор хэрэглэхээс бусад тохиолдолд хязгаарлалттай. 2011 оны 12 сарын 31 байдлаарх дүрмийн санд анх оруулсан хөрөнгө нь 2012 оны 1 сард баталсан Хадгаламж банкны дүрмийн сангийн өсөлтийг харуулж байна. 2010 оны 12 сарын 31 нээрх үлдэгдэл нь Монгол Улсын Хөгжлийн Банкны (МУХБ) байгуулахтай холбоотой арилжааны банкуудын байршуулсан дансууд юм.

Банк дотоод журмынхаа дагуу тодорхой хэмжээний хөрөнгийг өөрсдийн ажилчдын ажлын нөхцөл болон амжиргааны нөхцлийг сайжруулах зорилгоор Нийгмийн Хөгжлийн Санд хуваарилдаг. Энэхүү хөрөнгө Банкны ажилчидын тэтгэвэр тэтгэмжийг олгох, Банкны ажилчдад зориулан бариулж буй орон сууцыг санхүүжүүлэх болон хэрэгцээтэй үед нь ажилчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан байна. 2011 оны 12-р сарын 31-нээрх болон 2010 оны 12-р сарын 31-нээрх Нийгмийн Хөгжлийн Санд хуваарилсан хөрөнгийг Удирдлага хангалттай байсан гэж үзсэн. Холбогдох зардлуудыг Тодруулга 26-д харна уу.

Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж нь төрийн байгууллагын Төвлөрсөн Хадгаламжтай холбоотой. Бусад өр төлбөрийн бууралт нь (бусад санхүүгийн өр төлбөр г.м.) 2010 үны 12-р сарын 31-нээрх тоног төхөөрөмжийн худалдан авахад зориулсан хуримтлалтай холбоотой ба 2011 онд төлбөр нь хийгдсэн.

Аккредитивийн заргатай холбоотой байгуулсан сан нь 2008 онд үүссэн шийдэгдээгүй хэрэгтэй холбоотой үүссэн. Удирдлага энэхүү заргаас алдагдал хүлээх магадлалтай гэж тооцсон тул холбогдох төлбөрийн санг 2009 онд байгуулсан юм. 2011 болон 2010 оны туршид гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөнөөс гадна нөөцийн санд өөрчлөлт ороогүй. Дэлгэрэнгүйг Тодруулга 27-оос харна уу. Аккредитивтай холбоотой хэсэг нь тодруулга 27-д дурдсан экспортийн аккредитивийн хэмжээнд багтаж байгаа.

21. Дүрмийн Сан болон Бусад Нөөц

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Дүрмийн Сан	5,000	5,000

Монголбанк нь 100 хувь Төрийн өмчит байгууллага. Дүрмийн сан нь Банкны өөрийн хөрөнгө юм. Монгол Улсын Төв Банк (МонголБанк)-ны тухай хуулийн дагуу цэвэр ашгийн 40%-өөс доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилж, үлдэх хэсгийг (хамгийн ихдээ 60%) Улсын төсөвт шилжүүлдэг. Тиймээс Ерөнхий нөөцийн сан нь хуримтлуулсан цэвэр ашгийн 40%-өөс доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилдаг ба үүнийгээ Банк бүрэн захиран зарцуулах эрхтэй. Энэхүү нөөцийн санд Улсын төсөвт өмнө нь шилжүүлсэн болон ирээдүйд шилжүүлэх дүнг оруулахгүй. Учир нь эдгээр нь тухайн жилдээ Засгийн шазарт шилжчихсэн байдаг.

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Валютын дахин үнэлгээний сан	92,326	(130,443)
Үнэт металлын дахин үнэлгээний сан	20,789	6,458
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан	7,788	7,788
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний сан	42	21
Нийт бусад нөөц	120,945	(116,176)

Банк тухайн жилд учирсан алдагдлыг тооцож үзсэний үндсэн дээр 2010 оны 12-р сарын 31-нээрх ерөнхий нөөцийн санг хуримтлагдсан ашигт шилжүүлэхээр шийдсэн. Бусад нөөцийн өөрчлөлттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Өмчийн Өөрчлөлтийн Тайланд тусгасан. 2011 оны хувьд Бусад нөөцөд ямар нэгэн өөрчлөлт гараагүй бөгөөд энэ тухай Тодруулга 2-оос харна уу.

22. Хүүгийн Орлого ба Зардал

Сая төгрөгөөр	2011	2010
Хүүгийн орлого		
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	6,796	1,910
Дотоодын банкуудад олгосон зээл	5,533	1,150
Засгийн газрын үнэт цаас -хорогдуулсан өртгөөр	4,975	5,194
Санхүүгийн хэрэглүүр - борлуулахад бэлэн	2,152	2,333
Бусад хүүгийн орлого	213	1,164
Нийт хүүгийн орлого	19,669	11,751
Хүүгийн зардал		
Төв Банкны үнэт цаас	114,938	65,679
Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр	3,841	4,199
Бусад хүүгийн зардал	202	831
Нийт хүүгийн зардал	118,981	70,709
Цэвэр хүүгийн зардал	(99,312)	(58,958)

23. Алт ба үнэт металлын арилжааны цэвэр орлого

Сая төгрөгөөр	2011	2010
Алтны арилжааны орлого	22,503	4,286
Алтны дахин үнэлгээний бодит бус ашиг	14,331	6,458
Бусад үнэт металлын арилжаа	6,827	1,528
Тээвэрлэлт ба цэвэршүүлэлтийн зардал	(231)	(83)
Алт ба үнэт металлын арилжааны цэвэр орлого	43,430	12,189

25. Валютын ханшийн зөрүүний ашиг алдагдал

Сая төгрөгөөр	2011	2010
Валютын ханшийн зөрүүний бодит бус ашиг/(алдагдал)	222,769	(183,170)
Валютийн ханшийн зөрүүний бодит ашиг/(алдагдал)	25,243	(15,675)
Валютын арилжаанаас олсон ашиг	4,173	623
Валютын зөрүүний бусад ашиг/(алдагдал)	121	(97)
Валютийн ханшийн зөрүүнээс олсон Ашиг - Алдагдал	252,306	(198,319)

26. Үнэ цэнийн бууралтын сангийн буцаалт

Сая төгрөгөөр	Тодруулга	2011	2010
Бусад хөрөнгө	15	3,536	(7,581)
Дотоодын банкуудад олгосон зээл	13	-	17,375
Найдваргүй авлагаас нөхөн төлөгдсөн нийт дүн		3,536	9,794

26. Удирдлагын ба үйл ажиллагааны бусад зардал

Сая төгрөг	Тод- руулга	2011	2010
Хүний нөөцийн зардал		8,268	4,780
Мөнгөн дэвсгэрт хэвлүүлэх зардал		6,203	3,282
Хуулийн болон мэргэжлийн үйлчилгээний хөлс		3,060	3,376
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл/хорогдол	14	1,525	2,403
Харилцаа холбооны зардал		900	760
Харуул хамгаалалтын зардал		605	489
Гишүүнчлэл болон мэргэжлийн үйлчилгээний зардал		497	390
Тээврийн болон албан томилолтын зардал		384	385
Ашиглалтын зардал		384	347
Сургалтын зардал		339	948
Зар сурталчилгааны зардал		155	280
Гадаад улс дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны зардал		46	231
Акталсан үндсэн хөрөнгө		567	2,655
Үйл ажиллагааны бусад зардал			
Нийт удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал		22,933	20,326

Хүний нөөцийн зардал нь Нийгмийн Хөгжлийн Сангийн 4,000 сая төгрөг (2010: 1,500 сая төгрөг)-ийн зардал, 2011 оны цалин ба урамшууллын 3,581 сая төгрөг (2010: 2,728 сая төгрөг), нийгмийн даатгалын 652 сая төгрөг (2010: 518 сая төгрөг)-ийн зардлуудаас бүрдэнэ. Нийгмийн даатгалын зардалд 415 тэрбумын тэтгэврийн сан (2010 онд 330 тэрбум) орсон.

27. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага

Шийдэгдээгүй хэрэг. Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Банкны эсрэг зарга мэдүүлэх явдал гарч болох юм 2008 оноос хойш Швейцар болон Герман улсуудад үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагатай хийсэн аккредитивийн гэрээтэй холбоотойгоор шүүхэд нэхэмжилж шүүх үйл ажиллагаа нь үргэлжилж байгаа. Гэсэн хэдий ч Банк энэ шүүхэд аккредитын гэрээний дагуух өөрийн хүлээсэн үүргийн хүрээнд байр сууриа баттай хамгаалж байгаа. Үүнтэй холбогдуулан банк 2009 онд бүрэн дүнгээр (хүүг оруулан) нь сан байгуулсан. 2011 оны 12 сарын 31-ний байдлаар уг сан 35,618 сая төгрөг (2010: 31,988 сая төгрөг) байсан. Тодруулга 20-ыг харна уу.

Эдгээр аккредитивтэй холбогдуулан Калифорны өмнөд дүүргийн Америкийн нэгдсэн улс дүүргийн шүүхэд Банк залилан, гэрээний зөрчил, оролцооны дутагдал гэх мэт хууль зөрчсөн үндэслэлээр тодорхой хувь хүн болон байгууллагуудыг шүүхэд дуудан зарга үүсгээд байгаа. Уг хувь хүн болон байгууллага нэхэмжилж буй дүн нь дээр дурдсан банкны төлж болзошгүй өр төлбөрөөс мэдэгдэхүйц хэмжээгээр давж байгаа юм. Хэрэг манайд нааштай шийдэгдэх хандлагатай байгаа хэдий ч хариуцагчдыг авлагаа бүрэн барагдуулна гэсэн хангалттай баталгаа байхгүй байна. Тиймээс Банк санхүүгийн тайландаа авлага хүлээн зөвшөөрөөгүй боловч нэхэмжилсэн төлбөрөө барагдуулахаар тууштай ажиллаж байна.

Удирдлага 2011 оны 12-р сарын 31-ээр дээрх заргуудаас өөр ямар нэгэн материаллаг гарз учруулах нэхэмжлэгчээр дуудагдсан хууль зүйн асуудал байхгүй гэж үзсэн. Тиймээс дээрх аккредитивтэй холбоотой болзошгүй алдагдлын сангаас өөр ямар нэг сан санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

27. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

ОУВС-тай холбоотой үлдэгдлүүд. Банк ОУВС-аас тодорхой хэмжээний хөрөнгийг хүлээн авч, холбогдох дансуудад (Сангийн яамны данс г.м.) байршуулсан хэдий ч ОУВС-гийн хөрөнгийг татан төвлөрүүлэхэд гэрээт хийгээд аливаа үүрэг хүлээгээгүй тул эдгээр хөрөнгө, өр төлбөр нь СТОУС-ын тодорхойлолттой нийцэхгүй байна. Энэ хөрөнгөд ОУВС-д оруулсан хувь хөрөнгө, ОУВС-гийн “Стэндбай” хөтөлбөрийн зээл болон Ядуурлыг бууруулж-Өсөлтийг хурдасгах (ЯБӨХ) хөтөлбөрийн зээл орно. Эдгээр хөрөнгө Банк гэхээсээ илүү Сангийн яам (Засгийн газрын санхүүгийн төлөөлөгчийн хувьд) -ны мэдэлд байдаг тул Сангийн яам энэхүү хөрөнгийг хүлээн авч захиран зарцуулахад баталгаа болгон ОУВС-д өрийн бичиг гарган өгсөн байна.

Банк ба ОУВС-ын хамтын ажиллагаанд дахин нягталсны үр дүнд 2011 онд удирдлага ОУВС-ын хамтын ажиллагаанд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлдээ зарим нэгэн өөрчлөлт оруулан холбогдох дансдыг энэхүү санхүүгийн тайланд балансын гадуур бүртгэсэн. Үүнээс үүдэх санхүүгийн тайлангийн залруулгыг Тодруулга 2-т тусгав.

Сая ЗТЭ	2011.12.31	2010.12.31 (залруулсан)	2010.01.01 (залруулсан)
Монгол улсын Засгийн газрын бусад байгууллагуудаас авах үлдэгдлүүд			
ОУВС-д оруулсан хувь хөрөнгө	50.96	50.96	50.96
Монгол улсын Засгийн газраас ОУВС-д төлбөл зохих үлдэгдлүүд			
ОУВС-гийн үнэт цаасны дансууд:			
-ОУВС-гийн хувь хөрөнгийн төлбөрөөрх	50.96	50.96	50.96
-“Стэндбай” хөтөлбөрийн хөрөнгийг татан төвлөрүүлэхэд	122.64	122.64	122.64
ЯБӨХ-ийн дор хүлээн авсан зээл (үнэт цаасаар биш)	3.26	5.70	8.73
Нийт ОУВС-д төлөх дүн	176.86	179.30	182.33

ОУВС-д оруулсан хувь хөрөнгө. Хувь хөрөнгийн дүн нь Монгол улс ОУВС-гийн гишүүний үүднээс хувь хөрөнгийг нийлүүлснийг илтгэх онцгой төрлийн хөрөнгө юм. Хувь хөрөнгө нь тухайн орны эдийн засгийн цар хүрэнээс хамаараад янз бүр байх учир ОУВС-гийн Гүйцэтгэх Зөвлөлөөс энэхүү хувь хөрөнгийн хэмжээг тогтооно. Квот нь тухайн гишүүн орны Санд өгөх саналын эрх, Сангийн санхүүгийн эх үүсвэрт тавигдах хязгаарлалт болон гишүүдийн ЗТЭ-ийн хуваарилалтын хэмжээг тодорхойлдог. Монгол улсын хувь хөрөнгийн дийлэнх хэсгийг Сангийн яам хүүгүй өрийн бичиг гарган төлсөн ба ОУВС үлдсэн хэсэг нь ОУВС-гийн 1 ба 2-р дансуудад байгаа болно (Тодруулга 19-өөс харна уу). 2011 оны 12-р сарын 31-нээрх ОУВС дахь Монгол улсын хувь хөрөнгийн үлдэгдэл нь 51.1 сая ЗТЭ (2010 онд 51.1 сая ЗТЭ байсан) буюу 109,201 сая төгрөгтэй тэнцэнэ. Энэхүү дүнд хэсэгчлэн төлөх нөхцөлт (tranche) нөөцийн 0.14 сая ЗТЭ (2010 онд 0.14 сая байсан) буюу 300 сая төгрөгийн үлдэгдэл дүн багтсан бөгөөд энэ нь Монгол Банкны хөрөнгө юм. Хувь хөрөнгөд хүү тооцдоггүй. Сангийн яамнаас ОУВС-д оруулсан хувь хөрөнгийг төлөхөөр гаргасан хүүгүй өрийн бичиг нь Сангийн Яамны хөрөнгө ба Монголбанкны балансын гадуур хүлээн зөвшөөрөгдөнө.

ОУВС-аас гаргасан үнэт цаас. 2011 оны 12-р сарын 31-нээрх нийт ОУВС-гийн үнэт цаасны дансны дүн 173.6 сая ЗТЭ (2010: 173.6 сая ЗТЭ байсан) буюу 370,983 сая төгрөгтэй тэнцүү байв (Дэлгэрэнгүйг Тодруулга 2 –оос харна уу).

Энэхүү дүн нь ОУВС-ийн төгрөгөөрх ЗТЭ-ийн хуваарилалтыг илтгэх бөгөөд үүнд, дээр тайлбарласан хувь хөрөнгийг төлөхөд гаргасан өрийн бичиг (2011 оны 12-р сарын 31-нээр 50.96 сая ЗТЭ буюу 108,901 сая төгрөг)болон ЗТЭ-ийн хуваарилалт багтана. Жишээ нь, “Стэндбай” хөтөлбөрийн санхүүжилтийг олж авахад гаргасан өрийн бичиг.

“Стэндбай” хөтөлбөр нь Монгол улсын эдийн засгийг тогтворжуулах зорилгоор ОУВС-ын олгосон жилийн 1% дээр ЗТЭ-ийн түвшинг нэмсэнтэй тэнцэх хэмжээний хүүтэй зээл юм. Уг зээлийг 18 сарын хэлцлээр олгосон бөгөөд хөтөлбөрийн гүйцэтгэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хяналт зэргийг харгалзан үзнэ. Зээл болон түүний эргэн төлөлтийг ЗТЭ-ээр хийдэг. Стэндбай хөтөлбөрөөр баталсан нийт олговол зохих зээлийн хэмжээ 153.3 сая ЗТЭ бөгөөд үүнээс 122.64 сая ЗТЭ (2010: 122.64 сая ЗТЭ) буюу 262,082 сая төгрөгтэй тэнцүү хэмжээний зээлийг 2011 оны 12-р сарын 31-ий өдөр авсан байсан. Хэлэлцээрт 2009 оны 4-р сарын 1-ий өдөр гарын үсэг зурсан ба 2010 оны 10-р сарын 1-ий өдөр хугацаа нь дууссан.

27. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

Ядуурлыг бууруулж Өсөлтийг хурдасгах Хөтөлбөр (“ЯБӨХХ”) -ийн зээл нь ОУВС-аас 10 жилийн хугацаатай, жилийн 0.5%-ийн (2010: 0.5% байсан) хүүтэйгээр Монгол Улсын засгийн газарт олгогдсон. Уг зээлийг 3 жилийн хэлцлээр олгосон бөгөөд хөтөлбөрийн гүйцэтгэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хяналт зэргийг харгалзан үзнэ. Зээлийн эргэн төлөлт ЗТЭ-ээрх хийгдэх ба Сангийн яам Засгийн газрын хэрэгжүүлэгч агентийн хувьд энэхүү зээлд үүрэг хүлээж байгаа. Энэ зээлийн 2011 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл 3.26 сая ЗТЭ буюу 6,967 сая төгрөг байв.

Зээлтэй холбоотой Төлбөрийн Хариуцлага. Банк нь Монгол Улсын засгийн газар эсвэл тэдгээрийн харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол улсын хувьд чухал ач холбогдол бүхий (бараа үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Эдгээр хэрэглүүрүүдийн гол зорилго нь засгийн газар болон холбогдох талуудыг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино.

Аккредитивүүд нь Банкны харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах цуцлагдашгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм. Зээлээс үүдэх төлбөрийн үүрэг хариуцлага нь зээл болон аккредитивын хэмжээнээс ашиглагдаагүй үлдсэн хэсгийг илэрхийлнэ. Банк ийм зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хувьд уг зээлээс ашиглагдаагүй үлдсэн хэмжээгээр алдагдал хүлээх эрсдэлтэй юм. Гэвч ихэнх зээл нь зээлийн эрсдэл багатай харилцагчдад олгогддог тул энэхүү болзошгүй алдагдын хэмжээ нь нийт ашиглагдаагүй байгаа төлбөрийн хариуцлагын хэмжээнээс бага байна.

Зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хэмжээг дор харуулав:

Сая төгрөгөөр	2011.12.31	2010.12.31
Ашиглагдаагүй зээлийн шугам - Хятадын Ардын Банк	554,075	-
Экспортын аккредитивүүд	73,688	66,603
Нийт Зээлтэй холбоотой Төлбөрийн Хариуцлага	627,763	66,603

Банк 2011 оны 5-р сард “Хятадын Ардын Банк (БНХАУ-ын Төв Банк, цаашид “ХАБ” гэх) болон Монголбанк Хятадын юань/Монгол төгрөг солилцох своп хэлцэл”-ийн гэрээнд гарын үсэг зурсан. Энэхүү гэрээ нь хоёр улсын төв банк хоорондын хамтын ажиллагаанд чухал алхам болоод зогсохгүй хоёр улсын банк, санхүү, эдийн засгийн харилцааны цаашдын хөгжлийг түргэтгэх, дэмжихэд гол хөшүүрэг болох юм.

Банк хоорондын гэрээний дагуу ХАБ болон Монголбанк нь юань болон төгрөгийн хөрвөсөн худалдааг цаашид хийж байх учир учир банкууд тус бүрийнхээ мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн, хүү тооцдоггүй тусгай дансыг нээсэн. ХАБ юаний дансыг Монголбанкинд зориулж, Монголбанк төгрөгийн дансыг ХАБ-д зориулан тус тус нээсэн байна.

Төв банкууд энэхүү мөнгөн хөрөнгийг санхүүгийн зах зээлийг тогтворжуулах зорилгоор богино хугацаанд хөрвөх чадварыг хангах, хоёр орны хоорондох худалдааг санхүүжүүлэхэд болон гэрээнд заасан бусад зорилгоор ашиглана. Гэрээнд зааснаар энэхүү хөрөнгийн ашиглах хугацаа нь 3 - 6 сар байна. Хөрөнгө ашиглах зөвшөөрлийг нэг тал нь нөгөөгөөсөө авах ёстой ба тухайн ашиглах хөрөнгийн хэмжээ нь Монголбанкны хувьд гэрээний дүн болох 5 тэрбум юань, ХАБ-ы хувьд 1 их наяд төгрөгөөр хязгаарлагдана. Банк ашиглаж буй хөрөнгийн хэмжээндээ хүү тооцон төлөх ёстой бөгөөд энэ нь гэрээнд заагдсан байна. Монголбанк юань ашигласан тохиолдолд, хүүгийн түвшин нь 200 суурь оноон дээр Шанхай-Интер Банкны Санал болгосон түвшинг (“ШИБОР”) нэмсэнтэй тэнцэх ба ашиглах хугацааны турш тооцно. Харин ХАБ төгрөг ашигласан тохиолдолд, хүүгийн түвшин нь банк хоорондын төгрөгийн жигнэсэн дундаж хүүгийн түвшинтэй тэнцүү байна.

2011 оны 12-р сарын 31-ний байдлаар Монголбанк 2.5 тэрбум юаний анхны худалдан авалт хийсэн бөгөөд үүнтэй дүнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг ХАБ-д худалдсан байна. Ингэснээр ХАБ-н дахь хадгаламжийн хэмжээ өсч цаашид ХАБ-аас зөвшөөрөл авснаар ашиглах эрх үүснэ. 2011 онд энэхүү хөрөнгийг ашиглах талаар ямар нэгэн хүсэлт тавигдаагүй байна. Энэхүү хөрөнгийн харилцан ашиглах гэрээний анхны дүн болох 2.5 тэрбум юань (554,075 сая төгрөг) нь хөрөнгийг ашиглах хүсэлтийн хязгаар болох ба энэ хэмжээ нь 2011 оны 12-р сарын 31-нээрх Банкны зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хэмжээг илтгэнэ.

27. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

2012 оны эхний улиралд Банк нь энэхүү хөрөнгийг ашиглах анхны хүсэлтээ тавьснаас гадна бөгөөд гэрээнд тусгагдсан хөрөнгийн хэмжээ нь мөн өссөн байна. Дэлгэрэнгүйг Тодруулга 33-оос харна уу.

Экспортын аккредитивууд нь ихэвчлэн экспортын хэлцлийн зорилгоор Монгол улсын засгийн газарт олгогддог. Энэхүү тайланд тусгагдсан экспортын аккредитивын дүн нь АНУ, Швейцар болон ХБНГУ-ийн шүүхэд шийдэгдээгүй байгаа заргатай холбоотойгоор үүссэн. Банк эдгээр хууль зүйн болзошгүй төлбөрүүдийн дүнд найдваргүй авлагын санг байгуулсан бөгөөд энэ нь Тодруулга 20-иос харагдана.

Банкны удирдлага 2011 он болон 2010 оны 12-р сарын 31-нээрх аккредитивийн шийдэгдээгүй хэрэгт байгуулсан сангаас бусад аккредитив, зээлийн шугамаарх үүрэг хариуцлагын бодит үнэ цэнийг материаллаг бус хэмээн дүгнэсэн байна. Ашиглагдаагүй байгаа зээлийн шугам болон аккредитивийн гэрээт үлдэгдэл нь ирээдүйн мөнгөний шаардлагыг бий болгохгүй. Учир нь эдгээр санхүүгийн хэрэглүүрүүд нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагддаг.

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Банкны үйл ажиллагаа нь ямагт эрсдэлтэй байдаг тиймээс ч эдгээр эрсдэлийг тогтмол хянаж зөв зохистой бодлого баримтлах нь банкны гол зорилго. Эдгээр эрсдэлийг зохистой удирдах нь Монголын банкны үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж инфляцийг зохистой түвшинд барих зөв мөнгөний бодлого явуулахад чухал шаардлагатай. Эдгээр эрсдэлүүд нь банкны тэргүүний зорилгодоо хүрэх чадварыг хязгаарлах үр дагавартай байж болно. Энэ нь төв банкинд илүүтэй илрэх бөгөөд гадаад валютын ханшийн зөрүүнээс хүлээх санхүүгийн гэнэтийн алдагдал нь үүний нэг жишээ болно. Эдгээр санхүүгийн алдагдал нь бүхий л төрлийн санхүүгийн эрсдлээс хамааралтай үүсдэг.

Банкинд тулгарах эрсдэлүүд нь санхүүгийн (зээлийн, хөрвөх чадварын, зах зээлийн), үйл ажиллагааны, нэр хүндээ хадгалах мөн эрх зүйн эрсдэлүүдээс бүрдэнэ. Одоогийн банкны эрсдэлийн удирдлага нь төвлөрсөн бус бөгөөд газар тус бүр тэдгээрийн үйл ажиллагаанд учирсан аливаа эрсдэлээс сэргийлэх бодлого баримталдаг. Банк нь Монгол улсын төв банк учраас түүний эрсдэлүүд онцгой байдаг ба тэдгээр эрсдэлүүдийг Банкны стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, илрүүлж байдаг. Үүнээс гадна Банк нь эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхитэй хайж байна. Одоогоор Хөрөнгө оруулалтын хороо нь эрсдэлийн стратегийг боловсруулж, шаардлагатай хязгаарыг тогтоох үүрэгтэй байхад Эрсдэлийн Удирдлагын Алба болон Валют эдийн засгийн газар нь үүнтэй холбоотой зарчмууд, үйлчлэх хүрээ, бодлого, хязгаарыг хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн Удирдлагын бүтэц. Захирлуудын зөвлөл нь эрсдэлүүдийг тодорхойлж хянахад эцсийн хариуцлага хүлээнэ. Гэхдээ эрсдэлийг удирдах, хянах үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

Захирлуудын Зөвлөл. Захирлуудын Зөвлөл ерөнхий эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн стратеги, бодлогыг батлахаас гадна эрсдэлтэй холбоотой асуудлаар Банкны ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгчид зөвлөмж өгдөг.

Хяналтын Зөвлөл. Хяналтын зөвлөл нь банкны дотоод бүтэц, зохион байгуулалтад харьяалагддаггүй бөгөөд бие даасан хяналт тавьж, Банкны үйл ажиллагааны эрсдэлийг ерөнхийд нь хянах үүрэгтэй.

Хөрөнгө оруулалтын хороо. Хөрөнгө оруулалтын хороо нь банкны эрсдэлийг удирдах үүрэгтэй хамгийн гол хэсэг бөгөөд Захирлуудын Зөвлөл, ерөнхийлөгчид эрсдэлийн удирдлагын бодлого дээр зөвлөмж өгдөг. Хөрөнгө оруулалтын хорооны бүрэлдэхүүнд Тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, Эрсдэлийн удирдлагын албаны захирал, Валют эдийн засгийн газрын захирал болон Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын захирал багтдаг.

Хөрөнгө оруулалтын хороо нь “Жилийнхээ хөрөнгө оруулалтын бодлого”-ыг баталж, зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Энэхүү зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд үндэслэн Улсын гадаад валютын нөөцийн бүтцийг гарган ерөнхийлөгчид барина. Үүнд гадаад валютын нөөцийн валютын бүтэц, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгө оруулалтын хугацаа, боломжит хэрэглүүр, харилцагч байгууллагад тавьсан хязгаарлалт зэргийг тусгана. Ерөнхийлөгч гадаад валютын нөөцтэй холбоотой лимитийг улирал тутамд батлах бөгөөд энэ нь гадаад валют, зээл, хөрвөх чадвар, хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол арга юм.

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Банкны гадаад валютын нөөцийн эрсдэл нь хамгийн чухал ба үүнийг банкны нийт хөрөнгөд гадаад валютын хөрөнгийн эзлэх хувиар тооцоолно. Тиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон холбогдох газруудын явуулдаг үйл ажиллагаа нь гадаад валютын нөөцтэй холбоотой эрсдэлийг удирдан хяналт тавихад түлхүү чиглэгдэнэ. Хөрөнгө оруулалтын хорооны өөр нэгэн үүрэг бол Эрсдэлийн удирдлагын алба болон бусад холбогдох газруудад хяналт тавих бөгөөд тэдгээр нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн эрсдэл болон хэрэгжилт бодлоготой нийцтэй байгаа эсэхэд ерөнхийлөн анхаарч ажилладаг.

Эрсдэлийн Удирдлагын Алба. Эрсдэлийн Удирдлагын Алба (“ЭУА”) нь гадаад валютын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, бусад эрсдэлтэй холбоотой процедур, хараат бус хяналтын үүрэг гүйцэтгэдэг. Мөн гадаад валютын нөөцийн удирдлага, эрсдэлийн бодлого, лимитүүдийн хэрэгжилтэд хяналт тавьдаг бөгөөд гадаад валютын нөөцийн эрсдэлийн тооцоолол болон танилцуулдаг.

Улсын Гадаад Валютын Улсын Нөөцийн Удирдлагын Журамд зааснаар, нөөцийн удирдлагын зорилго нь Банкны мөнгөний болон гадаад валютын бодлогыг хослуулахад оршино. Гадаад валютын нөөцийн гол зорилго нь:

- *Мөнгөний бодлогыг дэмжих*
- *Зах зээлийн валютын ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах*
- *Засгийн газрын Валютын өр төлбөрт баталгаа гаргах*
- *Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг болон онцгой байдлын үед мөнгөний эх үүсвэр болгон хэрэглэгдэх*

Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бодлоготойгоор удирдах, хянаснаар гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлага дээрх зорилгод дэмжлэг болно. Гадаад эрсдэлийг хянах зорилгоор Банк нь хөрөнгийн сонголт болон хуваарилалтыг хийдэг. Ингэхдээ төлбөр бололцоот хөрвөх чадварыг хангах зорилгоор шаардлагатай гадаад валютын бүтэц, үнэт цаас хөрөнгө, хөрвөх чадварын шаардлагад нийцэх хөрөнгө оруулалтын хэрэглүүрт хязгаарлалт тавих, хүүгийн түвшний эрсдэлийг хязгаарлах зорилгоор хугацаанд параметр тогтоодог.

Валют эдийн засгийн газар. Валют эдийн засгийн газар нь холбогдох тусгай албуудаараа дамжуулан хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Валют эдийн засгийн газрын захирал нь хөрөнгийн бүрдэл, хэрэглүүрүүд, харилцагч талууд, дуусгавар хугацаа, гадаад валютын хөрөнгийн хэмжээ зэрэг хөрөнгийн асуудлуудыг удирдан хянах үүрэгтэй.

Дотоод Аудит. Эрсдэлийн удирдлагын системийн үр бүтээлтэй, шаардлага хангахуйц байдлыг үнэлж дүгнэн шалгах нь банкны дотоод аудитын гол зорилго. Банкны санхүүгийн болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг найдвартай хамгаалан, зүй зохистой хууль журманд нийцэн үйл ажиллагаа явуулахад чиглэсэн банкны баримтлах дүрэм журмуудыг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, хэрэгжүүлэх бүх шатны эрсдэлийн удирдлагын үр бүтээлтэй байдлыг хянах нь дотоод аудитын хэлтсийн гол зорилт билээ. Дотоод аудит нь эрсдэлүүдээ хэмжихдээ ерөнхий ба онцгой түвшинд хуваан авч үздэг. Ерөнхий эрсдэлийн үнэлэлт нь урт хугацааны болон жилийн ерөнхий аудит төлөвлөгөөний дор явагдах ба зорилго нь аудитын нөөцийг эрсдэл бүрийн хэмжээнээс хамааран зохистой хуваарилах бол нарийвчилсан эрсдэлийн үнэлэлт нь ямар нэгэн тулгарсан асуудлыг цааш нь нарийвчлан судлах үед хийгддэг байна.

Банкны дотоод аудит нь 2007-оос 2011 оны урт хугацааны аудитын төлөвлөгөө болон 2011 оны жилийн аудитын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулаад байгаа бөгөөд баримталж байгаа ба гол зорилго нь үйл ажилгааны нэгж бүрт илэрсэн эрсдэлийг үнэлэхийн тулд тэдгээрт шалгуур тавин ажиллаж байна. Үүний тулд тодорхой шалгууруудыг боловсруулж тэдгээрийг жигнэсэн дундаж онооны аргаар эрсдэл учирч болох бүх үйл ажиллагааны нэгжид хуваарилан нийт эрсдэлийн хэмжээг ерөнхийд нь гаргаж, өндөр дунд бага хэмээн ангилна.

Дотоод хяналтын системийг үнэлж дүгнэх нь дотоод аудитын ажлын чухал нэг хэсэг юм. Энэхүү үнэлгээ нь санхүүгийн тайлангийн системийн найдвартай байдал болон холбогдох хууль журмыг даган мөрдөх гэх мэт найдвартай бодлого хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлоход чиглэсэн. Дотоод аудит нь шалгалтын бүх үр дүнг Ерөнхийлөгчид тайлагнах ба Банкны удирдлагын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг түүнд өгсөн үнэлгээ зөвлөмжийг Удирдлагын зөвлөлтэй хэлэлцэн тайлагнадаг юм.

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Зээлийн Эрсдэл. Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулсан хэрэглэгч, үйлчлүүлэгч, гуравдагч талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс үүдэн алдагдал хүлээж болох Банкны нэг төрлийн эрсдэл юм.

Санхүүгийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор гуравдагч талуудтай хийсэн ажил гүйлгээ болон банкны зээл олголтоос үүдэн зээлийн эрсдэл бий болдог. Зээлийн эрсдэлийг удирдахдаа хөрөнгө оруулалт хийх хөрөнгөө зөв сонгох, нэг төрлийн хөрөнгөнд хийх хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаар тогтоох арга замаар удирддаг. Хөрөнгө оруулалтын төрөл, гуравдагч талуудаас хамааралтай үүдэх зээлийн эрсдэлийн түвшний хязгаарыг удирдлагаас ойр ойрхон тогтоож жил тутам тогтмол хяналт тавьдаг.

Банкны санхүүгийн хөрөнгөний зээлжих чанарыг олон улсын үнэлгээний байгууллагаас тогтоосон жишигт тулгуурладаг бол тухайн гадны байгууллагад (жишээлбэл төв банк) тусгайлан тогтоосон үнэлгээ байхгүй тохиолдолд тухайн орны үнэлгээнд тулгуурлана. Банк нь хэрвээ олон улсын зах зээлийн байдал тогтворгүй байвал системийн эрсдэлд орохоос зайлсхийж тухайн байгууллагуудын үнэлгээг үл харгалзан үйл ажиллагаагаа зогсоох шаардлагатай.

Зээлийн эрсдлийг бууруулахын тулд гадаад валютын нөөцийг AAA рейтингтэй Засгийн газар (Төв Банк)-ын болон олон улсын байгууллагуудын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хадгаламж болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд учрах зээлийн эрсдэл нь олон улсын үнэлгээний байгууллагуудаас AA болон түүнээс дээш рейтинг авсан харилцагчидтай ажил гүйлгээ явуулах замаар хязгаарлагдаж байна. Хэрэв харилцагч нь нэгээс дээш үнэлгээний байгууллагаас үнэлгээ (рейтинг) авсан хамгийн бага үнэлгээнд нь үндэслэдэг.

Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд Банк зээлийн эрсдэлээ бууруулахын тулд барьцаа хөрөнгийг түлхүү хэрэглэдэг. Төв Банкны Дахин Санхүүжилтын журамд зааснаар, үндсэн төрлийн барьцаа хөрөнгүүдийг дор дурдав:

1. Төв Банкны үнэт цаас
2. Богино хугацаат засгийн газрын үнэт цаас
3. Монголбанкны хүлээн зөвшөөрсөн, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны гишүүн орнуудын (ОУЭЗХАГО) засгийн газраас гаргасан үнэт цаас
4. Гадаадын томоохон санхүүгийн байгууллагад эзэмшилтэй, AAA рейтингтэй эргэн төлөгдөх чадвар өндөртэй үнэт цаас
5. Монголбанкны хүлээн зөвшөөрсөн санхүүгийн байгууллагуудын өрийн бичгүүд
6. Банкинд болон гадаадын банкинд байршуулсан хугацаат хадгаламжууд.

Банкны тогтоосон зохистой харьцаануудны шалгуурыг бүх зээлдэгч банкууд хангах ёстой. Хэрэв дотоодын зээлдэгч банкууд энэхүү харьцаануудаас нэгийг л биелүүлээгүй тохиолдолд Банк тухайн банкинд олгох буюу олгосон зээлийн үйл ажиллагаагаа цуцалдаг.

Монголын томоохон арилжааны банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог учир дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээн дээр тулгуурлан хянана. Ретинггүй банкуудын хувьд, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, санхүүгийн харьцааны шинжилгээ болон хамааралтай хөрөнгийн зээлийн эрсдэлийг тодорхойлоход хэрэглэдэг Банкны Хяналт шалгалтын газраас гаргаж буй болон бусад олдоцтой мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргадаг. Одоогоор Банк нь өөрийн боловсруулсан зээлийн үнэлгээний системийг арилжааны банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдлийг үнэлэхдээ ашиглаагүй байна.

Цаашилбал, бүх харилцагчдад зээлийн хязгаар байдаг бөгөөд энэ нь тэдний зээлийн үнэлгээ, капитал хөрөнгө болон бусад хүчин зүйлд үндэслэгдэнэ. Хөрөнгө оруулалтын хороо нь зээлийн хязгаарыг улирал бүр тогтоох бөгөөд зээл нь тухайн хязгаартаа байгаа эсэхийг өдөр тутам хянана. Банк өөрийн зээлийн эрсдэлийг хянахын тулд санхүүгийн хөрөнгийнхөө, ялангуяа арилжааны банкуудад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгө (Тодруулга 13 болон 15) -ийнхөө насжилтын шинжилгээг хийдэг байна. Зээлээ эргэн төлөх чадвар нь муудаж буй харилцагчдын талаарх мэдээлэл Захирлуудын Зөвлөлд хүргэгдэх ба тэд үүнийг хэлэлцэн үзэж шаардлагатай шийдвэрийг гаргана.

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Тодруулга 27-д дурьдсанчлан Банк нь тодорхой хэмжээний зээлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд Банк нь Монгол Улсын Засгийн Газар эсвэл тэдгээрийн харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол улсын хууд чухал ач холбогдол бүхий (бараа үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Энэхүү хэрэгслийн гол зорилго нь Засгийн газарт болон бусад төрийн байгууллагуудад санхүүжилтийн хөрөнгийг хангалттай байлгахад оршино. Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах цуцлагдашгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм. Гэхдээ энэ төрлийн эрсдэл нь зээлтэй ижил аргаар хязгаарлагдаж болно. Зээлтэй холбоотой үүрэг нь Хятадын Ардын банкттай хийсэн гэрээтэй холбоотой ба ашиглаагүй хэмжээгээр эрсдэл тодорхойлогдоно (Тодруулга 27-аас харна уу). Хийсэн шинжилгээндээ үндэслэн Банкны удирдлага Банкны энэ төрлийн харилцагчаас үүдэлтэй зээлийн эрсдэлд орох магадлал нь бага хэмээн дүгнэжээ.

Банкны зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн санхүүгийн хөрөнгийн бүртгэлээрх дүнд нөлөөлдөг. Зээлийн эрсдэл нь Тодруулга 10 болон 13-д харуулсны дагуу барьцаа хөрөнгөөр багасч болно. Аккредитивууд болон зээлийн хэмжээг нэмэх хүсэлтээс үүдэх үүргийн хувьд зээлийн эрсдэлд хамгийн ихээр өртөх магадлал нь энэхүү үүрэг хариуцлагын дүнгээр илэрхийлэгдэнэ. (Тодруулга 27-г харна уу).

Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийн одоогийн бодит үнэ цэнэ эсвэл тэдгээрээс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын дүн нь зах зээл дээрхи хувьсах хүчин зүйлс болох хүү болон валютын ханшийн зөрүүнээс шалтгаалан хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн болон эргэн төлөгдөх чадварын эрсдэлийг тодорхойлохдоо удирдлагын гол анхаардаг зүйлийн нэг нь гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр болон импортын бүтцэд завсар зааг тогтоох явдал юм. Банк энэхүү эрсдэлийг мэдрэмжийн шинжилгээгээр судлан хянадаг. Валютын төвлөрөл дэх эрсдэлийг үл тооцвол Банкинд зах зээлтэй холбоотой өөр онцгой эрсдэл байхгүй байна. Одоогоор Банк нь үнийн бусад эрсдэлд онцгой байдлаар өртөөгүй болно.

Ханшийн эрсдэл. Ханшийн эрсдэл нь санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнэ нь валютын солилцооны ханшийн хэлбэлзлээс үүдэн өөрчлөгдөж байх эрсдэлийг хэлнэ.

Ханшийн эрсдэлийг гадаад валютын багцыг төрөлжүүлэх замаар удирдаж болох ба дараах хэмжүүрээр тодорхойлогдоно:

- Удирдлагын шийдвэрт онцгой чухал валютууд;
- Гадаад валютын нөөцийн зорилгоор валютаар илэхийлэгдсэн хамааралтай хөрөнгүүд дэх удирдаж болохуйц валютын хамгийн их хувь хэмжээ болон богино ба урт хугацааны хөрөнгө оруулалтын багц.

Гадаад валютын нөөцөд тавигдах хязгаар нь Хөрөнгө оруулалтын Зөвлөлийн шийдвэрийн дагуу Банкны Ерөнхийлөгчөөр хүлээн зөвшөөрөгдөх ёстой. Энэхүү шийдвэр нь “Жилийн Хөрөнгө Оруулалтын Бодлого”-д үндэслэгдэх ба энэ нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

Зөвлөл ханшийн хэлбэлзэлд хязгаарын түвшин тогтоодог ба энэхүү түвшин нь уг хязгаартай байж чадаж буй эсэхийг тогтоох үүднээс өдөр бүр хянагдаж байдаг. Эрсдэлд-өртөж буй-Дүн (ЭӨД)-гийн арга ханшийн эрсдэлийг тогтооход хэрэглэгддэг. Эрсдэлийн удирдлагын алба (ЭУА) нь ЭӨД-ийн 99%-и-г түвшинд 10 өдрийн хугацаагаар өдөр тутам тодорхойлж үүнийгээ удирдлагад мэдээлдэг байна. Үүнээс гадна мэдрэмжийн шинжилгээг хэрэглэдэг.

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Доорх хүснэгт нь 2011 оны болон 2010 оны 12-р сарын 31-нээрх ханшийн эрсдэлд мэдэгдэхүйц өртөж буй Банкны санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг валютаар илэрхийлэн харуулж байна.

Сая төгрөгөөр	Санхүүгийн хөрөнгө	Санхүүгийн өр төлбөр	Балансын цэвэр дүн
2011			
Ам.доллар	2,504,922	(556,915)	1,948,007
Монгол төгрөг	493,691	(3,116,908)	(2,623,217)
Евро	507,486	(104,728)	402,758
ЗТЭ	97,153	(111,530)	(14,377)
Бусад	72,559	(7,629)	64,930
Нийт	3,675,811	(3,897,710)	(221,899)
2010			
Ам.доллар	2,223,740	(690,663)	1,533,077
Монгол төгрөг	177,473	(2,339,887)	(2,162,414)
Евро	388,736	(70,969)	317,767
ЗТЭ	90,983	(100,711)	(9,728)
Бусад	62,391	(5,763)	56,628
Нийт	2,943,323	(3,207,993)	(264,670)

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцсээрх гадаад валютын болон ЗТЭ-ын ханшийн харьцангуй боломжит өөрчлөлтөд ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгийн үзүүлэх мэдрэмжийг харуулсан. Хүснэгтэн дэх сөрөг утгатай дүнгүүд нь ашиг ба алдагдал дахь болзошгүй цэвэр хасагдуулгыг илэрхийлэх ба эерэг утгатай дүнгүүд нь боломжит өсөлтийг илэрхийлнэ. Үүнд бүх хувьсагчид тогтмол:

Сая төгрөгөөр	2011.12.31-нээрх Ашиг/алдагдал дахь нөлөө	2010.12.31-нээрх Ашиг/алдагдал дахь нөлөө
Ам.доллар 20%-аар чангарахад	389,601	306,615
Ам.доллар 20%-аар сулрахад	(389,601)	(306,615)
Евро 20%-аар чангарахад	80,552	63,553
Евро 20%-аар сулрахад	(80,552)	(63,553)
ЗТЭ 20%-аар чангарахад	(2,875)	(1,946)
ЗТЭ 20%-аар сулрахад	2,875	1,946
Бусад валют 20%-аар чангарахад	12,986	11,326
Бусад валют 20%-аар сулрахад	(12,986)	(11,326)

Эрсдэлийн нөлөөний хэмжээ нь Монголбанкны үндсэн үйл ажиллагааны мөнгөн нэгж (төгрөг) болон ЗТЭ-д хамаарагдах мөнгөн нэгжээс бусад валютийн хувьд тооцоологдсон болно.

Хүүгийн түвшний эрсдэл. Хүүгийн түвшний эрсдэл нь санхүүгийн хэрэглүүрүүдийн одоогийн бодит үнэ цэнэд эсвэл түүнээс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалд хүүгийн түвшин нөлөөлсөнөөр бий болж буй хэлбэлзлийн эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдэлийг удирдахад тулгарах гол зүйл нь хөрөнгө оруулалт тус бүрийн тохиролцоонд заагдсан эрсдлийн хэмжээнээс хэтрэлгүйгээр хөрөнгө оруулалтаас тогтвортой үр ашиг хүртэх явдал юм.

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Банкны хөрөнгө болон өр төлбөрийн ихэнх хувь нь тогтмол хүүгээр үнэлэгддэг. Энэ тогтмол хүү нь хүүгийн эрсдлийг ихээхэн хэмжээгээр бууруулдаг. Стратегийн харьцуулсан үзүүлэлтийг тодорхойлох явцдаа, хүүгийн түвшингийн эрсдэлийг багасгах зорилгоор Банк гадаад валютын нөөцийн багцдаа хугацааг нь зааж өгдөг. Энэхүү хугацааны хэрэгжилтийг өдөр бүр хянадаг.

Хөрөнгө оруулалтын хугацаа нь хөндлөн шинжилгээний (investment horizon) аргаар тодорхойлогдоно. Хөрөнгө оруулалтын хугацааг 1 жилээр, хамгийн бага үр өгөөжийн түвшинг сөрөг үр өгөөжөөр (1 жилийн хугацаанд үр өгөөжийн өөрчлөлт сөрөг бол), сөрөг үр өгөөжийн хүлээн зөвшөөрөх боломж 5%-аас ихгүй байхаар өөрийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, ирээдүйн өгөөжийг таамаглах аргаар зохистой хугацааг тооцдог.

Дараахь хүснэгтэд банкны хүүгийн түвшний эрсдэлд орохуйц байдлыг харуулжээ. Энэ хүснэгтэд банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дансны үлдэгдэл дүнгээр, мөн гэрээнд заасан хүүгийн түвшин өөрчлөгдсөн буюу зээлийн хугацаа дуусгавар болсон өдрүүдийн аль түрүүнд болсноор ангилан үзүүлсэн байна.

Сая төгрөгөөр	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сарын	6-12 сарын	12 сараас дээш	Нийт хүү тооцдог	Хүү тооцдоггүй	Нийт
2011.12.31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	1,119,330	2,043,754	1,114	266,387	3,430,585	248,570	3,679,155
Нийт санхүүгийн өр төлбөр	(582,302)	(259,826)	(36,953)	(27,511)	(906,592)	(2,991,118)	(3,897,710)
2011.12.31-нээрх хүүгийн өөрчлөлтөнд нээлттэй цэвэр позиц	537,028	1,783,928	(35,839)	238,876	2,523,993	(2,742,548)	(218,555)
2010.12.31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	1,651,357	951,142	-	183,435	2,785,934	160,723	2,946,657
Нийт санхүүгийн өр төлбөр	(336,498)	(656,496)	(321,603)	(19,426)	(1,334,023)	(1,873,970)	(3,207,993)
2010.12.31-нээрх хүүгийн өөрчлөлтөнд нээлттэй цэвэр позиц	1,314,859	294,646	(321,603)	164,009	1,451,911	(1,713,247)	(261,336)

Банкны удирдлага ЗТЭ-ийн хадгаламж (Тодруулга 7), ЗТЭ-ийн хуваарилалт болон HSBC Банкнаас авсан зээл (Тодруулга 19) – ээс бусад хүү төлөгддөг хөрөнгө болон өр төлбөрийн хүү нь тогтмол хүүтэй учир Банкны хүүгийн эрсдэлд орох магадлалыг их гэж үзэхгүй байна. Тиймээс 2011 болон 2010 оны санхүүгийн үзүүлэлтүүд нь хүүгийн түвшингийн нөлөө багатай бөгөөд хүүгийн хэлбэлзэл нөлөөлсөн хувьсах хүүтэй хөрөнгө болон өр төлбөрийн зөрүүнээс үүдэх хүүгийн мэдрэмжийн зөрүү нь мөн их биш гэж үзжээ.

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Банк өөрийн санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн хувийг хянаж байдаг. Доорх хүснэгтэд удирдлагын шийдвэр гаргахад хэрэглэдэг тайлангууд дээр үндэслэсэн тухайн тайлант хугацааны хүүгийн түвшинг нэгтгэн харуулсан. Үнэт цаасны хувьд хүүгийн түвшин нь тайлант хугацааны зах зээлийн ханшин дээр үндэслэсэн дуусвар хугацаа хүртэлх хүүгийн түвшинг илтгэнэ:

Жилийн %	2011				2010			
	ТӨГ	АМ.ДОЛЛАР	ЕВРО	Бусад	ТӨГ	АМ.ДОЛЛАР	ЕВРО	Бусад
Хөрөнгө								
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	-	0.16%	0.33%	0.56%	-	0.28%	0.62%	0.46%
Хөрөнгө оруулалт -борлуулахад бэлэн	-	0.28%	-	-	-	0.18%	0.57%	-
Хөрөнгө оруулалт -дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших	-	-	-	-	-	0.18%	-	-
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	-	0.12%	-	-	-	0.29%	-	-
Засгийн газрын үнэт цаас	8.97%	-	-	-	3.77%	-	-	-
Дотоодын банкуудад олгосон зээл	16.20%	5.50%	1.25%	-	10.30%	5.50%	1.25%	-
Өр төлбөр								
Төв банкныүнэт цаас	12.25%	-	-	-	11.00%	-	-	-
Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр	-	3.00%	0.75%	1.28%	-	3.00%	0.75%	1.28%
Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр	-	-	-	1.35%	-	-	-	1.35%

Хэрэв дээрх хүснэгтэд валют нь “-” тэмдгээр тэмдэглэгдсэн бол тухайн валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр Банкинд байхгүй гэдгийг илтгэнэ.

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Бүс нутгийн төвлөрлийн эрсдэл. 2011 оны 12-р сарын 31-ний байдлаарх Банкны хөрөнгө болон өр төлбөрийг газарзүйн байршлаар нь дор харуулав:

Сая төгрөгөөр	Монгол	ЭЗХАХБ	ОУВС	ЭЗХАХБ бус	Нийт
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	44,505	-	-	-	44,505
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	-	2,147,427	97,153	-	2,244,580
Хөрөнгө оруулалт -борлуулахад бэлэн	490	209,456	-	2,594	212,540
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	-	678,496	-	-	678,496
Засгийн газрын үнэт цаас	155,276	-	-	-	155,276
Дотоодын банкуудад олгосон зээл	340,581	-	-	-	340,581
Бусад санхүүгийн хөрөнгө	3,177	-	-	-	3,177
Нийт санхүүгийн хөрөнгө	544,029	3,035,379	97,153	2,594	3,679,155
Өр төлбөр					
Гүйлгээн дэх бэлэн мөнгө	713,351	-	-	-	713,351
Төв банкнаас гаргасан үнэт цаас	879,113	-	-	-	879,113
Төрийн байгууллагуудаас байршуулсан хөрөнгө	1,170,890	-	-	-	1,170,890
Дотоодын банкнуудаас байршуулсан хөрөнгө	1,015,230	-	-	-	1,015,230
Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр	-	1,218	104,194	-	105,412
Бусад санхүүгийн өр төлбөр	13,714	-	-	-	13,714
Нийт санхүүгийн өх төлбөр	3,792,298	1,218	104,194	-	3,897,710
2011.12.31-нээрсн Балансын цэвэр дүн	(3,248,269)	3,034,161	(7,041)	2,594	(218,555)
Зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлага (Тодруулга 27)	73,688	-	-	554,075	627,763

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

2010 оны 12-р сарын 31-ний байдлаарх Банкны хөрөнгө болон өр төлбөрийг газарзүйн байршлаар нь дор харуулав:

Сая төгрөгөөр	Монгол	ЭЗХАХБ	ОУВС	ЭЗХАХБ бус	Нийт
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	14,609	-	-	-	14,609
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	-	1,006,273	90,983	-	1,097,256
Хөрөнгө оруулалт -борлуулахад бэлэн	490	1,084,291	-	2,594	1,087,375
Хөрөнгө оруулалт -дуусах хугацаа хүртэл нь эзэмших	-	72,702	-	-	72,702
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	-	491,280	-	-	491,280
Засгийн газрын үнэт цаас	53,044	-	-	-	53,044
Дотоодын банкуудад олгосон зээл	130,391	-	-	-	130,391
Нийт санхүүгийн хөрөнгө	198,534	2,654,546	90,983	2,594	2,946,657
Өр төлбөр					
Гүйлгээн дэх бэлэн мөнгө	519,692	-	-	-	519,692
Төв банкны үнэт цаас	1,100,997	-	-	-	1,100,997
